

АМНАТ-ийн зохицуулалтын олон улсын ба дотоодын туршлагын судалгаа

З. Манлайбаатар
Т. Дөлгөөн
Д. Өнөржаргал
Д. Оюунтөгс
У. Энхсайхан

Эдийн засгийн судалгаа, эрдэм шинжилгээний хүрээлэн (ЭЗСЭШХ)

Хураангуй

Энэ судалгааг “Монгол нүүрс ассоциаци”-ийн захиалгаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам болон нүүрс экспортлогч компаниудын дэмжлэгтэйгээр хийж гүйцэтгэв. Ковид-19 цар тахлын хүндрэлтэй зэрэгцэн ЗГ-ын 2021 оны 174-р тогтоолоор экспортын нүүрсний ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр (АМНАТ) ногдуулах борлуулалтын үнэлгээг жишиг үнэд суурилан тооцох болсноос үүдэн нүүрс экспортлогчид хэт өндөр АМНАТ төлөх асуудал үүссэн. Үүнтэй холбоотойгоор энэ судалгаанд уул уурхайн салбарт АМНАТ ногдуулах олон улсын ба дотоодын туршлагыг харьцуулж, АМНАТ-ийн зохицуулалттай холбоотой үүсээд байгаа асуудлыг нарийвчлан судалж, санал зөвлөмж дэвшүүлэхийг зорьсон.

АМНАТ-ийн зохицуулалтын талаарх олон улсын туршлагыг Австрали, Индонези, ОХУ, БНХАУ-ын жишээн дээр авч үзсэн. Харин АМНАТ-ийн зохицуулалтын дотоодын туршлагыг уул уурхайн салбарын тоон мэдээлэл, бодлогын болон судалгааны баримт бичгийн хүрээнд шинжилж, АМНАТ ногдуулах борлуулалтын үнэлгээг жишиг үнэд суурилан тооцох аргачлалтай холбоотой асуудлыг нарийвчлан судалсан.

Түлхүүр үгс:

Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр(АМНАТ), нүүрсний экспорт, жишиг үнэ, борлуулалтын үнэлгээ, уул уурхайн татвар, Монгол, ОХУ, Индонези, Австрали, БНХАУ.

Улаанбаатар, Монгол

2022



АМНАТ-ИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ОЛОН УЛСЫН БА ДОТООДЫН ТУРШЛАГЫН СУДАЛГАА

**УЛААНБААТАР ХОТ
2022 ОНЫ 3-Р САР**

ГАРЧИГ

Оршил	5
1. Уул уурхайн салбарын татвар, АМНАТ-ийн талаарх үндсэн ойлголт, зарчмууд	6
1.1. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр буюу роялти.....	6
1.2. Бусад татвар.....	9
1.3. АМНАТ, бусад татвартай холбоотой зайлшгүй анхаарах зүйлс	11
2. Сонгосон орнууд дахь АМНАТ-ийн зохицуулалтын туршлага	13
2.1. Австралийн АМНАТ-ийн зохицуулалт	14
2.2. Индонезийн АМНАТ-ийн зохицуулалт.....	22
2.3. Оросын Холбооны Улсын АМНАТ-ийн зохицуулалт	33
2.4. Бүгд Найрамдах Хятад Ард Улсын АМНАТ-ийн тогтолцоо.....	39
3. Монголын улсын АМНАТ-ийн зохицуулалтын туршлага: Нүүрсний салбар.....	47
3.1. Монголын эдийн засаг ба нүүрсний салбар	47
3.2. Монгол дахь АМНАТ-ийн зохицуулалт.....	49
3.3. Нүүрсний борлуулалтын үнэ ба жишиг үнийн зөрүү.....	52
3.4. Жишиг үнийг тооцох аргачлал	56
3.5. Ашигт малтмал борлуулах үнэд үзүүлж буй тээвэр, логистик, дэд бүтцийн нөлөөлөл ...	60
3.6. Нүүрс экспортлогчдод ногдож буй татварын ачаалал	62
4. Дүгнэлт ба санал зөвлөмж.....	66
4.1. АМНАТ-ийн зохимжтой хувь хэмжээ, татварын бодлого	66
4.2. Нүүрсний жишиг үнэ тооцох аргачлал.....	68
4.3. Санал, зөвлөмж	70
Судалгаанд ашигласан эх сурвалж.....	72
Харьцуулсан судалгаанд ашигласан эх сурвалжууд	72

Зургийн жагсаалт

Зураг 1. Хөгжиж буй орнуудын уул уурхайн компаниудын төлсөн татварын бүтэц	8
Зураг 2. Австралийн коксжих нүүрсний экспорт 2020, түнш орнуудаар	14
Зураг 3. Австралийн коксжих нүүрсний экспорт.....	15
Зураг 4. Коксжих нүүрсний гаалийн дундаж үнэ, австрали доллар/тонн	15
Зураг 5. Австралийн эрчим хүчний нүүрсний экспорт	16
Зураг 6. Австралийн эрчим хүчний нүүрсний гаалийн дундаж үнэ, австрали доллар/тонн	16
Зураг 7. Японы санхүүгийн жилийн гэрээний үнэ (JFY) болон Ньюкасл дахь эрчим хүчний нүүрсний үнэ, ам.доллар/тонн	20
Зураг 8. Индонезийн эдийн засагт уул уурхайн салбарын үзүүлэх нөлөө	22
Зураг 9. Индонезийн нүүрсний экспорт, түнш орнуудаар, сая тонн	23
Зураг 10. Жишиг үнийн тооцоолол.....	26
Зураг 11. Нүүрсний суурь үнэ (HBA), \$/тонн	26
Зураг 12. ОХУ-ын нүүрсний үйлдвэрлэл, сая тонн.....	33
Зураг 13. ОХУ-ын нүүрсний экспорт, улсаар/зүүн/, нийт /баруун/, сая тонн	33
Зураг 14. ОХУ-ын нүүрсний экспортын нийт экспортод эзлэх хувь.....	34
Зураг 15. ОХУ-ын экспортолсон нүүрсний дундаж үнэ, ам.доллар/тонн.....	34
Зураг 16. Байгалийн баялгийн рент, 2020 он.....	47
Зураг 17. Нүүрсний рент ДНБ-д эзлэх хувь	47
Зураг 18. Нүүрсний олборлолт экспорт, улирлаар мян.тн.....	48
Зураг 19. Нүүрсний экспорт ба эдийн засгийн өсөлт	48
Зураг 20. Жишиг үнэ болон гэрээний үнийн зөрүү, мянган төгрөг	53
Зураг 21. Сул коксжих нүүрс, мянган төгрөг/тонн.....	55
Зураг 22. Баяжуулсан коксжих нүүрс, мян төгрөг/тонн	55
Зураг 23. Боловсруулаагүй коксжих нүүрс, мянган төгрөг/тонн	55
Зураг 24. Антрацит, мянган төгрөг/тонн	56
Зураг 25. Эрчим хүчний нүүрс, мянган төгрөг/тонн	56
Зураг 26. Баяжуулсан коксжих нүүрсний жишиг үнэ болон sxcoal-ийн үнийн харьцуулалт	57
Зураг 27. Боловсруулаагүй сул коксжих нүүрсний жишиг үнэ болон Сэхэ дэх үнийн харьцуулалт	57
Зураг 28. Нүүрсний борлуулалтын орлогод ногдох АМНАТ-ийн хувь хэмжээ.....	62
Зураг 29. Компаниудын үүрсэн АМНАТ-ийн ачаалал, 2021 оны сүүлийн хагас	64
Зураг 30. Монгол Улсын зарим татварын хувь хэмжээ (%), 2000-2021 он	64
Зураг 31. Хөрөнгийн нийт хуримтлал, 2015 оны үнээр, тэрбум төгрөг.....	65

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Сонгосон орнуудын АМНАТ-ийн товч харьцуулалт	13
Хүснэгт 2. Австралийн АМНАТ-ийн орлогын нийт татварын болон уул уурхайн салбарын татварын орлогод эзлэх хувь	15
Хүснэгт 3. Австралийн бүс нутгуудад мөрддөг уул уурхайн салбарын хууль тогтоомжууд	16
Хүснэгт 4. Австралийн бүс нутгуудад мөрдөгддөг АМНАТ-ийн хувь, хэмжээ	17
Хүснэгт 5. АМНАТ-ийн хууль журмууд	23
Хүснэгт 6. Индонезийн нүүрсний АМНАТ-ийн түвшин, борлуулалтын орлогод ногдуулах хувь	25
Хүснэгт 7. Индонезийн нүүрсний ангилал	27
Хүснэгт 8. Экспортын татвар, бүтээгдэхүүнээр, цэвэршүүлэх байгууламжийн хөгжлөөр.....	29
Хүснэгт 9. ОХУ-ын нүүрсний АМНАТ, нүүрсний төрлөөр.....	36
Хүснэгт 10. ОХУ-ын бусад ашигт малтмалуудын АМНАТ	37
Хүснэгт 11. ОХУ-ын нүүрсний компаниудын төлдөг бусад төрлийн татварууд	38
Хүснэгт 12. Хятадын нийт нүүрсний олборлолт ба дундаж үнэ	39
Хүснэгт 13. БНХАУ-ын мужуудын нүүрс олборлолт сая тн.....	39
Хүснэгт 14. БНХАУ-ын нөөцийн татварын хуулийн шинэчлэл	43
Хүснэгт 15. БНХАУ-ын нөөцийн татварын хувь хэмжээ.....	44
Хүснэгт 16. Монгол эдийн засгийн өсөлтийн таамаглалууд, %	48
Хүснэгт 17. АМНАТ-ын түвшин	49
Хүснэгт 18. Нүүрсний жишиг үнийн эх сурвалж, АМНАТ ногдуулах борлуулалтын үнэлгээний талаарх журам	51
Хүснэгт 19. Жишиг үнэ тооцдог нүүрсний ангилал	52
Хүснэгт 20. Нүүрсний чанарын үзүүлэлтүүдийн үнэд үзүүлж буй нөлөө, \$/тн	59
Хүснэгт 21. Цагаан хад – Ганцмод нүүрс тээвэрлэх зардал, 2021 оны дунджаар, юань/тонн .	61
Хүснэгт 22. Нарийн сухайт – Сэхэ нүүрс тээвэрлэх зардал, 2021 оны дунджаар, юань/тонн .	61

Оршил

Энэхүү судалгаа нь уул уурхайн салбарт ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр (АМНАТ) ногдуулах олон улсын ба дотоодын туршлагыг харьцуулах, тэр дундаа нүүрсний олборлолт, экспортод ногдуулах АМНАТ-ийн зохицуулалттай холбоотой асуудлыг нарийвчлан судлах, санал зөвлөмж дэвшүүлэх зорилготой. Судалгааг хийх болсон гол шалтгаан нь 2021 оны 6-р сард батлагдсан Засгийн газрын 174-р тогтоолоор экспортын нүүрсний АМНАТ ногдуулах борлуулалтын үнэлгээг жишиг үнэд суурилан тооцох болсноос үүдэн нүүрс экспортлогчид хэт өндөр АМНАТ төлөх нөхцөл байдал үүссэнтэй холбоотой. Ер нь АМНАТ-ийн хэмжээ огцом өссөн. манай улсад хэрэгжүүлж буй АМНАТ-ийн зохицуулалт нүүрсний салбарын онцлог, зах зээлийн нөхцөл байдлаас хамааран олон удаа өөрчлөгдөж ирсэн байдаг. Гэвч Засгийн газрын энэ удаагийн шийдвэр Ковид-19 цар тахлын нөлөөгөөр нүүрсний салбарын компаниуд үйл ажиллагааны болон санхүүгийн бэрхшээлтэй тулгарсан, хил нэвтрэх үйл ажиллагаа удааширснаас үүдэн нүүрсний экспортын тээврийн зардал огцом өссөн үетэй давхацсан нь байдлыг улам хүндрүүлсэн. Иймээс үүссэн нөхцөл байдлын шалтгааныг нарийвчлан судлах, үүнд нөлөөлж буй төрөл бүрийн хүчин зүйлсийг тодруулах шаардлагатай юм.

Энэ судалгааны хүрээнд уул уурхайн салбарын татвартай холбоотой үндсэн ойлголт, зарчмуудыг тоймлон нэгтгэсэн үр дүнг тайлангийн эхний бүлэгт танилцууллаа. Тайлангийн 2-р бүлэгт АМНАТ-ийн зохицуулалтын талаарх олон улсын туршлагыг Австрали, Индонези, ОХУ, БНХАУ гэсэн дөрвөн улсын жишээн дээр тодруулж авч үзлээ. Эдгээр улс нь коксжих болон эрчим хүчний нүүрсний экспортоор дэлхийд тэргүүлэгч, манай улсын нүүрсний салбарын гол өрсөлдөгчид болон гол хэрэглэгч орнууд юм. Тайлангийн 3-р бүлэгт АМНАТ-ийн зохицуулалтын дотоодын туршлагыг уул уурхайн салбарын тоо мэдээлэл, баримт бичгийн хүрээнд судалж, АМНАТ ногдуулах борлуулалтын үнэлгээг жишиг үнэд суурилан тооцох аргачлалтай холбоотой асуудлыг нарийвчлан танилцууллаа. Судалгааны үр дүнд үндэслэсэн дүгнэлт, гол санал зөвлөмжийг тайлангийн 4-р бүлэгт дэвшүүллээ.

Энэ судалгааг Монгол нүүрс ассоциацийн захиалгаар Эдийн засгийн судалгаа, эрдэм шинжилгээний хүрээлэнгийн судлаачид гүйцэтгэв.

Судалгаанд Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Ашигт малтмал газрын тосны газар зэрэг төрийн байгууллагын мэргэжилтнүүд, Монголын Алт МАК, МоЭнКо, Өсөх зоос, Саус Гоби Сэндс, Энержи Ресурс, Эрдэнэс Таван Толгой зэрэг компаниудын төлөөлөл, салбарын зарим эксперт оролцож тоон мэдээлэл, санал дүгнэлтээ хуваалцсан.

1. Уул уурхайн салбарын татвар, АМНАТ-ийн талаарх үндсэн ойлголт, зарчмууд

Уул уурхайн төслөөс засгийн газрын хүртэх үр өгөөж нь татварын орлого болон ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр (роялти)-өөс бүрддэг.

1.1. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр буюу роялти

Эрдэс баялаг газар дор байхдаа ихэвчлэн улсын өмч байдаг. Мөн эрдэс баялаг бол нөхөн сэргээгдэхгүй нөөц бөгөөд өнөө үеийнхэн олборлож ашиглавал ирээдүй үеийнхэн уг нөөцийг ашиглах боломжгүй болно. Тийм учраас энэ чухал нөөцийг ашиглаж буй уул уурхайн компаниуд бизнесийн нийтлэг татваруудаас гадна засгийн газарт, эсвэл орон нутгийн захиргаанд нэмэлт нөхөн төлбөр өгөх ёстой. Үүнийг ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр (АМНАТ) буюу роялти гэдэг. АМНАТ тооцох хэд хэдэн хувилбар байдаг.

Олборлосон эрдэс бүтээгдэхүүний үнийн дүн буюу нийт орлогод суурилсан роялтиг ихэнх улс тогтоодог. Жишээлбэл, нүүрсний үнэ нэг тонн нь 100 ам.доллар бөгөөд тухайн улсад экспортын нүүрсний АМНАТ 5% гэвэл нүүрс олборлогч нь экспортолсон нүүрсний тонн тутамд 5 ам.доллар төлнө. Олборлолтын зардал болон ашгаас үл хамаарна. Нүүрсний үнэ өсвөл төлөх АМНАТ-ий хэмжээ ижил хувиар өснө. АМНАТ-ийн хувь хэмжээнээс гадна ямар үнийг баримтлах вэ гэдэг нь чухал асуудал юм. АМНАТ тооцохдоо тухайн эрдэс бүтээгдэхүүний дэлхийн зах зээлийн жишиг үнэ баримтлах нь хамгийн хялбар арга. Гэхдээ зарим түүхий эд, жишээ нь түүхий нүүрсний хувьд биржээр арилжаалагдахгүй бараа гэж үздэг тул аль нэг биржийн үнэ баримтлахад хэцүү байдаг. Иймээс борлуулалтын гэрээнд суурилах уу, эсвэл ямар нэг аргаар тооцоолсон жишиг үнэд суурилах уу гэсэн асуудал үүсдэг. Мөн АМНАТ тооцох суурь үнийг уурхайн аман дээрх үнээр үү, эсвэл хил дээрх үнээр тооцох уу гэдэг нь их ялгаатай. Ялангуяа тээврийн зардал ихтэй улсад энэ ялгаа маш том нөлөө үзүүлнэ. Энэ судалгаанд анхаарал хандуулах гол асуудал нь энэхүү жишиг үнэтэй холбоотой асуудлууд юм. Иймээс тайлангийн бусад хэсгүүдэд энэ талаар дэлгэрэнгүй авч үзнэ.

Хэрвээ компани олборлосон ашигт малтмалаа боловсруулж худалдсан бол боловсруулахад гарсан нэмэлт зардлыг нь хасаж төлбөр ноогдуулдаг, эсвэл боловсруулсан бүтээгдэхүүний үнэд нь арай бага хувиар роялти тогтоох жишиг олон улсад бий. Энэ төрлийн роялти нь тооцоход харьцангуй хялбар боловч бас сул талтай. Тухайлбал, олборлогч компани хамаарал бүхий салбар компанид бүтээгдэхүүнээ хямдаар борлуулах тохиолдолд засгийн газрын авбал зохих роялти төлбөр багасдаг.

Хэдий түгээмэл биш ч, роялти тооцох өөр хувилбарууд нэлээд олон оронд мөрдөгддөг. Түүний нэг нь тухайн төслийн ашгийн түвшинд суурилсан роялти. Ашиг өсвөл роялти төлбөр өснө, харин ашиг олоогүй бол роялти төлөхгүй. Иймээс энэ бол компанид илүү тааламжтай хувилбар юм. Ашигт суурилсан роялтигийн хувь борлуулалтын орлогод суурилсан роялтигийн хувиас илүү өндөр тогтоогддог. Мөн бүтээгдэхүүний биет хэмжээнд суурилсан роялти гэж бий. Энэ нь олборлосон нэгж бүтээгдэхүүнд тогтмол дүнтэй ноогдуулах төлбөр юм. Жишээлбэл, олборлосон нүүрсний 1 тонн тутамд 1 ам.долларын роялти тогтоох.

Дэлхийн улсууд уул уурхайн салбарт хандах хандлага, ашигт малтмалын төрлөөс хамаараад роялтиг олон янзаар тогтоосон байдаг. АНУ-ын Невада, Аризона мужуудад ихэнх ашигт малтмалд роялти төлбөр авдаггүй. Канадын Саскачеван муж үнэт болон суурь металлын төслүүдийг эхний 10 жил роялтигаас чөлөөлж, түүнээс цааш төслийн цэвэр ашгаас 5%-ийн

роялти төлбөр авдаг. Японд уул уурхайн салбар маш бага хувь эзэлдэг ба тус салбарыг дэмжих үүднээс роялтиг борлуулалтын үнийн 1% гэж тогтоож, төлбөрийг орон нутгийн захиргаанд төлдөг.

Чили, Перу зэрэг улс уул уурхайн салбарт гадаадын хөрөнгө оруулалт татахын тулд компанийн ашигт суурилсан роялти тогтоодог. Чилид роялтигийн түвшин ашгаас хамаараад 5–14% байдаг бол Перуд мөн ашгаас хамаараад 1–6.28% байдаг¹. Харин Лаост роялтиг нийт орлогод ноогдуулах ба түүхий эдээс хамаарч 1–7 % байхаар тогтоосон байдаг. Австралид металл хайлуулах салбарыг дэмжихийн тулд боловсруулалтын түвшин гүнзгийрэх тусам роялтигийн хувийг бууруулж авдаг. Тухайлбал, Баруун Австралид хүдрийн борлуулалтын орлогод 7.5%, баяжмалын борлуулалтын орлогод 5.0%, металлын борлуулалтын орлогод 2.5%-аар роялти ноогдуулж, мужийн захиргаа төлбөрийг авдаг.

Монголд түүхий эдийн үнийн гэнэтийн ашгаас хүртэх өгөөжийг нэмэгдүүлэх, түүхий эдийн боловсруулалтыг дэмжих зорилгоор Ашигт малтмалын хуулиар бүтээгдэхүүний үнэ ба боловсруулалтын түвшнээс хамаарч роялтигийн үндсэн хувь дээр нэмэгдэх хувийг түүхий эдийн төрөл бүр дээр тусгайлан тогтоосон. Тухайлбал, зэсийн суурь роялти 5% байх ба Лондоны металлын бирж дээрх цэвэр зэсийн тонн тутмын үнэ 5000 ам.доллараас давбал роялтигийн хувь нэмэгдэнэ. Зэсийн үнэ 5000-6000 ам.доллар байвал зэсийн хүдэрт 22%, зэсийн баяжмалд 11%, цэвэр зэсэд 1% нэмж тооцно. Харин зэсийн үнэ 6000-7000 ам.доллар байвал хүдэрт 24%, баяжмалд 12%, цэвэр зэсэд 2% нэмэх гэх мэтчилэн өссөөр, зэсийн үнэ 9000 ам.доллараас давбал хүдэрт 30%, баяжмалд 15%, цэвэр зэсэд 5%-ийг нэмж тооцно.

Гэхдээ хөрөнгө оруулалтын гэрээнд талууд роялтийг тусгайлан тохирч болно. Жишээ нь, Монголын хоёр гол зэсийн уурхайн нэг болох Оюу Толгой төслийн гэрээ байгуулах 2009 оны үеийн хуульд роялти нь үнэ ба боловсруулалтын түвшнээс үл хамааран тогтмол 5% байсан тул талууд энэ хувиар роялти төлөхөөр тогтворжуулсан байдаг². Иймээс Ашигт малтмалын хуульд 2010 оны 11 сард шинээр орсон, дээр дурдсан өсөн нэмэгдэх роялти ногдуулах заалт уг төсөлд хамаарахгүй².

Үүнтэй харьцуулахад, Афганистаны Кара-Заган алтны уурхайн гэрээнд роялтигийн хувийг нэлээд өндөр байхаар тохирсон байдаг. Тухайлбал, уг гэрээнд олборлолтын үйл ажиллагаа эхэлсний дараа олборлогч компани сар бүр Уул уурхайн яамандаа алтны борлуулалтын нийт орлогын 26%-аар роялти төлөх, үнийг нь алт борлуулсан өдрийн Лондоны Металлын Биржийн ханшаар тооцно гэж заажээ³.

Гэхдээ тухайн нэг уурхайн амьдралын мөчлөг буюу олборлолт эхлэхээс дуусах хүртэлх хугацааны туршид төсөвт төлөх нийт орлогод АМНАТ нь ААНОАТ-аас бага байх учиртай. Олон Улсын Валютын Сан тухайн нэг уурхайгаас олборлолтын нийт хугацаанд олох засгийн газрын орлогыг тооцох онолын загвар (FARI⁴) боловсруулсан байдаг. Уг загварт, АМНАТ 5%, ААНОАТ 30%, төрийн өмчийн оролцоо 10% байх нөхцөлд уул уурхайн салбараас улсын төсөвт төвлөрүүлэх нийт татварын орлогын 52% нь ААНОАТ, 20% нь АМНАТ, 16% нь ногдол ашгийн суутган татвар, 12% нь төрийн өмчид ногдох ашиг байх онолын тооцоо гарсан байдаг.

¹ Review of the Legal/Fiscal Framework of Resource Countries, Shuichi Miyatake, 2018

² Монгол Улсын Засгийн газар болон Айвенхоу Майнз Лимитед, Рио Тинто Интернэшнл Холдингс Лимитед компани хоорондын Хөрөнгө оруулалтын гэрээ, 2009 он (хуудас 12)


³ Qara Zaghan Gold Project Contract between Afghan Krystal Natural Resources Company and the Ministry of Mines of the Islamic Republic of Afghanistan, 2011 (page 9).

⁴ IMF 2016, *Fiscal Analysis of Resource Industries (FARI) Methodology*

Гэхдээ 2010-аад оноос хойш дэлхий дахинд АМНАТ-ийн хувь хэмжээ нэмэгдэх хандлагатай болжээ. БНХАУ 2011 оны 11-р сард нөөцийн татвар шинээр ногдуулж эхэлсэн. Индонез улс 2009 онд нүүрсэнд, 2011 онд бусад ашигт малтмалд АМНАТ тооцох жишиг үнийн аргачлалыг нэвтрүүлсэн бөгөөд энэ нь АМНАТ-ийн суурийг нь тэлсэн гэж үздэг байна. Танзани улс 2010 онд Ашигт малтмалын хууль батлахдаа АМНАТ тооцох сууриа цэвэр ашгаас борлуулалтын орлого болгож өөрчилсөн бол хувь хэмжээгээ 3%-аас 4% болгож өөрчилсөн⁵. Мексик улс АМНАТ ногдуулдаггүй байсан бол 2014 оноос борлуулалтын орлогод 7.5%-ийн төлбөр ногдуулж эхэлсэн⁶.

Европын Холбоо болон Канадын биржид бүртгэлтэй, хөгжиж буй орны компаниудын төлсөн татвар, АМНАТ-ын мэдээллийг resourceprojects.org цахим хуудас нээлттэй болгосон бөгөөд доорх зурагт нийт татварын орлогод АМНАТ болон бусад татварын эзлэх хувийг 2015-2018 оны дунджаар харуулав. Энэ тоон өгөгдөл нь тухайн улсын нийт татварын орлогын бүтцийг бүрэн илэрхийлэхгүй боловч ерөнхий дүр зургийг харж болно. Тухайлбал, зургийн зүүн гар талд байгаа улсуудад нийт татварын орлогод АМНАТ-ийн эзлэх хувь (улбар шар) өндөр байна. Үүнд, АМНАТ-ийн хувь хэмжээ өндөр, бусад татварын хувь хэмжээ бага, эсвэл компаниудаас орлогын татвараа авч эхлээгүй, эсвэл авч чадахгүй байгаа зэрэгтэй холбоотой байж болно. Орлогын татвар болон АМНАТ аль аль нь түүхий эдийн тоо хэмжээ, чанар, өртгийн зөв зохистой үнэлгээнээс хамаардаг.

Зураг 1. Хөгжиж буй орнуудын уул уурхайн компаниудын төлсөн татварын бүтэц



Эх сурвалж NRG 2019⁷

Ашигт суурилсан татвар цуглуулахад хэцүү байдаг тул хөгжиж буй орны засгийн газрууд бүтээгдэхүүнд буюу борлуулалтад суурилсан татвар, АМНАТ-ыг нэмэх сонирхолтой байдаг. Энд Ардчилсан Конго, Индонез, Замби зэрэг улсын сүүлийн үеийн жишээг дурдаж болно. Ардчилсан Конго улсын засгийн газар 2018 онд зай хураагуурын гол түүхий эд болох кобальтыг

⁵ PwC (2012), Global Mining Industry Update

⁶ KPMG Global Mining Institute (2016), Mexico Country Mining Guide

⁷ NRG 2019, As Mining Enters the Renewables Era, Taxation Challenges Persist

стратегийн бүтээгдэхүүн гэж үзэн АМНАТ-ийг 3.5% байсныг 10% болгож нэмэгдүүлэх шийдвэр гаргажээ. Гэвч 2019 онд кобальтын үнийн бууралт болон өндөр татварын улмаас тус улсад олборлолт явуулж байсан Гленкор компанийн кобальтын уурхай хаагджээ. Индонезийн засгийн газар 2017 онд газрын тос, байгалийн хийн бүтээгдэхүүн хуваах хувийг зардлыг хассан “ашигт газрын тос”-ноос биш, нийт олборлосон газрын тосноос тооцох шийдвэр гаргасан. Зэсийн экспортоос хүчтэй хамаардаг Замби улс АМНАТ-ийн татварыг 2001-2015 оны хооронд 9 удаа өөрчилж байжээ. Тухайлбал, 2015 оны 4-р сард улсын төсвийн алдагдал нэмэгдсэн тул тус улсын засгийн газар зэсийн ил уурхайн АМНАТ-ийг борлуулалтад суурилснаар 20%, далд уурхайд 8% болгож өсгөх шийдвэр гаргасан. Гэвч салбарынхны эсэргүүцэл болон ОУВС-ийн шүүмжлэлээр, 2015 оны 6-р сард ил ба далд уурхайд 9% байхаар өөрчилсөн. Хамгийн сүүлд Замбийн засгийн газар 2018 онд улсын төсвийн алдагдал, улсын өрийн дарамтыг бууруулахын тулд 4-6% байсан АМНАТ-ийг 1.5 нэг хувиар өсгөж, зэсийн үнийн 7500 ам.доллараас давсан үнэд 10%-ийн татвар нэмж ногдуулах гэнэтийн орлогын шинэ татвар оруулж иржээ.

1.2. Бусад татвар

Төрийн санхүү талаас АМНАТ нь тухайн төслийн үр өгөөжийг эртнээс, борлуулалт эхэлсэн үеэс шууд авдаг, уурхайн үйл ажиллагааны туршид урьдчилж таамаглаж болохуйц орлогыг төсөвт өгдгөөрөө давуу талтай. Иймээс хөгжиж буй орнуудын төсвийн орлого ААНОАТ гэхээсээ АМНАТ-аас илүү хамаардаг. Төрийн өмчийн компаниудын ногдол ашиг өөр нэг чухал эх сурвалж боловч тогтмол биш, найдваргүй орлогын эх үүсвэр гэж үздэг⁸.

Уул уурхайн төслөөс засгийн газар өгөөж хүртэх өөр нэг гол суваг нь компанийн ашгийн татвар (аж ахуйн нэгжийн орлогын татвар) болон уул уурхайн онцлог татварууд юм. Уул уурхайн компаниуд бизнесийн бусад салбартай адил ашгаасаа татвар төлөх ёстой. Уул уурхайн төслүүдэд ноогдуулдаг компанийн ашгийн татварын түвшин сүүлийн жилүүдэд дэлхий дахинд буурах хандлагатай байгаа бөгөөд ерөнхийдөө 25–35% байдаг. Жишээлбэл, Чилид татварын дээд хувь 18.5%, Казакстанд 20%, Хятад болон Индонезид 25%, Канадад улсын татвар 15%, мужийн татвар 10-16%, Өмнөд Африкт 28%, Австрали, Перу, Танзанид 30%, Бразилд 34% байдаг⁹. Гэхдээ зарим орон уул уурхайн салбарыг дэмжихийн тулд оруулсан хөрөнгөө нөхөх боломж олгох зорилгоор татварын хөнгөлөлт үзүүлдэг бол зарим орны хуульд өндөр ашиг олсон үед татвар нэмж авах зохицуулалт байдаг.

Компанийн ашгийн татвар ноогдуулахдаа нийт орлогоос үйл ажиллагааны зардал, төлсөн роялти, импортын татвар, урьдчилгаа төлбөр зэргийг хасдаг. Мөн уурхайд анх оруулсан их хэмжээний хөрөнгө оруулалтаа нөхөх боломж олгох үүднээс хөрөнгийн зардлыг олон жил бага багаар цувуулж төлөх элэгдлийн шимтгэлийг татвар ноогдуулах орлогоос хасдаг. Гэхдээ засгийн газрын бодлогоос хамаараад уул уурхайн төслийн хөрөнгийн ашиглалтын хугацаа, элэгдүүлэх хурдыг хэрхэн тогтоож, төслийн эхэн үед компаниудын татварын ачааллыг бууруулах эсэх нь ялгаатай байдаг. Жишээ нь Австрали улс хөрөнгийн элэгдлийг тогтмол хурдтай тооцох хуультай боловч ашигт малтмал, газрын тосны хайгуул болон нөхөн сэргээлтийн үйл ажиллагааг урамшуулахын тулд хөрөнгө оруулалтыг нь хурдан элэгдүүлэх (150%) тусгай бодлоготой¹⁰. Канад улс олборлолт эхлэхээс өмнө, эсвэл томоохон өргөтгөлийн үеэр авсан барилга, машин тоног төхөөрөмжид мөн хурдан элэгдүүлэх (100%) заалтыг татварын хуульд тусгасан байдаг.

⁸ IGF 2020, *The Future of Resource Taxation: Roadmap*

⁹ PwC 2012, *Corporate income taxes, mining royalties and other mining taxes*,

¹⁰ *Guide to Depreciating Assets*, Australian Tax Office, 2014

Уул уурхайн төслүүдэд хамаатай өөр нэг чухал асуудал бол компанийн алдагдлыг ирээдүйд шилжүүлэх явдал юм. Уул уурхайн төслүүд олборлолт эхлэхээс өмнө их хэмжээний хөрөнгө оруулалт хийдэг учраас эхний жилүүдэд алдагдалтай ажиллах нь нийтлэг байдаг. Иймээс татварын хуульд уг алдагдлаа хожим ашигтай ажиллах жилийнхээ орлогоос нөхөх боломжийг бизнесүүдэд олгон, алдагдлыг дараа жилүүдийн татвар ноогдох орлогоос нь хасдаг. Алдагдал их байвал дараагийн хэд хэдэн жилийн татварыг ч бууруулж болно. Улс орнуудад алдагдлыг шилжүүлэх жилийн тоо нь ихэвчлэн дараалсан 5-7 жил, эсвэл 10 хүртэлх жил байдаг. Жишээлбэл, Индонезид 5 жил, Казакстан, Мексик, ОХУ-д 10 жил хүртэлх хугацаагаар алдагдлыг шилжүүлж тооцдог¹¹. Зарим тохиолдолд алдагдлыг бүрэн нөхөх хүртэл хязгааргүй хугацаагаар шилжүүлэх нь ч бий¹². Монголд компанийн алдагдлыг шилжүүлэх хугацаа 4-8 жил байдаг ба Оюу Толгой төслийн гэрээнд энэ хугацааг 8 жил гэж заасан.

Уул уурхайн салбарын гэрээнүүдэд байдаг нийтлэг зохицуулалт бол “ring fencing” юм. Энэ нь компанийн ашигт татвар ноогдуулах зорилгоор тухайн компанийн уул уурхайн нэг төслөөс орох орлого, хасагдах зардлуудыг өөр нэг төслийн орлого, зарлагаас бүрэн тусгаарлах тухай зохицуулалт. Энэ нь компанийг өөр газар хайгуул хийж, шинэ уурхай эхлүүлэхэд ашгаа шилжүүлэх боломжийг хааж, засгийн газрыг аж ахуйн нэгжийн орлогын татвараа аль болох ойрын хугацаанд цуглуулах боломж олгодог. Мөн тухайн оронд шинэ уул уурхайн компаниуд орж ирэн, төслөө эхлүүлэх нөхцөл бүрдүүлдэг.

Уул уурхайн салбарт нөлөөлөх нэг чухал татвар бол суутган татвар (withholding tax) юм. Уул уурхайн компаниудын зээлдүүлэгчдэдээ төлж буй хүү, эздэдээ төлж буй ногдол ашиг, туслан гүйцэтгэгч, үйлчилгээ үзүүлэгч болон зөвлөхүүдэдээ төлж буй төлбөрт суутган татвар ноогдуулдаг. Энэ нь тэдгээр төлбөрийг хүлээж авагчдын орлогоос авах татварыг шилжүүлж буй этгээдээс суутгаж буй хэрэг юм. Хэрэв суутган татвар тогтоохгүй бол тухайн уурхайн орлогын зарим хэсэг буюу туслан гүйцэтгэгчид, үйлчилгээ үзүүлэгчдийн олсон орлого, ашигт татвар ноогдуулахгүй өнгөрнө. Улс хоорондын давхар татварын хэлэлцээрүүдэд суутган татварыг хязгаарлах нөхцөлүүд заасан байдаг. Компани болон засгийн газрын хооронд байгуулах гэрээнд уг татварыг чөлөөлөх, тогтворжуулах, эсвэл өндрөөр тогтоох нөхцөл тохирч болно. Олон улсад энэ татвар ерөнхийдөө 5–10% байдаг. Жишээлбэл, Либерийн засгийн газар болон Чайна Юнион компанийн хооронд байгуулсан гэрээнд эхний 12 жилд ноогдол ашигт 0%, зээлийн хүүд 5%, үйлчилгээний төлбөрт 5% суутган татвар тус тус төлөхөөр тусгажээ¹³.

Дээр дурдсан татваруудаас гадна нэмэгдсэн өртгийн албан татвар (НӨАТ), импортын татвар, түүхий эдийн экспортын татвар, орон нутгийн татвар, газрын буюу лицензийн төлбөр, бусад хураамж гэх мэт олон төрлийн татвар хураамжийг компани төлдөг. Мөн манай улсын нүүрс олборлогчид олборлосон нүүрсний кг тутамд 1-2 төгрөгийн агаарын бохирдлын төлбөр нэмж төлдөг.

Эцэст нь, газрын тос, байгалийн хий олборлох гэрээнд ихэвчлэн тусдаг татварын төрлүүд бол бүтээгдэхүүн хуваах болон нөөцийн рентийн татвар юм. Бүтээгдэхүүн хуваах гэрээний тухайд, компани олборлолтын бүх зардлаа хариуцна. Тухайн сарын олборлолтоос өртөг нөхөгдөх зардал буюу өртөгт газрын тосыг хасаад үлдэх “ашигт газрын тос”-ыг компани ба засгийн газар гэрээнд заасны дагуу хувааж авдаг. Харин нөөцийн рентийн татвар нь төслийн эдийн засгийн рент буюу компанийн хэвийн ашгаас давсан “эдийн засгийн ашиг”-т тодорхой хувиар тогтоосон татвар юм.

¹¹ Corporate income taxes, mining royalties and other mining taxes, PwC, 2012

¹² *Mining Contracts: How to Read and Understand Them*, Extractive Industry’s Transparency Initiative, 2014 (хуудас 76)

¹³ Mineral Development Agreement between the Government of the Republic of Liberia, China-Union (Hong Kong) Mining Co., Ltd. and China-Union Investment (Liberia) Bong Mines Co.,Ltd, 2009

Татварын албаны хувьд бүтээгдэхүүн хуваах хэлбэрээр засгийн газрын орлого бүрдүүлэхэд энгийн хялбар байдаг бол нөөцийн рентийн татварыг тооцож хураахад нэлээд төвөгтэй, маргаан их гардаг¹⁴. Монголын Засгийн газар газрын тосны олборлолтод бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулдаг.

1.3. АМНАТ, бусад татвартай холбоотой зайлшгүй анхаарах зүйлс

Уул уурхайн салбарт АМНАТ-тэй холбоотой дараах хэдэн зүйлсийг анхаарах шаардлагатай байдаг.

1. АМНАТ-ийн түвшин ямар байх, татвар ноогдох суурийг яаж тооцох, АМНАТ ямар хэлбэртэй байх зэрэг нь тухайн улсын хуулиар зохицуулагдаж байдаг ч их хэмжээний хөрөнгө оруулалт хийж, урт хугацааны төсөл хэрэгжүүлэх аж ахуйн нэгжүүдийн хувьд **татварын орчин тогтвортой** байх нь амин чухал. Иймээс жишээлбэл гадаадын хөрөнгө оруулагчид энэ эрсдэлийг бууруулахын тулд хөрөнгө оруулалтын гэрээнд ихэвчлэн хуульд заасан татваруудыг төсөл хэрэгжих хугацаанд тогтворжуулах, эсвэл хуульд зааснаас өөр татварын түвшнийг тогтмол мөрдөхийг тусгайлан тусгадаг. Дотоодын аж ахуйн нэгжүүдийн хувьд ч мөн ийм шаардлага тавих нь зүй ёсны асуудал байдаг.
2. Дэлхий даяар уул уурхайн маш олон төслүүд хөрөнгө оруулалт татахаар, экспортын зах зээлд эзлэх байр сууриа нэмэгдүүлэхээр хоорондоо өрсөлдөж байдаг тул засгийн газар хүртэх ашгаа нэмэхийн тулд татварын түвшнийг өндөр тогтоох гэж оролдох нь сөрөг үр дагавар авчирч болзошгүй. Учир нь тухайн эрдэс баялгаас хүртэх засгийн газрын хувь ихэснэ гэдэг нь аж ахуйн нэгжүүд болон хөрөнгө оруулагчийн хүртэх өгөөж тэр хэрээр буурна гэсэн үг. Иймээс **бусад орны татвартай өрсөлдөхүйц**, гэхдээ хүртэх үр ашгаа аль болох их байлгах татварын түвшнийг хэлэлцэж тохирох нь чухал. Татварын яг ямар системийг зохистой гэж үзэх нь түүхий эдийн үнийн хэлбэлзэл, тухайн түүхий эдийн өвөрмөц онцлогоос хамаардаг.
3. АМНАТ гэх мэт тухайн нэг татварын бодлогод реформ хийхдээ **бусад төрлийн татварын ачаалал** ямар байгааг анхаарах шаардлагатай. Бусад төрлийн татварын ачаалал их байгаа байгаа үед тухайн нэг төрлийн татварын хувь хэмжээг өсгөх орон зай маш бага байдаг.
4. Түүхий эдийн **үнэ байнга хэлбэлзэхээс** гадна, зарим түүхий эдийн хувьд хил гааль, **тээвэрлэлт хязгаарлагдах, тээврийн зардал огцом өөрчлөгдөх** эрсдэл тохиолддог. Өөрөөр хэлбэл, түүхий эдийн үнийн мөчлөг болон татварын онцлогоос хамаараад тухайн үед мөрдөж буй журмаар татварын орлого хэлбэлзэх, саатах хүндрэл тохиолдож болно. Иймээс уул уурхайн салбарын онцлогийг ойлгож, **хүндрэлийн суурь шалтгааныг арилгахад** анхаарах шаардлагатай.
5. Уул уурхайн салбар, эсвэл тухайн нэг түүхий эдийн олборлолт тухайн улсын **эдийн засагт үзүүлэх нөлөө** хэр байгааг харгалзан үзэж байж хууль, журамдаа өөрчлөлт оруулах нь чухал. ДНБ, экспорт, төсвийн орлогод үзүүлэх нөлөө ихтэй салбарын үйлдвэрлэл, борлуулалтад нөлөөлөх **бодлогын шийдвэрийг маш сайн судалж, тооцож байж гаргах** хэрэгтэй. Мөн тус салбарт төр болон олон нийтийн хандлага, тус **салбарын талаар зөв ойлголт** өгөхөд анхаарах нь чухал
6. Үүнээс гадна татварын орлого, тэр дундаа уул уурхайн салбараас төвлөрүүлсэн орлогыг засгийн газар хэрхэн **үр ашигтай, үр дүнтэй зарцуулж, хуваарилж** байгаа нь зайлшгүй анхаарал хандуулах ёстой асуудал юм. Хэрвээ ашигт малтмалын нөөцийн экспортын орлогыг буруу зарцуулбал “баялгийн хараал” гэх сөрөг нөлөө үүсдэг. Иймээс түүхий

¹⁴ Mineral royalties and other mining-specific taxes, Pletro Guj, 2012

эдийн үнийн хэлбэлзлээс үүсэх эрсдэлийг бууруулахын тулд төсвийн тогтворжуулалтын сан байгуулах, “голланд өвчнөөс” сэргийлэхийн тулд сангийн хөрөнгийг гадаад улсад байршуулах, уул уурхайн баялгийг үе хооронд шударга хуваарилахын тулд хуримтлуулах, өсгөж арвижуулах, төвийн ба орон нутгийн хөгжлийн хөрөнгө оруулалтад тэнцвэртэй хуваарилах гэх мэт шийдлийг улам боловсронгуй болгох шаардлагатай юм.

2. Сонгосон орнууд дахь АМНАТ-ийн зохицуулалтын туршлага

АМНАТ-ийн зохицуулалтын талаарх олон улсын туршлагыг Австрали, Индонези, ОХУ, БНХАУ гэсэн дөрвөн улсын жишээн дээр тодруулж авч үзлээ. Эдгээр улс нь коксжих болон эрчим хүчний нүүрсний экспортоор дэлхийд тэргүүлэгч, манай улсын нүүрсний салбарын гол өрсөлдөгчид болон гол хэрэглэгч орнууд тул жишээ болгон сонгсон. Улс тус бүрийн онцлогийг дэлгэрэнгүй танилцуулахын өмнө АМНАТ-ийн харьцуулсан товч хураангуйг харуулъя.


Хүснэгт 1. Сонгосон орнуудын АМНАТ-ийн товч харьцуулалт

	Австрали	Индонези	ОХУ	БНХАУ
АМНАТ-ийн зохицуулалт	Муж, бүсийн түвшинд	Улсын түвшинд, лицензийн төрлөөс хамаарна	Улсын түвшинд	Муж, бүсийн түвшинд
АМНАТ тооцох суурь	Ихэнх мужид борлуулалтын өртөг	Борлуулалтын өртөг	Олборлосон нэгж (тн)	Борлуулалтын өртөг
АМНАТ-ийн хувь хэмжээ	Борлуулалтын өртгийн 1-15%, ашгийн 20% хүртэл, муж, үнээс хамааран ялгаатай.	2-13.5%. Лицензийн төрөл, уурхайн онцлогоос хамаарна	Коксжин нүүрснээс бусад тн. тутамд 14-47 рубль.	2-10%, мужууд өөрсдөө тогтооно. Өвөр Монголд угаасан нүүрс 9%, түүхий-10%
Борлуулалтын үнэлгээг үндэслэх үнэ	Гэрээний үнэ	Жишиг үнэ	Коксжих нүүрсэнд жишиг үнэ, бусад нүүрсэнд дефлятор	Гэрээний үнэ
Жишиг үнэ тооцох аргачлал	--	Нээлттэй. Эхлээд нүүрсний “харгалзах үнэ” (НВА)-ийг 4 төрлийн үнийн индекс ашиглан тооцно. Дараа нь НВА үнийг ашиглан нүүрсний 75 ангилал тус бүрийн жишиг үнийг тусгай томъёогоор тооцно	Нээлттэй. Коксжих нүүрсэнд Австралийн нүүрсний FOB үнийн 1.5%, бусад нүүрсэнд улирал бүр дефлятор тооцно.	--

2.1. Австралийн АМНАТ-ийн зохицуулалт

Австрали бол дэлхийн ашигт малтмалын зах зээлийн томоохон оролцогчдын нэг. 2020 онд Австралийн дотоодын нийт бүтээгдэхүүний 10 орчим хувийг уул уурхайн салбар бүрдүүлжээ. Тус салбар нь экспортод түлхүү чиглэсэн. 2020 онд Австрали 172 сая тн коксжих нүүрс экспортолсон бөгөөд энэ нь дэлхийн коксжих нүүрсний экспортын 55% юм. Үүнтэй харьцуулахад, 2020 оны Монголын коксжих нүүрсний экспорт дэлхийн экспортын 8% болно. Австралийн хүрэн нүүрсний дийлэнх хэсгийг Квинслэнд (54.5%) болон Шинэ Өмнөд Уэльс (44.5%) мужуудад олборлодог бөгөөд дийлэнх хувийг гадаад зах зээлд экспортолдог.

Зураг 2. Австралийн коксжих нүүрсний экспорт 2020, түнш орнуудаар



Эх сурвалж: Австралийн Засгийн газар

Австралийн коксжих нүүрсний 2020 оны экспортыг түнш орнуудаар авч үзвэл, Энэтхэг 32%-ийг, Япон 20%-ийг, БНСУ 12%-ийг, БНХАУ 7%-ийг тус тус бүрдүүлжээ. БНХАУ Австралид албан бус импортын хязгаарлалт тавьсан. Гэхдээ БНХАУ-ын хилийн боомтуудад саатсан Австралийн нүүрснээс 2021 оны 10-р сард 2.78 сая тонн нүүрс импортолсон. Одоогоор хоригийг цуцлах эсэх талаар албан ёсны мэдээлэл гараагүй байна (Michael Smith; Peter Ker, 2021).

Австралийн уул уурхайн салбарын орлого

АМНАТ нь тус улсын уул уурхайн салбараас олох төсвийн нийт орлогын тал орчим хувийг бүрдүүлдэг тул төсвийн орлогын гол эх үүсвэр юм. Доорх хүснэгтэд Австралийн АМНАТ орлогын нийт татварын орлого болон уул уурхайн салбарын татварын орлогод эзлэх хувийг харууллаа. 2015-16 оны санхүүгийн жилд Австралийн уул уурхайн салбарын татварын орлого нь нийт татварын орлогын 2.8%-ийг эзэлж байсан бол 2019-20 онд 7.1% болж нэмэгджээ. Энэ нь ашигт малтмалын өндөр үнэ, төмрийн хүдрийн дэлхийн зах зээлийн бусад өрсөлдөгчдийн нийлүүлэлт (ялангуяа Бразил) буурснаас гадна БНХАУ-ын эрэлт нэмэгдэж экспортын орлого өссөнтэй холбоотой. Австралид уул уурхайн салбарын татварын нийт орлогод АМНАТ-ийн эзлэх хувь хэмжээ 2015-16 онд 61.0% байсан ба үүнээс хойш тасралтгүй буурсаар 2019-20 онд 38.6%-д хүрчээ. Харин АМНАТ-ын нийт татварын орлогод эзлэх хувь 2019-20 оны санхүүгийн жилд 2.7% байна. Өөрөөр хэлбэл, сүүлийн жилүүдэд Австралид уул уурхайн салбараас төвлөрүүлэх бусад татварын орлого эрс нэмэгджээ.

Хүснэгт 2. Австралийн АМНАТ-ийн орлогын нийт татварын болон уул уурхайн салбарын татварын орлогод эзлэх хувь


	2015-16	2016-17	2017-18	2018-19	2019-20
Уул уурхайн салбарын татвар, нийт татварын орлогод эзлэх хувь	2.8%	4.5%	5.0%	6.6%	7.1%
АМНАТ уул уурхайн салбарын татварын орлогод эзлэх хувь	61.0%	51.1%	45.3%	39.5%	38.6%
АМНАТ нийт татварын орлогод эзлэх хувь	1.7%	2.3%	2.3%	2.6%	2.7%

Эх сурвалж: Government of Western Australia; Australian Minerals Council


Гаалийн дундаж үнэ

Доорх зурагт Department of Industry, Science, Energy and Resources-ийн мэдээлснээр, Австралийн коксжих нүүрсний экспортын хэмжээ болон, гаалийн дундаж үнийг харууллаа. Нүүрсний гаалийн дундаж үнэ ихээхэн хэлбэлзэлтэй байдаг. Австралийн коксжих нүүрсний дундаж үнэ 2018-19 оны санхүүгийн жилд сүүлийн 10 жилийн хамгийн өндөр түвшиндээ хүрсэн. 2020-21 оны санхүүгийн жилд 135.3 австрали доллар/тонн байв.

Зураг 3. Австралийн коксжих нүүрсний экспорт




Зураг 4. Коксжих нүүрсний гаалийн дундаж үнэ, австрали доллар/тонн




Эх сурвалж: Department of Industry, Science, Energy and Resources

Коксжих нүүрсний адил эрчим хүчний нүүрсний гаалийн үнэ ихээхэн хэлбэлзэж иржээ. 2015-16 онд эрчим хүчний нүүрсний гаалийн үнэ хамгийн доод буюу 73.3 австрали доллар/тонн байв. Харин 2018-19 оны санхүүгийн жилд сүүлийн 10 жилийн хамгийн өндөр хэмжээндээ хүрчээ. Гэвч үүнээс хойш тасралтгүй буурсаар 2020-21 онд 83.3 австрали доллар/тонн болов.

Зураг 5. Австралийн эрчим хүчний нүүрсний экспорт



Зураг 6. Австралийн эрчим хүчний нүүрсний гаалийн дундаж үнэ, австрали доллар/тонн



Эх сурвалж: Department of Industry, Science, Energy and Resources

Австралийн уул уурхайн салбарын хуулийн орчин

Австралид төрийн удирдлагын гурван түвшинтэй (холбооны, муж эсвэл нутаг дэвсгэр, орон нутгийн) ба үүнийг дагаад гурван түвшний хууль тогтоомжтой. Уул уурхайн салбарыг үндсэндээ муж, нутаг дэвсгэрийн буюу хоёр дахь түвшний хууль тогтоомжоор зохицуулдаг. Муж, орон нутгийн удирдах газар нь АМНАТ тогтоох, улсын тэмдэгтийн хураамж авах гэх мэт татварын тодорхой эрх мэдэлтэй байдаг.

Австрали нь байгалийн баялаг ихтэй орнуудын дунд хамгийн өндөр “үр нөлөөтэй” татварын хувь хэмжээтэй (effective tax rate) орнуудын нэг юм. 2015-16 оны санхүүгийн жилд Австралийн уул уурхайн салбарын “үр нөлөөтэй” татварын хувь хэмжээ 51% байжээ. Үүний 30% компанийн орлогын албан татварт ногдоно. 2005 онд Австрали нь Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн (OECD) гишүүн орнуудын дунд компанийн татварын хувь хэмжээгээрээ 14-т бичигдэж байсан бол 2019 онд 2-т орсон (Mintz, 2019).

Доорх хүснэгтэд Австралийн бүс нутгуудад хэрэгждэг уул уурхайн салбарын хуулиудыг харууллаа.

Хүснэгт 3. Австралийн бүс нутгуудад мөрдөгддөг уул уурхайн салбарын хууль тогтоомжууд

	Гол хууль тогтоомж	Эрх бүхий байгууллага
Шинэ Өмнөд Уэльс	Mining Act 1992 (NSW)	Department of Industry (Resources & Energy)
Хойд хэсэг/North Territory	Mineral Titles Act 2010 (NT) Mining Management Act 2001 (NT) Mineral Royalty Act 1982 (NT)	Department of Primary Industry and Resources
Квинслэнд	Mineral Resources Act 1989 (Qld) Mineral and Energy Resources (Common Provisions) Act 2014 (Qld)	Department of Natural Resources, Mines and Energy
Өмнөд Австрали	Mining Act 1971 (SA)	Department of State Development

Тасмания	Mineral Resources Development Act 1995 (Tas)	Department of State Growth
Викториа	Mineral Resources (Sustainable Development) Act 1990 (Vic)	Department of Economic Development, Jobs, Transport and Resources
Баруун Австрали	Mining Act 1978 (WA)	Department of Mines, Industry Regulation and Safety

Эх сурвалж: Lexology

Дээрх хууль, тогтоомжийн дагуу Австралийн дөрвөн бүс (Баруун Австрали, Квинслэнд, Шинэ Өмнөд Уэльс, Хойд хэсэг) АМНАТ-ын бие даасан, харилцан адилгүй хувь хэмжээ тогтоодог. Эдгээр нь ашигт малтмалын төрөл, боловсруулалтын түшингээс хамааран ялгаатай байдаг.

Зарим хуулийн нэмэлт өөрчлөлт

- Хойд хэсэг (North Territory)-д 2021 оны 7-р сарын 1-ээс эхлэн 2001 оны Mining Management хуулийн дагуу ногдуулсан уул уурхайн аюулгүй байдлын хураамж болон уг баталгааг хангахтай холбоотой зардал 1982 оны Ашигт малтмалын роялтигийн тухай хуульд АМНАТ-ийн зорилгоор хасагдахгүй болсон.
- Баруун Австрали хамгийн сүүлд 1984-1986 онд АМНАТ-ийн хувь хэмжээ, ногдуулж буй хэлбэрт системчилсэн үнэлгээ хийсэн. Засгийн газар уг үнэлгээний зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байгаа тул 1981 онд баталсан хувь хэмжээ мөрдөгдөж байна.
- Өмнөд Австралийн хувьд байгалийн хийн АМНАТ-ийн хувь хэмжээд олон удаа нэмэлт өөрчлөлт оруулж байжээ.
- Шинэ Өмнөд Уэльсийн хувьд 30 жилийн өмнө баталсан хуульдаа (Mining Act 1992) 2021 онд анх удаа өөрчлөлт оруулсан. Энэ нэмэлт өөрчлөлтөөр Royalties for Rejuvenation Fund –ийг байгуулах юм.
- Квинслэнд/Queensland-д 2020 онд Natural Resources, Mines and Energy Legislation (Fees) Amendment Regulation 2020-ийг баталсан. Гэхдээ АМНАТ-ийн хувь хэмжээнд өөрчлөлт оруулаагүй.

Австралийн АМНАТ-ийн хувь хэмжээ

Дээр дурдсанчлан, Австралийн бүс нутгуудад ялгаатай хууль тогтоомж үйлчилдэг ба АМНАТ ногдуулах хэмжээ, аргачлал харилцан адилгүй. Доорх хүснэгтэд бүс нутгуудад мөрдөгдөж байгаа АМНАТ-ийн төрөл болон хувь тооцох аргачлалыг харууллаа.

Хүснэгт 4. Австралийн бүс нутгуудад мөрдөгддөг АМНАТ-ийн хувь, хэмжээ

Бүс	АМНАТ-ийн төрөл	Хувь, хэмжээ	Тайлбар
Баруун Австрали	Борлуулалтын цэвэр орлогод суурилсан	Хүдэр болон овор ихтэй (bulk) түүхий эд: 7.5% Баяжмал: 5.0% Металл: 2.5% Алт: 1.25%-2.5% Экспортын нүүрс: 7.5%	Борлуулсан ашигт малтмалын тоо хэмжээг анхны борлуулсан үнээр үржүүлж, зөвшөөрөгдөх зардлуудыг хасна.
Шинэ Өмнөд Уэльс	Борлуулалтын цэвэр орлогод суурилсан	Зэс, алт, төмөр, уран, цайр зэрэг үндсэн металл: 4%	Хүдэр дэх агуулгын өртгөөс хүдрийг баяжуулах болон эхний овоолгын дараа зах зээлд гаргах зардлыг хасаж болно.
		Нүүрс: Ил уурхай - 8.2% Далд уурхай (underground) - 7.2%	Олборлосон нүүрсний өртгөөс дараах зардлуудыг хасна. Үүнд: боловсруулах зардал, судалгааны зардал

		Гүний уурхай (deep underground) - 6.2%	Даатгалын хураамж /mine subsidence levy/ Commonwealth levy for long service leave Уурхайн аврах ажиллагааны хураамж Муу өр төлбөр
	Нэгжид суурилсан	Бусад ашигт малтмал: тонн тутамд AUD 0.35 – AUD 0.70	Хүдэр дэх агуулгын хэмжээгээр
Квинслэнд /Queensland/	Борлуулалтын цэвэр орлогод суурилсан	Кобальт, зэс, алт, хар тугалга, никель, мөнгө, цайр: Зах зээлийн дундаж үнээс хамаарч 2.5% - 5% Манган, молибден, тантал, вольфрам: 2.7%	Ашигт малтмалын өртгийг Лондоны металлын бирж (LME) болон Лондоны үнэт цаасны зах зээл (LBM) дээр үндэслэн тооцох ба ханшийн өөрчлөлт, бараа, үйлчилгээний татвар, тээвэр, даатгал болон Департаментаас баталсан бусад зардлаар засварлана.
	Борлуулалтын цэвэр орлогод суурилсан	Нүүрс ¹⁵ : – Дундаж үнэ AUD 100-аас бага бол: 7% дундаж үнэ нь AUD 100-150 хооронд байвал: $(7\% + ((\text{дундаж үнэ} - 100) \div \text{дундаж үнэ} \times 5.5))\%$ дундаж үнэ AUD 150-аас дээш байвал: $7\% + ((\text{дундаж үнэ} - 100) \div \text{дундаж үнэ} \times 5.5)\% + ((\text{дундаж үнэ} - 150) \div \text{дундаж үнэ} \times 2.5)\%$	Борлуулсан нүүрсний хувьд: Нэхэмжлэгдсэн цэвэр орлогыг нийт нэхэмжлэхийн төлөгдөх биет хэмжээ (тонн)-д хуваана. Ингэхдээ даатгал болон тээврийн зардлыг хасаж тооцно.
		Төмрийн хүдэр: Дундаж үнэ AUD 100-аас бага бол тонн тутамд AUD 1.25 Дундаж үнэ AUD 100-аас их бол, 1.25% эсвэл $1.25\% + ((\text{дундаж үнэ} - 100) \div \text{дундаж үнэ} \times 1.25)\%$	Борлуулсан төмрийн хүдрийн хувьд: Нэхэмжлэгдсэн орлогыг нийт нэхэмжлэхийн төлөгдөх тоннд хуваана. Хаягдал буюу ашигласан төмрийн хүдрийн хувьд: АМНАТ ногдуулах нийт өртгийн хэмжээг нийт тоннд хуваана.
Хойд хэсэг/ North Territory	Ашигт суурилсан	Нийт үйлдвэрлэлийн орлого нь AUD 10,000-аас бага бол цэвэр өртгийн 20%.	Үйлдвэрлэлийн нэгжийн борлуулах боломжтой ашигт малтмалын үйлдвэрлэлээс үүссэн цэвэр үнэ цэнээс тооцно Энэ хоёр тооцооллын аль их хэмжээтэйг нь төлнө.
	Борлуулалтын цэвэр өртөгт суурилсан	АМНАТ төлөгчийн эхний жилд нийт үйлдвэрлэлийн орлогын 1% хоёр дахь жилд 2%, гурав дахь жилээс 2.5%	

Эх сурвалж: Government of Western Australia; New South Wales Government; Queensland Government; Government of Northwest Territories

Баруун Австралид 1981 онд нэвтрүүлсэн, гурван шатлалт өртөгт суурилсан системийг ашигладаг. Боловсруулалтын түвшнээс (хүдэр, баяжмал, эцсийн бүтээгдэхүүн) хамааран 3 ялгаатай хувь хэмжээ ногдуулдаг. Өртөгт суурилсан АМНАТ нь үнийн хэлбэлзэл, түүхий эдийн агууламж зэргийг харгалзан үздэг, анх борлуулсан дүнгээрх (first sold form) тоо хэмжээ болон үнийг үржүүлж тооцдог. Мөн "АМНАТ-ийн тусгай хувь (Special Royalty Rate)-г тогтоодог ба энэ нь голчлон бага өртөгтэй барилга, аж үйлдвэрлэлийн ашигт малтмалд ногдуулдаг. Хуульд

¹⁵ AUD 1 = USD 0.7-0.8

зааснаар улирал бүр олборлолтын тайлангаа гаргадаг. АМНАТ-ийг Цахим Сангийн шилжүүлэг (Electronic Funds Transfer) эсвэл чек хэлбэрээр Уул уурхай, газрын тосны газар (Department of Mines and Petroleum) хүлээн авдаг. Уул уурхай, аж үйлдвэрийн зохицуулалт, аюулгүй байдлын газар (The Department of Mines, Industry Regulation and Safety) нь АМНАТ-тай холбоотой хууль журмыг хэрэгжүүлэгч байгууллага бөгөөд дараах үүргийг гүйцэтгэдэг. Үүнд:

- АМНАТ-ийг ард иргэдэд зохих өгөөж хүртээхүйц захиран зарцуулах
- АМНАТ-ийн бодлогыг хэрэгжүүлэх, хангах зөвлөгөөг боловсруулах
- Зохих хууль тогтоомж, АМНАТ-ийн тогтолцооны талаар зөвлөгөө өгөх, удирдах замаар нөөц ашигласны төлбөрийн бодлогыг хэрэгжүүлэх.

Шинэ Өмнөд Уэльст АМНАТ-ийг ашигт малтмалын төрлөөс хамааран тогтмол хувь хэмжээгээр тогтоодог. АМНАТ ногдуулах нүүрсний борлуулалтын орлогын суурийг тухайн Департаментийн баталсан журмын дагуу тогтоодог (NSW Legislation, 2022). АМНАТ-ийг сар бүр эсвэл жилд нэг удаа гэсэн 2 ялгаатай хугацааны давтамжтай төлдөг. Тодруулбал, нүүрсний АМНАТ-ийг сар бүр Office of State Revenue-д шилжүүлдэг. АМНАТ-ийн хэмжээ нь хүснэгтэд үзүүлсэн шиг олборлолтын аргаас хамаарч өөр өөр байдаг. Мөн ашиг багатай уул уурхайн компаниудыг АМНАТ-өөс чөлөөлдөг. Тухайлбал, уул уурхайн компанийг дараах тохиолдолд нүүрсний АМНАТ-өөс чөлөөлнө (Бүс нутгийн АМНАТ-ийн эрхийн тогтоол). Үүнд:

- ашигт малтмал нь “төрийн өмчийн ашигт малтмал” байвал
- Сүүлийн 12 сарын хугацаанд олборлосон ашигт малтмалын өртөг 2000 австрали доллароос бага бол
- Хэрэв энэ олборлосон хугацаа 12 сараас бага бол олборлосон хугацааны жилд эзлэх хувийг олж, 2000 австрали доллароос хувиан тооцож чөлөөлнө

Квинсланд/Queensland/-д АМНАТ-ийн хэмжээ, төрөл нь бүтээгдэхүүний шинж чанар, тэдгээрийн үнээс хамааран ялгаатай байдаг. Цэвэр борлуулалтад суурилсан болон нэгжид суурилсан аргаар АМНАТ-ийн хувь хэмжээг тодорхойлдог. Өөрөөр хэлбэл, АМНАТ-ийг нийт мөнгөн орлогоос тооцдоггүй. Цэвэр борлуулалтад суурилсан аргаар тооцохдоо ашигт малтмалын үнийг Лондоны металлын бирж болон Лондоны үнэт цаасны зах зээлд үндэслэн тооцож, валютын ханшийн өөрчлөлт, бараа, үйлчилгээний татвар, тээвэр, даатгал болон яамнаас шийдвэрлэсэн бусад зардлыг хасаж засварладаг. Энэ аргыг төмрийн хүдрээс бусад төмөрлөг ашигт малтмалд ашигладаг. Нүүрсний хувьд дундаж үнээс хамааруулан ялгаатай байдлаар АМНАТ-ийн хувь хэмжээг тогтоодог. Нүүрсний дундаж үнийг нийт борлуулалтын цэвэр үнийн дүнг (тээвэр болон даатгалын зардлыг хассан дүн) борлуулсан тоо хэмжээнд хуваан тодорхойлдог.

Биржийн бус ашигт малтмалын хувьд АМНАТ ногдуулах үнийг Queensland Revenue Office-оос баталдаг. АМНАТ-ийг ашигт малтмалын борлуулалтын цэвэр орлогоос хувиар тооцдог тул эхлээд ашигт малтмалын нийт цэвэр орлогыг гаргах хэрэгтэй. Ашигт малтмалыг ямар нэгэн хамааралгүй этгээдэд худалдсан тохиолдолд нийт цэвэр орлого нь зарж борлуулсан дүн юм. Харин ашигт малтмалыг хамаарал бүхий этгээдэд худалдсан, тохиолдолд нийт цэвэр орлого нь “АМНАТ тооцох нийт өртгийн шийдвэр (Gross value royalty decision)”-ээр тодорхойлсон дүн болно. Ийм нөхцөлд АМНАТ-ийг төлөхийн тулд “АМНАТ тооцох нийт өртгийн шийдвэр”-ийг Queensland Revenue Office-д хүсэлт гарган авах ёстой (Queensland Government, 2021).

Квинсландад АМНАТ-ийн системд тусгай урамшуулал байдаг бөгөөд энэ нь АМНАТ төлөхгүй босго буюу Royalty-free threshold юм (нүүрс, төмрийн хүдэрт хамаарахгүй). Тухайн санхүүгийн жилд борлуулсан, ашигласан уул уурхайн төслийн хүрээнд олборлосон ашигт малтмалуудын нийлбэр дүнгийн эхний 100,000 австрали долларыг АМНАТ-өөс чөлөөлдөг. Энэ нь үйлдвэрлэл

буурах эсвэл үнэ унах эрсдэлийг төр хуваалцаж буй явдал юм. Мөн тогтоосон болон зарим тусгайлан заасан ашигт малтмал (зэс, алт, хар тугалга, никель, мөнгө, цайр, манган, молибден, тантал, вольфрам)-ын хувьд 50%-аас доошгүй хувийн металлын агууламжтай бөгөөд Квинсландад боловсруулагдсан бол АМНАТ-аас 20%-35% чөлөөлөх “Боловсруулалтын хөнгөлөлт” олгодог.

Улирал тутам тайлангаа гаргах шаардлагатай бүх уул уурхай, газрын тосны нөөц ашиглагчид АМНАТ-ийг сар бүр төлөх ёстой (хэрэв улирал тутам төлөх боломжтой гэж заагаагүй бол). АМНАТ-ийг Квинсландын орлогын алба/Queensland Revenue Office/-д төвлөрүүлнэ.

North Territory хувьд АМНАТ-ийг хоёр аргаар тогтоодог. Эхнийх нь ашигт суурилсан, нөгөө нь нийт борлуулалтын цэвэр орлогод суурилдаг. Ашигт суурилсан аргын суурь дүнг дараах байдлаар тодорхойлно. Энэ нь “Тухайн түүхий эдийг олборлоход зайлшгүй шаардлагатай зардлыг үйлдвэрлэлийн худалдсан буюу борлуулаагүй, борлуулах боломжтой ашигт малтмалын нийт үнийн дүнгээс хасна”. АМНАТ төлөгч нь цэвэр өртгийг тооцохын зэрэгцээ нийт үйлдвэрлэлийн орлогод тодорхой хувиар тооцож, АМНАТ-ийн доод хэмжээг тооцно. Тооцооллын дараа хоёр дүнгийн аль ихийг нь төлөх ёстой. Энэ нь “Minimum Royalty” гэсэн шинэ журмын дагуу 2019 оны 7-р сараас эхлэн мөрдөгдөж байна. Мөн жижиг уурхайнуудын хувьд жилийн нийт орлого AUD 500,000-аас их бол АМНАТ төлнө.


АМНАТ-ийг зургаан сар тутамд, 30 хоногийн дотор төлөх ёстой ба гурван сарын дотор жилийн тайлан болон үлдэгдэл төлбөрөө өгөх ёстой. Тогтоосон хугацаандаа төлбөрөө төлөхгүй бол алданги тооцно. Төлбөрийг нутаг дэвсгэрийн Татварын албанд төлөх ёстой.

Эрчим хүчний нүүрс

Австрали Улс нь хүрэн нүүрсний нөөцөөрөө дэлхийд 4-т ордог ба олборлосон хүрэн нүүрсний 80 орчим хувийг экспортолдог байна. Түүнчлэн, эрчим хүчний нүүрсний экспортоороо дэлхийд 2-т жагсдаг. Тухайлбал 2020 оны байдлаар дэлхийн эрчим хүчний нүүрсний экспортын 20%-ийг бүрдүүлжээ. Австрали эрчим хүчний нүүрсийг Япон, БНХАУ, Тайвань болон БНСУ руу экспортолдог ба дийлэнх хэсгийг Япон болон БНСУ руу гаргадаг (Department of Industry, Science, Energy and Resources, 2021).

Эрчим хүчний нүүрсний үнийн зохицуулалт нь эрчим хүчний нүүрсний чанар болон экспортлох улс орнуудаар харилцан адилгүй байдаг. Австралийн нүүрсийг Япон, Солонгос руу экспортлохдоо гол төлөв урт хугацааны гэрээнүүдэд тулгуурлан жилийн үнэ тогтоодог (жишээ нь Японы санхүүгийн жилийн (JFY) гэрээний үнэ). Хятад зэрэг бусад улс руу хийх экспортын хувьд арилжаа нь спот зах зээл дээр хийгддэг. Богино хугацааны гэрээгээр арилжаалсан Австралийн эрчим хүчний нүүрсний жишиг үнэ нь Ньюкасл дахь эрчим хүчний нүүрсний спот үнэ юм (Reserve bank of Australia, 2013) .

Зураг 7. Японы санхүүгийн жилийн гэрээний үнэ (JFY) болон Ньюкасл дахь эрчим хүчний нүүрсний үнэ, ам.доллар/тонн



Австралийн ашигт малтмалын татварууд

Австрали ашигт малтмалтай холбоотой татварын 2 төрөлтэй. Эдгээр нь АМНАТ болон Ашигт малтмалын нөөцийн түрээсийн татвар юм (PwC, 2012). Гэхдээ ашигт малтмалын нөөцийн түрээсийн татвар нь 2012-2014 оны хооронд үйлчилж байсан ба одоогоор ийм төрлийн татвар ногдуулдаггүй (Australian Taxation Office, 2019).

Австрали компаниуд дэлхий даяарх орлогоосоо **ААНОАТ** төлдөг. Харин олон улсын компаниуд зөвхөн Австралиас авсан орлогод Австралийн орлогын албан татвар төлнө. Гэхдээ Австралитай давхар татварын гэрээ (DTA) байгуулсан олон улсын компани бол Австрали дахь бизнесийн ашигт татвар ногдуулах хувь хэмжээ нь тухайн компанийн Австрали дахь хэсэгт хамаарах ашгаар хязгаарлагддаг. ААНОАТ нь Австралийн бүх мужуудад ижил хэмжээтэй байдаг бөгөөд холбооны хуулиар зохицуулагддаг. Одоогийн ААНОАТ-ын хувь хэмжээ 30% байгаа нь компаниудын хувьд Австралид үйл ажиллагаа явуулахад тулгардаг бэрхшээлүүдийн нэг гэж үздэг. Австралийн татварын тогтолцооны талаар хийсэн судалгаануудад татварын энэ хувь хэмжээг бууруулах санал зөвлөмж өгдөг. Гэхдээ тус улс жижиг дунд бизнес эрхлэгчдэд татварын хөнгөлөлт үзүүлдэг. Тодруулбал тухайн компанийн нийт борлуулалтын орлого 50 сая австрали доллароос бага бол татварын хөнгөлөлт эдлэх боломжтой. 2020-21 оны санхүүгийн жилд жижиг дунд уурхай эрхлэгчид ААНОАТ 26%, 2021-2022 онд 25% төлнө.

Экспортын татвар. Экспортын зөвшөөрөлтэй байх ерөнхий шаардлагаас бусдаар Австралийн ашигт малтмалыг экспортлох, худалдахтай холбоотой хууль тогтоомжийн хязгаарлалтууд бараг байхгүй. Түүнчлэн, Австралиас экспортлох ашигт малтмалын хувьд экспортын тусгай татвар ногдуулдаггүй. (Andrew Emrich, 2020). Татвар ноогдох орлогоос хайгуулын зардлыг хасаж тооцдог. Байгаль орчны нөхөн сэргээлтийн зардлыг орлогын албан татвараас чөлөөлдөг.

Бусад татвар, төлбөрүүд. Холбооны засгийн газраас тогтоосон хөрөнгийн ашгийн татвар болон бараа үйлчилгээний татвар нь бүх муж, бүс нутагт хүчинтэй. Тухайлбал:

- Хөрөнгийн ашгийн татвар – Австралид бүтгэлтэй компанийн эзэмшиж буй хөрөнгийн орлогод ААНОАТ-ын хувь хэмжээгээр татвар ногдуулна.
- Бүтээгдэхүүн үйлчилгээний татвар-Нэмэгдсэн өртгийн албан татвар (НӨАТ) 10%.


2.2. Индонезийн АМНАТ-ийн зохицуулалт

Индонезийн уул уурхайн салбарын эдийн засагт эзлэх байр суурь

Уул уурхайн салбар нь Индонезийн ДНБ, экспорт, засгийн газрын орлого, ажил эрхлэлт болон алслагдсан бүс нутгийн хөгжилд чухал хувь нэмэр оруулдаг. Ихэнх тохиолдолд уул уурхайн компаниуд нь алслагдсан бүс нутгийн цорын ганц ажил олгогч нь болдог (PWC, 2019). Харин нийт эдийн засгийн тав орчим хувийг уул уурхайн салбар бүрдүүлдэг. Гэхдээ бүсээсээ шалтгаалж ялгаатай байдаг. Тухайлбал Зүүн Калимантан мужид (нүүрсний ихэнх хэсэг нь олборлогддог) тус салбар ДНБ-ий 45.2 хувийг бүрдүүлдэг бол Баруун Папуа, Риау, Өмнөд Суматра, Өмнөд Калимантанд 20 гаруй хувийг бүрдүүлдэг (Oxford Business Group, 2020). Энэхүү үзүүлэлт нь уул уурхайн бүтээгдэхүүний үнэ, ялангуяа нүүрсний үнээс ихээхэн хамаарч хэлбэлздэг.

Индонезийн уул уурхайн салбар нь экспортын гол салбар бөгөөд 2018 оны байдлаар нийт экспортын 18 хувийг бүрдүүлсэн байна (Зураг 8). Гэхдээ 2014 оноос боловсруулаагүй (хагас боловсруулсан) ашигт малтмалын экспортыг хатуу хориглох, зарим ашигт малтмалд боловсруулалтын түвшнээс хамаарсан экспортын татвар ноогдуулж эхэлсэн. Эрдэс баялгийг боловсруулж эхэлснээр нийт экспортод эзлэх уул уурхайн экспортын хувь өснө гэж Засгийн газар найдаж байсан. Гэвч 2017 оноос зарим эрдэс баялгийн экспортын хязгаарлалтыг сулруулж, татварын түвшнээ буулгасан. Экспортын хоригоо сулруулж, нүүрсний үнэ өссөнтэй холбоотойгоор 2018 онд уул уурхайн экспортын хэмжээ нэмэгдэж, нийт экспортод эзлэх хувь нь 16 хувь болж өсжээ.


Зураг 8. Индонезийн эдийн засагт уул уурхайн салбарын үзүүлэх нөлөө



Эх сурвалж: Индонезийн төв банк

Тус улс нүүрс, зэс, алт, цагаан тугалаг, никелийн үйлдвэрлэлээрээ дэлхийд дээгүүр ордог. Тэр дундаа эрчим хүчний нүүрсний экспортоороо дэлхийд тэргүүлэгч орон. 2020 онд дэлхийн нийт эрчим хүчний нүүрсний экспортын 37 хувийг дангаар (400 орчим сая тонн) бүрдүүлсэн. Энэ нь Индонезийн нийт уул уурхайн экспортын 50 орчим хувь юм. 2020 оны нийт нүүрсний 71 хувийг Энэтхэг (29%), Хятад (18%), Филиппин (8%), Япон (8%), Малайз (8%) зэрэг улсад гаргасан.

Зураг 9. Индонезийн нүүрсний экспорт, түнш орнуудаар, сая тонн



Эх сурвалж: trademap.com

Индонезийн АМНАТ-ийн хууль зүйн орчин

Индонезийн Уул уурхайн тухай хууль (Mining Law – 2020 онд нэмэлт өөрчлөлт оруулсан) нь дагалдах маш олон засгийн газар болон яамдын журмуудтай. АМНАТ нь эдгээр дагалдах журмаар зохицуулагддаг. Эдгээр журмууд нь ойр ойрхон өөрчлөгдөж ирсэн (Хүснэгт 5).

Хүснэгт 5. АМНАТ-ийн хууль журмууд

Уул уурхайн тухай хууль No. 4/2009 (2020 онд нэмэлт өөрчлөлт орсон)
Засгийн газрын журмууд
- Уул уурхайн бизнесийн үйл ажиллагааны журам 23/2010 (2012, 2014, 2018 онд нэмэлт өөрчлөлт орсон) - АМНАТ-ийн түвшин 81/2019 (2000, 2012, 2019 онд шинэчлэн найруулсан)
Эрчим хүч, ашигт малтмалын яамны журам
Ашигт малтмалын, нүүрсний үнийн жишиг үнийг тогтоох журам 7/2017 (2017, 2018, 2020, 2021 онд нэмэлт өөрчлөлт орсон)
Ашигт малтмал, нүүрсний ерөнхий газрын захирамж, журам, тогтоол
- АМНАТ-ийн тооцооллын журам No.32 E/35/2009 - Зарим тусгай төрөл, ашиглалтын нүүрсний жишиг үнэ тогтоох журам No.480.K/30/2014

Эх сурвалж: PWC (2019), peraturan.bpk.go.id

Индонезийн Ашигт малтмалын тухай хуульд зааснаар уул уурхайн үйл ажиллагаанд дараах төрлийн зөвшөөрлүүдийг олгодог бөгөөд зөвшөөрлийн төрлөөс шалтгаалж төлөх АМНАТ болон татварын түвшнүүд ялгаатай байдаг. Тухайлбал:

1. Уул уурхайн бизнесийн зөвшөөрөл (Izin Usaha Pertambangan “IUP”). Уул уурхайн бизнесийн зөвшөөрөл нь уул уурхайн үйл ажиллагааны хоёр үе шатыг хамаардаг: (i)

- хайгуулын (ii) олборлолтын. Хайгуулын IUP нь геологийн судалгаа нь бүрэн хийгдсэн уул уурхайн бүсэд судалгаа, хайгуул, ТЭЗҮ хийх зориулалтаар олгосон зөвшөөрөл юм. Харин олборлолтын IUP нь геологийн судалгаа нь бүрэн хийгдсэн уул уурхайн бүсэд үйлдвэрлэлийн үйл ажиллагаа (жишээ нь, барилга байгууламж барих, олборлох, боловсруулах, тээвэрлэх, борлуулах) эрхлэхэд зориулагдсан уул уурхайн зөвшөөрөл юм.
2. Уул уурхайн бизнесийн тусгай зөвшөөрөл (Izin Usaha Pertambangan “IUPK”). Энэ нь IUP-тай адилаар үйл ажиллагааны хоёр үе шатыг хамаардаг. Хайгуулын IUPK нь улсын нөөцийн бүсийн арилжааны зориулалтаар ашиглах боломжтой хэсэгт судалгаа, хайгуул, ТЭЗҮ хийх зориулалтаар олгосон зөвшөөрөл юм. Харин олборлолтын IUP нь улсын нөөцийн бүсийн арилжааны зориулалтаар ашиглах боломжтой хэсэгт үйлдвэрлэлийн үйл ажиллагаа (жишээ нь, барилга байгууламж барих, олборлох, боловсруулах, тээвэрлэх, борлуулах) явуулахад зориулагдсан уул уурхайн зөвшөөрөл юм.
 3. Ажлын гэрээ/Нүүрсний ажлын гэрээ (Contract of Work/Coal Contract of Work “CoW”, “CCoW”). CoW компаниуд нь 100 хувь гадаадын хөрөнгө оруулалттай байж болдог бөгөөд IUP болон IUPK зөвшөөрөлтэй компаниудын тодорхой хувь нь л гадаадын хөрөнгө оруулалттай болж болдог. Түүнчлэн IUP/IUPK зөвшөөрлүүдээс илүү удаан хугацаанд үйл ажиллагаа явуулах боломжтой бөгөөд үйл ажиллагаа явуулж буй газартаа газ, газрын тос, нүүрс болон уранаас бусад бүх байгалийн баялгийг олборлох боломжтой. Харин CCoW компанийн хувьд зөвхөн нүүрс олборлоно. Гэхдээ CoW/CCoW эзэмшигч компаниуд нь илүү өндөр хэмжээний АМНАТ болон татваруудыг төлдөг.
 4. Ажлын гэрээг үргэлжлүүлэх уул уурхайн бизнесийн тусгай зөвшөөрөл (IUPK for the Continuation of Operation of Contract of Work). Энэ төрлийн зөвшөөрөл Ашигт малтмалын хуулийн 2020 оны нэмэлт өөрчлөлтөөр орж ирсэн бөгөөд CCoW болон CoW зөвшөөрлүүд дууссаны дараа сунгалтаар олгогддог бизнесийн зөвшөөрөл юм.
 5. Олон нийтийн уул уурхайн зөвшөөрөл (Izin Pertambangan Rakyat “IPR”). Жижиг хэмжээний газарт хязгаарлагдмал хөрөнгө оруулалттайгаар уул уурхайн бизнес эрхлэх зөвшөөрөл. Энэхүү зөвшөөрөлтэйгөөр гадаадын хөрөнгө оруулалт татах боломжгүй.
 6. Чулуу олборлох зөвшөөрлийн бичиг (Surut Izin Penambangan Butuan “SIPB”). Тодорхой зорилгын хүрээнд тодорхой төрлийн чулуулгийг олборлох үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл юм.
 7. Цацраг идэвхт ашигт малтмал олборлох тусгай зөвшөөрөл (Assignment License for radioactive minerals mining activities). Цөмийн энергийн салбарын хууль тогтоомжийн дагуу цацраг идэвхт ашигт малтмалын ашиглалтын хүрээнд олгодог зөвшөөрөл юм.
 8. Тээвэрлэлт борлуулалтын зөвшөөрөл. Тээвэрлэлт борлуулалтын зөвшөөрөл гэдэг нь ашигт малтмал, нүүрсний уурхайн түүхий эдийг худалдан авах, тээвэрлэх, худалдах зорилгоор аж ахуйн нэгжид олгосон бизнесийн зөвшөөрөл.
 9. Уул уурхайн үйлчилгээний зөвшөөрөл (Izin Usaha Jasa Pertambangan “IUJP”). Уул уурхайн бизнесийн үйл ажиллагааны үе шат эсвэл зарим хэсэгтэй холбоотой уул уурхайн үйлчилгээний үндсэн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл.
 10. Уул уурхайн бизнесийн борлуулалтын зөвшөөрөл (Борлуулалтын IUP)

Индонезийн АМНАТ-ийн хувь хэмжээ, тооцоолол журам

IUP болон IUPK эзэмшигчдийн хувьд бүтээгдэхүүний төрлөөс хамааран АМНАТ нь 1-10 хувь байдаг бөгөөд борлуулалтаасаа төлдөг. Харин нүүрсний АМНАТ нь 2-7 хувь ба энэ нь нүүрсний илчлэг болон уурхайн төрлөөс хамаардаг. Ил уурхайтай харьцуулахад далд уурхайн илүү бага АМНАТ төлдөг.

Хүснэгт 6. Индонезийн нүүрсний АМНАТ-ийн түвшин, борлуулалтын орлогод ногдуулах хувь

Ил уурхай	Хувь хэмжээ
≤ 4700 ккал/кг	3%
4700 – 5700 ккал/кг	5%
≥ 5700 ккал/кг	7%
Далд уурхай	
≤ 4700 ккал/кг	2%
4700 – 5700 ккал/кг	4%
≥ 5700 ккал/кг	6%

Эх сурвалж: Индонезийн ЗГ-ын АМНАТ-ийн түвшний журам 81/2019

Уул уурхайн бизнесийн тусгай зөвшөөрөл IUPK эзэмшигчид мөн **цэвэр ашгийнхаа 10 хувийг** нэмэлт нөөц ашигласны төлбөр болгон төлөх ёстой. Энэхүү нэмэлт АМНАТ-ийн орлогын 40 хувийг төв засгийн газар авдаг бөгөөд үлдсэн хэсгийг холбогдох муж, орон нутагт хуваарилдаг. Харин ажлын гэрээний зөвшөөрөл (CoW/CsoW) эзэмшигчдийн хувьд **АМНАТ 13.5 хувьтай** байдаг. Компаниуд засгийн газарт АМНАТ төлөх үйл ажиллагаа нь Эрчим хүч, ашигт малтмалын яамны журам “Ашигт малтмал, нүүрсний татварын бус улсын орлогыг ногдуулах, бүрдүүлэх төлөх хэрэгжилтийн удирдамж”-аар зохицуулагддаг. Энэхүү удирдамжаас онцлог заалтуудыг дурдвал:

Нүүрсний үнийн өсөлттэй холбоотойгоор Индонезийн засгийн газар одоогоор АМНАТ-ийн хувь хэмжээг үнээс хамааран өсөн нэмэгдэх байдлаар зохицуулах санал дэвшүүлж байгаа бөгөөд салбарын бизнес эрхлэгчид энэ саналыг өргөн хүрээтэй нухацтай хэлэлцэж байж шийдвэрлэхийг шаардаж байгаа аж (CNBC Indonesia , 2022). Мөн Индонезийн засгийн газар нүүрсийг боловсруулж, нэмүү өртөг шингээсэн тохиолдолд АМНАТ-ийн түвшнийг тэглэх санал гаргаад байгаа ажээ.

Индонезийн нүүрсний АМНАТ ба жишиг үнэ


Индонезийн засгийн газар 2009 оноос нүүрсний АМНАТ-ийн борлуулалтын үнэлгээг тооцоход жишиг үнийг тооцож эхэлсэн бөгөөд 2011 оноос хэрэгжүүлж эхэлжээ. Мөн бусад ашигт малтмалуудын хувьд 2011 оноос жишиг үнэд суурилан АМНАТ-ийг тооцож авч эхэлсэн.

Индонезид нүүрсний жишиг үнэ, суурь үнэ гэсэн хоёр ялгаатай нэр томьёо хэрэглэгддэгийг анхаарах хэрэгтэй. Жишиг үнэ (benchmark price)-ийг зарлахын тулд эхлээд Эрчим хүч, ашигт малтмалын яам нүүрсний суурь үнэ (Coal Reference price - Harga Batubara Acuan, “НБА”)-ийг сар болгон тооцож зарладаг. Энэ үйл ажиллагааг (НРВ) нь Ашигт малтмал, нүүрсний ерөнхий газрын журмаар зохицуулагддаг.

Уул уурхайн бүтээгдэхүүнүүдэд тогтоож байгаа жишиг үнэ нь засгийн газрын АМНАТ-ийн тооцооллын доод үнэ болдог. Өөрөөр хэлбэл, хэрэв борлуулалтын бодит үнэ нь жишиг үнээс өндөр байвал АМНАТ-ийг борлуулалтын үнээс тооцно. Хэрэв бодит борлуулалтын үнэ жишиг үнээс доогуур байвал АМНАТ-ийг жишиг үнэд үндэслэн тооцно.

Нүүрсний жишиг үнийг тооцож зарлахдаа **жишиг үнийн томьёог** ашигладаг бөгөөд хэд хэдэн хүчин зүйлсийг авч үздэг. Үүнд нүүрсний илчлэг, нүүрсний суурь үнэ (НБА), чийгшил, хүхрийн агууламж болон үнслэг зэрэг багтдаг.

Зураг 10. Жишиг үнийн тооцоолол




Суурь үнэ (НВА)-ийг сар бүр Эрчим хүч, ашигт малтмалын яамнаас зарладаг. 6322 ккал/кг илчлэгтэй, 8 хувийн чийгшилтэй, 0.8 хувийн хүхрийн агууламжтай, үнслэг 15 хувьтай нүүрсэнд үндэслэн дөрвөн нүүрсний үнийн индексийг тооцдог. Тухайн сарын НВА-ийг тооцохдоо өмнөх сарын утгуудыг авч ашигладаг.

1. Global Newcastle Index (GC)
2. Newcastle Export Index (NEX)
3. Indonesian Coal Index (ICI)
4. Platts 5900

Эхний хоёр индекс (GC, NEX) нь гадаадын зах зээлийн үнийг төлөөлдөг бол сүүлийн хоёр индекс (ICI, Platts) нь Индонезийн дотоодын зах зээлийн үнийг төлөөлдөг. Бүх үнийн индекс адил жинтэй ордог.

$$HBA = 25\% * ICI + 25\% * Platts + 25\% * NEX + 25\% * GC$$

Зураг 11. Нүүрсний суурь үнэ (НВА), \$/тонн



Эх сурвалж: Индонезийн эрчим хүч, ашигт малтмалын яам

Суурь үнэ (НВА)-ийг тодорхойлсны дараа нүүрсний жишиг үнийг нарийн тодорхойлсон үнийн томъёо ашиглан тооцдог (Tiwari, Bhattacharya, & Raghav, 2015). Нийт 7000 ккал/кг-2995 ккал/кг-ийн хоорондох 75 нүүрсний төрлөөс шалтгаалан хэд хэдэн ялгаатай жишиг үнүүд тогтох бөгөөд энэ нь чийгшил, хүхрийн агууламж, илчлэг, үнслэг байдал зэргээс шалтгаална. Нүүрсний илчлэгийн хэмжээг GAR нөхцөлөөс ADB нөхцөл рүү хөрвүүлэхдээ дараах тэгшитгэлийг ашиглана:

$$K_{GAR} = K_{ADB} * \frac{(100 - TM)}{(100 - M)}$$

K_{GAR} = GAR (gross as received) нөхцөл дэх нүүрсний илчлэгийн түвшин

K_{ADB} = ADB нөхцөл дэх нүүрсний илчлэгийн түвшин

TM = Нийт чийгшил

M = Чийгшил

Тухайлбал, Хүснэгт 7-д харуулсан нүүрсний төрлүүдийн (No. 1-7) жишиг үнийг дараах томъёо ашиглан тооцоолно:

$$HPB\ Marker_{(i)} = (HBA * K_{(i)} * A_{(i)}) - (B_{(i)} + U_{(i)})$$

$HPB\ Marker_{(i)}$ = (i) дугаар нүүрсний жишиг үнэ [\$/тн]

$K_{(i)}$ = Нүүрсний илчлэг_(i)/6322 [бутархай]

$A_{(i)}$ = (100 – Нүүрсний чийгийн агууламж_(i))/(100 – 8) [бутархай]

$B_{(i)}$ = (Нүүрсний хүхрийн агууламж_(i) – 0.8)*4 [\$/тн]

$U_{(i)}$ = (Нүүрсний үнсний агууламж_(i) – 15)*0.4 [\$/тн]

i = нүүрсний төрөл, 1-7

Хүхэр болон үнсний агууламжийг тооцоололд хасах байдлаар оруулж өгч байгаа нь хүхрийн агууламж их байх тусам нүүрстөрөгчийн ялгаруулалт их байдаг болон ялгарсан үнсийг зайлуулахад зардал гарах тул торгууль (penalty) хэлбэрээр оруулдаг (Tiwari, Bhattacharya, & Raghav, 2015).

Хүснэгт 7. Индонезийн нүүрсний ангилал

No	Нүүрсний төрөл/Брэнд	Чанарын үзүүлэлтүүд			
		Илчлэг (ккал/кг)	Чийгшил (%)	Хүхэр (% , ar)	Үнслэг (% , ar)
1	Gunung Bayan I	7000	10.0	1.00	15.00
2	Prime Coal	6700	12.0	0.60	5.00
3	Pinang 6150	6200	14.5	0.60	5.50
4	Indominco IM_EAST	5700	17.5	1.63	4.80
5	Melawan Coal	5400	22.5	0.40	5.00
6	Envirocoal	5000	26.0	0.10	1.20
7	Jorong J-1	4400	32.0	0.25	4.15

Эх сурвалж: sumbarprow.go.id

Бусад төрлийн нүүрснүүд болон тэдгээрийн жишиг үнийг тооцдог аргачлалыг Хавсралт 1, Хавсралт 2-г дэлгэрэнгүй танилцууллаа.

Энэхүү жишиг үнэ тооцох аргачлалын сул тал нь үнийн шокын нөлөөг хоцорч тусгадаг. Ковид-19 цар тахалтай холбоотойгоор Индонезийн нүүрсний эрэлт 2020 оны 3-р сараас эхлэн буурсан. Эрэлт буурснаар үнэ дагаж буурсан. Гэтэл жишиг үнэ тооцоход ашиглагддаг харгалзах үнэ (HBA) нь дөрвөн индексийн өнгөрсөн сарын утгад үндэслэдэг тул жишиг үнэ болон борлуулалтын үнийн ялгаа ихсэж Индонезийн нүүрсний компаниудад Ковид-19-өөс гадна АМНАТ төлбөрийн нэмэлт дарамт тулгарчээ. Индонезийн нүүрсний холбооны мэдэгдсэнээр, эрчим хүчний нүүрсэнд жишиг үнэ болон зах зээлийн (гэрээний) үнээс тонн тутамд 5 долларын зөрүү гарч байсан. Тиймээс Индонезийн нүүрсний холбоо АМНАТ-ийг илүү уян хатуу буюу жишиг үнээр бус гэрээний үнээр тооцох хүсэлт гаргасан (APBI, 2020). Түүнчлэн тухайн үед

мөрдөгдөж байсан журмаар АМНАТ-ийг ачилт хийгдмэгц, нүүрсийг захиалагчид хүргэсэн эсэхээс үл хамаарах төлдөг байсан нь компаниудад эргэлтийн хөрөнгийн хомсдол үүсгэж байжээ (Шинэ журмаар ачилт хийгдсэнээс хойш 30 хоногийн дотор төлдөг болсон).

Индонезийн уул уурхай бусад татварууд

ААНОАТ. Индонезийн орлогын албан татварын түвшин 25 хувь бөгөөд 5 хүртэлх хувийн хөнгөлөлт эдлэх боломжтой. Ажлын гэрээний зөвшөөрөл CCoW/CoW эзэмшигчдийн хувьд орлогын албан татвар нь 30-45 хувь байдаг бөгөөд яг хэдэн хувь байхыг гэрээгээр шийддэг. Арилжааны хөрвөх чадвартай холбоотой тодорхой шаардлагыг хангасан Индонезийн хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниуд энэ татвараас 5 хувийн хөнгөлөлт эдлэх боломжтой байдаг.

НӨАТ. Ихэнх бүтээгдэхүүн үйлчилгээнд НӨАТ-ыг ногдуулдаг. 2022 оноос эхлэн НӨАТ нь 1 хувь нэмэгдэж 11 хувь болсон. Одоогийн мөрдөж байгаа хуульд алтны гулдмай, нүүрс, байгалийн баялгийг эх үүсвэрээс нь шууд нийлүүлэхэд НӨАТ тооцохгүй гэж заасан. Түүнчлэн НӨАТ-ийн хувь нь боловсруулалтын түвшнээс шалтгаалан өөрчлөгддөг. Гэхдээ нүүрсний хувьд угаах, бутлах үйл ажиллагааг боловсруулах үйл ажиллагаа гэж үздэггүй.

Гэнэтийн ашгийн татвар. Нүүрсний үнэ өсөж Индонезийн нүүрсний компаниудын ашиг нэмэгдэж байгаа тул нүүрс олборлогч компаниудад гэнэтийн ашгийн татвар ногдуулах санал гарах болсон. Индонезийн үндсэн хуульд ард түмэн, олон нийт нүүрс зэрэг байгалийн баялгаас ашиг хүртэх ёстой гэж заасан байдаг тул нүүрсний компаниудад гэнэтийн ашгийн татвар ногдуулах нь илүү үндэслэлтэй гэж зарим шинжээчид үзэж байна. Гэхдээ гэнэтийн ашгийн татварын хэмжээ нь ямар төрлийн/хэр илчлэгтэй нүүрс олборлож байгаагаасаа шалтгаалан өөр байх шаардлагатай.

Газар ашиглалтын төлбөр (dead rent). Засгийн газрын 81/2019 журмын дагуу IUP болон IUPK эзэмшигчид хайгуулын үе шатанд га тутамд 30,000 рупи (1 рупи ~ 0.2 төгрөг) ашиглалтын шатанд га тутамд 20,000 – 60,000 рупи хүртэл газар ашиглалтын төлбөр шаарддаг. CoW/CCoW эзэмшигчдийн хувьд төлөх хэмжээг гэрээгээр тохирдог.

Экспортын татвар. 2012 оноос зарим боловсруулаагүй ашигт малтмалыг экспортлохыг хориглож, ашигт малтмалын боловсруулалтын түвшнээс шалтгаалан экспортын татвар авч эхэлсэн. Гэхдээ нүүрснээс экспортын татвар авдаггүй. Ашигт малтмалын боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор экспортын татвар ногдуулж эхэлсэн ч жил бүр экспортын хязгаарлалтаа сулруулж, татварын түвшнийг бууруулж байна. Боловсруулалтын түвшнээс хамаарч татварын хэмжээ тодорхойлогдох бөгөөд дөрвөн үе шаттай байсныг 2018 оны нэмэлт өөрчлөлтөөр гурван үе шат болгон өөрчилсөн.

- I үе шат – Боловсруулалтын түвшин 30% ихгүй
- II үе шат – Боловсруулалтын түвшин 30%-50%
- III үе шат – Боловсруулалтын түвшин 50%-аас өндөр

2014 оноос боловсруулалтын түвшин бага ашигт малтмалд экспортын татвар ногдуулж эхэлсэн байдаг. Цаашлаад бага агуулгатай никелийн хүдэр, угаасан бокситын экспортыг бүрэн хориглосон. Гэхдээ 2017 оноос энэхүү хоригийг сулруулан 10 хувийн татвартай гаргахыг зөвшөөрөх болсон. Цэвэршүүлэх байгууламжийн хөгжлийн дөрвөн түвшнээс хамаарч 0-7.5 хувийн татварыг ногдуулж байсан бол 2018 оноос бууруулж 3 түвшнээс хамаардаг болж 0-5 хувийн татварыг авах болсон.

Хүснэгт 8. Экспортын татвар, бүтээгдэхүүнээр, цэвэршүүлэх байгууламжийн хөгжлөөр

№	Types of Mineral	Export duty Rate			
		The physical progress stage of the refining facility's development			Minerals with certain criteria
		Stage 1	Stage 2	Stage 3	
1	Copper concentrate with concentration > 15% CU	5.0%	2.5%	0.0%	N/A
2	Iron concentrate (hematite, magnetite with concentration >62% Fe and < 1% TiO ₂)	5.0%	2.5%	0.0%	N/A
	Laterite iron concentrate (goethite/laterite) with concentration > 50%	5.0%	2.5%	0.0%	N/A
	Iron sand concentrate with concentration > 54% Fe and 1%<TiO ₂ <25%	5.0%	2.5%	0.0%	N/A
	Iron sand concentrate pellet with concentration > 54% Fe and 1%<TiO ₂ <25%	5.0%	2.5%	0.0%	N/A
3	Manganese concentrate with concentration > 49% MN	5.0%	2.5%	0.0%	N/A
4	Lead concentrate with concentration > 56% PB	5.0%	2.5%	0.0%	N/A
5	Zinc concentrate with concentration > 51% Zn	5.0%	2.5%	0.0%	N/A
6	Limenite concentrates with concentration > 45% TiO ₂	5.0%	2.5%	0.0%	N/A
7	Other titanium concentrates with concentration > 90% TiO ₂	5.0%	2.5%	0.0%	N/A
8	Nickel with concentration < 1.7% Ni	N/A			10%
9	Washed bauxite with concentration > 42% Al ₂ O ₃	N/A			10%

Эх сурвалж: PWC (2019)

**Хавсралт 1. Индонезийн Ашигт малтмал, нүүрсний ерөнхий газарт бүртгэлтэй
бусад төрлийн нүүрс (No. 8 - 75)**

No	Нүүрсний төрөл/Брэнд	Чанарын үзүүлэлтүүд			
		Илчлэг (ккал/кг)	Чийгшил (%)	Хүхэр (%, ar)	Үнслэг (%, ar)
8	Ecocoal	4200	35.0	0.18	3.90
9	Gunung Bayan II	7,000	12.00	2.00	10.00
10	Marunda Thermal Coal	6,600	11.00	0.50	10.00
11	Trubaindo HCV_HS	6,553	12.00	1.69	4.21
12	Medco Bara 6500	6,500	10.00	3.28	9.38
13	Trubaindo HCV_LS	6,423	11.50	0.71	4.76
14	AGM Waruba Coal	5,313	23.00	0.24	4.00
15	Pinang 6000 NAR	6,300	14.00	0.60	5.50
16	Arutmin Satui 10	6,300	11.00	1.00	10.00
17	Arutmin Senakin	6,250	11.00	1.00	12.00
18	Arutmin A6250	6,250	10.00	1.20	12.00
19	Mandiri 1	5,200	25.00	0.60	7.00
20	Wahana Coal	6,200	12.00	0.90	10.00
21	Medco Bara 6200	6,200	10.00	4.00	12.00
22	Indominco IM_West / 6500	6,171	15.50	0.76	5.22
23	TAJ Coal	6,200	10.00	1.00	14.00
24	Mandiri 2	5,100	26.00	0.60	7.00
25	Trubaindo MCV_LS	6,143	14.00	0.76	5.20
26	SKB Coal	6,130	9.00	2.20	17.00
27	Baramarta Coal	6,112	9.50	0.95	13.00
28	Arutmin A6100	6,100	11.50	1.00	12.50
29	Insani Coal	6,050	19.00	0.15	3.20
30	BCS Coal	5,915	15.10	0.56	9.40
31	Indominco IM_West / 6350	6,029	15.50	0.71	5.22
32	Bangun Coal	6,072	10.02	2.20	14.91
33	Pinang 6000	6,000	16.00	0.60	5.00
34	Indominco IMM_MCVHS	5,970	15.50	1.65	5.05
35	Multi Coal Low	5,950	16.00	1.00	7.00
36	Multi Coal Middle	5,900	16.00	2.00	7.00
37	Pinang 5900	5,900	19.00	0.90	4.50
38	Arutmin A5900	5,900	12.00	0.90	13.00
39	Multi Coal High	5,765	16.00	3.20	7.00
40	KCM Coal	5,730	10.50	0.90	20.50
41	TSA Coal	5,700	18.00	2.00	8.00
42	Tanito Coal	5,700	17.50	1.00	8.50
43	Mahakam Coal	5,700	17.50	1.00	8.50
44	Ebony High Sulphur	5,700	18.00	1.75	4.70
45	Pinang 5700	5,700	19.00	0.50	5.00
46	IBP5500	5,500	20.00	1.00	7.00
47	Arutmin A5700	5,700	11.00	0.80	14.00
48	BSS Coal	5,520	10.00	0.45	15.50
49	Lanna Harita Coal	5,500	22.00	1.00	6.00
50	Pinang 5500	5,500	21.00	0.40	5.50
51	Mahoni Medium Sulphur	5,500	20.00	1.30	4.70
52	Mahoni	5,500	20.00	0.80	4.70
53	Mahakam Coal B	5,400	23.00	1.50	8.00
54	Mahoni B	5,300	22.50	0.80	4.60
55	Kideco Coal	5,125	24.50	0.10	2.00
56	Agathis	5,100	25.00	0.82	4.50
57	Lanna Harita Coal	5,000	27.00	1.20	6.00

58	IBP5000	5,000	25.00	1.00	7.00
59	Sungkai Medium Sulphur	5,000	26.00	1.30	4.50
60	Sungkai	5,000	26.00	0.90	4.50
61	Sungkai High Sulphur	5,000	26.00	1.70	4.50
62	Arutmin A5000	5,000	22.40	0.54	8.90
63	AGM Warute Coal	4,350	33.00	0.40	4.00
64	IBP4600	4,600	28.00	0.50	7.00
65	Bas Gumay Coal	4,400	35.00	0.50	4.96
66	IBP4400	4,400	30.00	0.50	7.00
67	IBP4200	4,200	32.00	0.50	6.00
68	PIC Coal	4,200	33.00	1.75	6.00
69	BIB 4000	4,000	38.00	0.50	6.00
70	Borneo BIB	3,800	41.00	0.40	5.00
71	AGM Warutas Coal	3,800	40.00	0.15	5.23
72	PKN 3500	3,520	43.40	0.15	3.40
73	BMPclenco32	3,200	48.00	0.50	5.00
74	LIM 3010	3,010	47.50	0.60	5.30
75	LIM 3000	2,995	50.10	0.60	5.30

Хавсралт 2. Индонезийн бусад нүүрсний жишиг үнэ тооцох томьёо

1. Бусад нүүрсний жишиг үнэ No. 8

$$HPB\ Marker\ (i) = (HBA * K(i) * A(i)) - (B(i) + U(i))$$

Үүнд:

- $HPB\ Marker\ (i)$ = (i) дугаар нүүрсний жишиг үнэ [\$/тонн]
- $K(i)$ = Нүүрсний илчлэг (i) / 6322 [бутархай]
- $A(i)$ = $(100 - \text{Нүүрсний чийгшил}(i)) / (100 - 8/FKA(i))$ [бутархай]
- $FKA(i)$ = $(((((100-8)/(100 - \text{Нүүрсний чийгшил}(i)))) * \text{Нүүрсний чийгшил}(i)) + (100 - 8)) / 100$ [хувь]
- $B(i)$ = $(\text{Нүүрсний хүхрийн агууламж}(i) - 0.8) * 4$ [\$/тонн]
- $U(i)$ = $(\text{Нүүрсний үнсний агууламж}(i) - 15) * 0.4$ [\$/тонн]
- i = 8 (8-р төрлийн нүүрс)

2. Бусад нүүрсний жишиг үнэ No. 9 – 66

$$HPB\ (j) = \{ (HPB\ Price\ Marker\ (i) + (B(i) + U(i))) * (K(j) / K(i)) * [(100 - \text{Чийгшил}(j)) / (100 - \text{Чийгшил}(i))] * [(100 - 8) / (100 - 8)] \} - (B(j) + U(j))$$

[\$/тонн]

- $HPB(j)$ = Бусад нүүрсний жишиг үнэ, (j) дугаар [\$/тонн]
- $B(i)$ = $(\text{Нүүрсний хүхрийн агууламж}(i) - 0.8) * 4$ [\$/тонн]
- $U(i)$ = $(\text{Нүүрсний үнсний агууламж}(i) - 15) * 0.4$ [\$/тонн]
- $B(j)$ = $(\text{Нүүрсний хүхрийн агууламж}(j) - 0.8) * 4$ [\$/тонн]
- $U(j)$ = $(\text{Нүүрсний үнсний агууламж}(j) - 15) * 0.4$ [\$/тонн]
- $K(j) / K(i)$ = Нүүрсний илчлэг(j)/Нүүрсний илчлэг(i) [бутархай]
- (i) = Нүүрс № 1 – 7
- (j) = Бусад нүүрс № 9 – 66

3. Бусад нүүрсний жишиг үнэ, № 67 – 75 (Бага илчлэгтэй нүүрс)

Чийгшил < 40%

$$\text{HPB}(j) = \{(\text{HPB Price Marker}(i) + (B(i) + U(i))) * (K(j) / K(i)) * [(100 - \text{Чийгшил}(j)) / (100 - \text{Чийгшил}(i))] * [(100 - 8/\text{FKA}(i)) / (100 - 8/\text{FKA}(j))] - (B(j) + U(j))\} \quad [\text{US\$/ton}]$$

- HPB(j) = (j) дугаар нүүрсний жишиг үнэ [\$/тонн]
- HPM(i) Marker = (i) дугаар нүүрсний жишиг үнэ
- B(i) = (Нүүрсний хүхрийн агууламж(i) – 0.8)*4 [\$/тонн]
- U(i) = (Нүүрсний үнсний агууламж(i) – 15)*0.4 [\$/тонн]
- B(j) = (Нүүрсний хүхрийн агууламж(j) – 0.8)*4 [\$/тонн]
- FKA(j) = (((100 – Нүүрсний чийгшил)/(100 – Нүүрсний Чийгшил(j)))*Нүүрсний чийгшил(j)) + (100 – Нүүрсний чийгшил)/100 [хувь]
- U(j) = (Нүүрсний үнсний агууламж(j) – 15)*0.4 [\$/тонн]
- K(j) / K(i) = Нүүрсний илчлэг(j)/Нүүрсний илчлэг(i) [бутархай]
- (i) = Нүүрс № 8
- (j) = Бусад нүүрс № 67 – 69

Чийгшил ≥ 40%

$$\text{HPB}(j) = \{(\text{HPB Price Marker}(i) + (B(i) + U(i))) * (K(j) / K(i)) * [(100 - \text{Чийгшил}(j)) / (100 - \text{Чийгшил}(i))] * [(100 - 8/\text{FKA}(i)) / (100 - 8/\text{FKA}(j))]\}$$

- HPB(j) = (j) дугаар нүүрсний жишиг үнэ [\$/тонн]
- HPM(i) Marker = (i) дугаар нүүрсний жишиг үнэ
- FKA(j) = (((100 – Нүүрсний чийгшил)/(100 – Нүүрсний Чийгшил(j)))*Нүүрсний чийгшил(j)) + (100 – Нүүрсний чийгшил)/100 [хувь]
- K(j) / K(i) = Нүүрсний илчлэг(j)/Нүүрсний илчлэг(i) [бутархай]
- (i) = Нүүрс № 8
- (j) = Бусад нүүрс № 67 – 69


2.3. Оросын Холбооны Улсын АМНАТ-ийн зохицуулалт

ОХУ-ын нүүрсний салбарын өнөөгийн байдал

ОХУ нь ашигт малтмалын нөөцөөр баялаг бөгөөд томоохон ашигт малтмалын үйлдвэрлэгч улсуудын нэг юм. ОХУ нь нүүрс, алт, мөнгө, цагаан алт, никель, алмаз, төмрийн хүдэр, уран зэрэг ашигт малтмалыг түлхүү олборлодог. Мөн байгалийн хий, нефтийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлээр дэлхийд тэргүүлэгчдийн нэг юм. ОХУ-ын ашигт малтмалын олборлолтын дийлэнх хэсэг нь дотоодын хэрэглээнд зориулагддаг бол байгалийн хий нефтийн бүтээгдэхүүний ихэнх хэсгийг экспортолдог.

ОХУ нүүрсний нөөцөөрөө дэлхийд 2-д, нүүрсний үйлдвэрлэлээрээ дэлхийд 6-д бичигддэг. 2000 оноос өмнө ОХУ-ын нүүрсний салбар уналттай байсан бол түүнээс хойш тогтворжиж сэргэж иржээ. 2020 онд ОХУ-ын нүүрс олборлох хүчин чадал 508 сая тонн байсан ба 402.1 сая тонн нүүрс үйлдвэрлэсэн бөгөөд нийт үйлдвэрлэлийн 49.2%-ийг экспортолжээ.


Зураг 12. ОХУ-ын нүүрсний үйлдвэрлэл, сая тонн



Эх сурвалж: ОХУ-ын Эрчим хүчний яам, Олон улсын эрчим хүчний агентлаг

Сүүлийн 20 жилд ОХУ-ын нүүрсний экспорт 5 дахин өссөн бөгөөд 2020 онд 197.9 сая тонн, 12.4 тэрбум ам.долларын үнэ бүхий нүүрс экспортолсон. БНХАУ, БНСУ, Япон, Турк, Тайвань зэрэг улсууд ОХУ-аас авсан нүүрсний импортоор тэргүүлж байна. Сүүлийн 20 жилд БНХАУ болон БНСУ-ын ОХУ-с авч буй нүүрсний импорт хурдацтай өссөн. 2020 онд БНХАУ 29.4 сая тонн, 1.9 тэрбум ам.долларын үнэ бүхий нүүрс ОХУ-аас импортолжээ.


Зураг 13. ОХУ-ын нүүрсний экспорт, улсаар, сая тонн



Эх сурвалж: Олон улсын худалдааны байгууллага, trademap.org


2015 оноос хойш ОХУ-ын нүүрсний экспортын нийт экспортод эзлэх хувь өсөж эхэлсэн бөгөөд 2020 онд нүүрсний экспорт нь нийт экспортын орлогын 3.7%-ийг бүрдүүлсэн.

Зураг 14. ОХУ-ын нүүрсний экспортын нийт экспортод эзлэх хувь



Эх сурвалж: Олон улсын худалдааны байгууллага, trademap.org

Зураг 15. ОХУ-ын экспортолсон нүүрсний дундаж үнэ, ам.доллар/тонн



Эх сурвалж: Олон улсын худалдааны байгууллага, trademap.org

ОХУ-д нүүрсний салбар бусад уул уурхайн салбаруудтай харьцуулахад харьцангуй жижигт тооцогддог. 2016 онд нийт уул уурхайн салбарын ДНБ-д эзлэх хувь хэмжээ 9.7% байсан бөгөөд 2020 онд энэхүү хувь хэмжээ 9.8% буюу нэлээд тогтвортой байна. Харин 2016 онд нүүрсний олборлолт ОХУ-ын ДНБ-ий 0.5%-ийг бүрдүүлж байсан.

ОХУ нь 2019 онд агаар дахь хүлэмжийн хийг бууруулах Парисын гэрээнд нэгдсэн бөгөөд нүүрсхүчлийн хийн ялгаруулалтыг бууруулах хэд хэдэн бодлого тодорхойлсон. Гэхдээ тус бодлогод нүүрсний салбарын үйлдвэрлэлийг бууруулах чиглэлийн бодлого хараахан тусгагдаагүй. ОХУ нь нүүрсний салбар, тэр дундаа нүүрсний экспортыг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлого баримталж байна. Тухайлбал, 2035 он хүртэл нүүрсний салбараа үргэлжлүүлэн хөгжүүлж, дотоодын нүүрсний хэрэгцээг бүрэн хангах, экспортын хэмжээгээ нэмэгдүүлэх, тэр дундаа Ази, Номхон далайн бүс нутгийн орнуудад нийлүүлэх төлөвлөгөөтэй байна. Экспортын хүчин чадлыг нэмэгдүүлэхийн тулд тулд төмөр замын сүлжээгээ өргөтгөж байгаа. Тухайлбал, Одоогийн байдлаар ОХУ-ын баруун хэсгийг Номхон далайтай холбосон Хаант засгийн үеийн Транссибирийн төмөр зам болон Зөвлөлтийн үеийн Байгаль-Амарын гол шугам гэсэн хамгийн урт хоёр төмөр замыг өргөтгөх 720 тэрбум рублийн (9.8 тэрбум ам. доллар) төсөл хэрэгжүүлж байна. Тус төсөл нь 2024 он гэхэд нүүрс болон бусад бараа бүтээгдэхүүний тээвэрлэх хүчин чадлыг жилд 182 сая тоннд хүргэх болно. (Fedorinova & Quinn, 2021). ОХУ мөн гангийн үйлдвэрлэлд ашиглагдах нүүрсний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхээр төлөвлөж байгаа аж. ОХУ-

ын томоохон нүүрсний уурхайн нэг болох Элга -д 130 тэрбум рублийн хөрөнгө оруулалт хийж 2023 он гэхэд нүүрсний олборлолтын хэмжээг 45 сая тоннд хүргэхээр төлөвлөж байна.

ОХУ-ын ашигт малтмалын хуулиуд

ОХУ-д уул уурхайн үйл ажиллагааг дараах хуулиудаар зохицуулдаг. Үүнд:

- Газрын хэвлийн тухай хууль. 1992 оны 2 сарын 21-ий өдөр батлагдсан бөгөөд 7 бүлэг, 52 зүйлтэй. Газрын хэвлийн тухай хуульд газрын хэвлийн баялгийг хайх, үнэлэх, хайх, ашиглах, хамгаалах үндсэн нөхцөлийг тусгасан.
- Үнэт металл, үнэт чулууны тухай хууль. 1998 оны 3 сарын 26-ны өдөр батлагдсан бөгөөд 9 бүлэг, 32 зүйлтэй. Үнэт металл, үнэт чулууны тухай хуульд үнэт металл, эрдэнийн чулууг боловсруулах, ашиглах, устгах эрх зүйн ерөнхий зохицуулалтыг тусгасан.
- Бүтээгдэхүүн хуваах гэрээний тухай хууль. 1995 оны 12 сарын 19-нд батлагдсан бөгөөд 3 бүлэг, 26 зүйлтэй. Газрын хэвлийг ашиглах, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны чиглэлээр ОХУ-ын хууль тогтоомжийг боловсронгуй болгох зорилгоор батлагдсан энэхүү хууль нь ашигт малтмалын хайгуул хийх, үйлдвэрлэхэд гадаадын хөрөнгө оруулалт хийгдэж буй тохиолдлын үед үүсэх харилцааны эрх зүйн орчныг тогтоодог.
- ОХУ-ын эх газрын тухай хууль (О континентальном шельфе Российской Федерации). 1995 оны 11 сарын 30-нд батлагдсан, 8 бүлэг, 49 зүйлтэй. Энэхүү хууль нь ОХУ-ын эх газрын статус, ОХУ-ын эх газрын дээрх бүрэн эрх, харьяалал, ОХУ-ын олон улсын гэрээг ОХУ-ын Үндсэн хууль, олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, хэм хэмжээний дагуу хэрэгжүүлэхийг тодорхойлдог.
- Улс орны батлан хамгаалах, төрийн аюулгүй байдлыг хангах стратегийн ач холбогдол бүхий аж ахуйн нэгжид гадаадын хөрөнгө оруулалт хийх журмын тухай" хууль (стратегийн хөрөнгө оруулалтын тухай хууль). 2008 оны 4 сарын 29-нд батлагдсан бөгөөд 1 бүлэг, 17 зүйлтэй. Энэхүү хууль нь улс орны батлан хамгаалах, стратегийн ач холбогдол бүхий аж ахуйн нэгжийн дүрмийн санг бүрдүүлдэг хувьцааг (хувьцааг) олж авах хэлбэрээр гадаадын хөрөнгө оруулагчид эсвэл хэсэг бүлэг хүмүүс хөрөнгө оруулалт хийхтэй холбогдсон харилцааг зохицуулдаг.
- Татварын хууль. 1998 оны 7 сарын 17-нд батлагдсан бөгөөд 31 бүлэг, 398 зүйлтэй. Тус хуулийн 26-р бүлэгт уул уурхайн бүтээгдэхүүнүүдийн татварын хэмжээ, тооцох аргачлал, бусад зохицуулалтыг тусгасан байдаг.

ОХУ-ын уул уурхайн салбарын зохицуулах байгууллагууд

- “Байгалийн нөөц, экологийн яам” нь уул уурхайн үйл ажиллагаанд хамаарах тусгай зөвшөөрлийн дэглэмийг удирдаж, уул уурхайн салбарыг зохицуулдаг агентлаг, бусад эрх бүхий байгууллагын ажилд хяналт тавьдаг.
- “Холбооны газрын хэвлийн ашиглалтын агентлаг” нь улсын геологийн судалгаа, газрын хэвлийг ашиглах эрхийн тендер, дуудлага худалдаа зохион байгуулах, газрын хэвлийн тусгай зөвшөөрөл олгох, хүчингүй болгох, газрын хэвлий дэх геологийн мэдээлэл, улсын ордуудын кадастрын бүртгэлийг хөтөлдөг.
- “Байгалийн менежментийн холбооны хяналтын алба” нь газрын хэвлийн тусгай зөвшөөрөл эзэмшигчид газрын хэвлийн ашиглалтын тусгай зөвшөөрлийн нөхцөлийг дагаж мөрдөж байгаа эсэхэд хяналт тавьж, байгаль орчныг хамгаалах, газрын хэвлийг зохистой ашиглахад хяналт тавьж, газрын хэвлийн тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд тогтмол аудит хийдэг.
- “Экологи, технологи, цөмийн хяналтын холбооны алба” нь газрын хэвлийн ашиглалтын чиглэлээр үйлдвэрлэлийн аюулгүй байдал, экологийн стандартыг дагаж мөрдөж байгаа

эсэхэд хяналт тавьж, холбооны түвшинд экологийн шинжээчийн дүгнэлт хийж, газрын хэвлийн лиценз эзэмшигчдэд тогтмол аудит хийдэг.

ОХУ-ын нүүрсний АМНАТ

ОХУ-д АМНАТ-ыг Уул уурхайн олборлолтын татвар хэлбэрээр авдаг ба ОХУ-ын нүүрсний компаниуд 2020 онд 12.4 тэрбум рублийн, 2021 оны эхний 3 улиралд 10.6 тэрбум рублийн АМНАТ төлсөн. Энэ нь нүүрсний компаниудын төлсөн нийт татварын 2020 онд 51%, 2021 оны эхний 3 улиралд 16.7%-ийг тус тус эзэлж байна. Цаашилбал, нийт уул уурхайн салбар 2020 онд 5.4 их наяд, 2021 оны эхний 3 улиралд 6.9 их наяд рублийн АМНАТ төлсөн байна.

АМНАТ нь татварын хуулиар зохицуулдаг бөгөөд АМНАТ-ийн хувь хэмжээ нь нүүрсний олборлолтын тоо хэмжээн дээр тулгуурладаг. Нүүрсний төрөл тус бүрээр нэг тонн нүүрсний олборлолтод тодорхой хэмжээний рублийн татварыг оногдуулдаг. Татвар төлөгч компани нь татвар төлөх нүүрсний хэмжээгээ өөрсдөө тодорхойлох бөгөөд, нийт олборлосон нүүрснээс бодит алдагдал, хаягдлуудаа хасаж тодорхойлдог.

Хүснэгт 9. ОХУ-ын нүүрсний АМНАТ, нүүрсний төрлөөр

Нүүрсний төрөл	АМНАТ-ийн хэмжээ, рубль тонн тутамд	Дефлятор /2018 оны III улиралд/	Нэг тонн нүүрсэнд ногдох татварын хэмжээг тооцоолох томьёо
Антрацит	47	1.134	47 рубль*1.134
Хүрэн нүүрс	11	1.006	11 рубль*1.006
Коксжих нүүрс	1	Тусгай коэффициент	1 рубль * тусгай коэффициент
Бусад нүүрс	24	1.021	24 рубль*1.021

Антрацит, хүрэн нүүрс, бусад нүүрсний татварын хэмжээг дефлятор буюу нүүрсний үнийн өөрчлөлттэй уялдсан параметрээр үржүүлснээр нэг тонн нүүрсэнд ногдох татварын хэмжээ гардаг. Тус дефляторыг өмнөх улирлын нүүрсний үнийн динамиктай уялдуулан Засгийн газраас улирал тутам тогтоосон журмын дагуу тооцож, баталдаг.

Коксжих нүүрсний татварын хэмжээг (1 рубль) Австралийн нүүрсний сарын дундаж үнэтэй уялдсан коэффициентоор үржүүлж эцсийн татварын хэмжээг тооцоолдог. Томьёог доор харуулав. Энд тухайн татварын хамрах хугацааны дундаж Австралийн нүүрсний үнийг ашигладаг (SGX TSI FOB Australia Premium Coking Coal OTC Futures/Options). Хэрэв Австралийн нүүрсний сарын дундаж үнэ тонн тутамд 100 ам.доллороос бага байвал энэ коэффициент нь шууд рублийн ам.доллартой тэнцэх ханшаар тооцогдоно. Коксжих нүүрсний тусгай коэффициентыг сар бүрийн 10-ны дотор холбогдох төрийн байгууллагаас тооцоолж, нийтэлдэг.

$$\text{Коксжих нүүрсний тусгай коэффициент} = \frac{\text{Австралийн нүүрсний FOB үнэ}}{\text{Рублийн ам.доллартой харьцах ханш}} * 1.5\%$$

Дээрх томьёоноос харвал, Австралийн коксжих нүүрсний үнэ 100 ам.доллороос давсан үед Оросын компаниудын экспортын үнэ Австралийн коксжих нүүрсний үнэтэй ойролцоо бол үнийн дүнгийн 1.5%-тай дүйцэх АМНАТ төлнө гэсэн үг. Хэрвээ дэлхийн зах зээл дээрх коксжих

нүүрсний үнэ өндөр үед компаниуд нүүрсээ Австралийн коксжих нүүрснээс 50% хямд өгвөл компаниудын төлөх АМНАТ-ийн бодит түвшин нь үнийн дүнгийн 3.0%-тай дүйнэ гэсэн үг. Энэ нь компаниудыг нүүрсээ аль болох өндөр үнээр борлуулах хөшүүрэг болно. Мөн дэлхийн зах зээлд нүүрсний үнэ хямдарч 100 ам.доллараос бага болбол АМНАТ-ийн хэмжээ нь экспортын орлогын 1%-тай тэнцэнэ. Уг татварын хэмжээг ам.долларын ханштай уясан учраас төсвийн орлогыг валютын ханшийн хэлбэлзлээс мөн сэргийлнэ.

ОХУ-ын татварын тогтолцоо нь холбооны, мужийн болон орон нутгийн татвар гэсэн шатлалтай байдаг ба уул уурхайн компаниуд АМНАТ-ийг Холбооны татварын байгууллагад тушаадаг. Татварыг сар бүр төлөх бөгөөд тайлант хугацааны дараагийн сарын 25-ны өдрийн дотор төлөх ёстой. Ашигт малтмалын лиценз шинээр авсан хуулийн этгээд 30 хоногийн дотор татвар төлөгчөөр бүртгүүлж, нүүрс олборлож эхэлмэгц татвараа төлнө.

Нүүрсний компаниуд аюулгүй нөхцөл, хөдөлмөр хамгааллыг хангахтай холбоотой зардал гаргавал тэрхүү зардлыг тооцоолсон АМНАТ-ийн хэмжээнээс хасах буюу татварын хөнгөлөлт үзүүлдэг. Татварын хөнгөлөлт дээд хязгаартай ба түүнийг ОХУ-ын Засгийн газар тогтоодог.

Хүснэгт 10. ОХУ-ын бусад ашигт малтмалуудын АМНАТ

Ашигт малтмал	Татвар оногдуулах хувь	Тайлбар
Зэс	6.5%-8%	Борлуулалтын орлогоос тогтоосон хувь хэмжээгээр татвар авна. Татварын хувь хэмжээ нь зэсийн боловсруулалтын түвшин болон тухайн уул уурхайн компанийн байрлаж буй мужаас шалтгаалан бага зэрэг өөр, өөр байдаг.
Алт	6%	Борлуулалтын орлогоос тогтоосон хувь хэмжээгээр татвар авна.
Төмрийн хүдэр	1 тонн тутамд 1 рубль	Олборлосон төмрийн хүдрийн нэг тонн тутамд 1 рублийн татвар оногдуулах бөгөөд тус татварын хэмжээг 62%-ийн агуулгатай төмрийн хүдрийн үнийн өөрчлөлтөөс хамаарах коэффициентоор үржүүлдэг. $SGX\ TSI\ Iron\ Ore\ CFR\ China$ үнийг ашигладаг. Коэффициент = Хятадын төмрийн хүдрийн үнэ * 4.8% * (ОХУ-ын төмрийн хүдрийн агуулга, 62%) * рублийн ам.доллартой харьцах ханш

ОХУ-ын нүүрсний компаниудын төлдөг бусад татварууд

ОХУ-ын хувьд нүүрсний АМНАТ нь бусад улс орнуудтай харьцуулахад бага бол нүүрсний компаниудын төлдөг бусад төрлийн татварууд ч харьцангуй багад тооцогдоно.

ОХУ Дэлхийн худалдааны байгууллагад 2012 онд элссэнээр хүлээсэн амлалтынхаа дагуу сүүлийн жилүүдэд олон төрлийн ашигт малтмалын (алт, цагаан алт, **нүүрс**, никель, зэс гэх мэт) экспортын татвараа цуцалсан. Өөрөөр хэлбэл, нүүрс экспортлогчид экспортын татвар төлөхгүй. Харин вольфрам болон ихэнх ашигт малтмалын хаягдалд (жишээлбэл, хөнгөн цагааны хаягдал) оногдуулах экспортын татвар хэвээр байгаа.

Хүснэгт 11. ОХУ-ын нүүрсний компаниудын төлдөг бусад төрлийн татварууд

Татварын төрөл	Татварын нэр	Татварын хувь хэмжээ
Холбооны татвар	Орлогын албан татвар	20%
	НӨАТ	Экспорт -0% Дотоодын борлуулалт-20%
	Хувь хүний орлогын албан татвар	13%
	Усны татвар	0%
Бүс нутгийн татвар	Аж ахуйн нэгжийн хөрөнгийн татвар	2.2%
Орон нутгийн татвар	Газрын татвар	1.5%
Салбарын татвар	Газрын хэвлий ашигласны төлбөр	Ашигт малтмалын олборлолтоос бусад зориулалтаар газрын хэвлийг ашигласны төлбөрийг геологийн процессын үе шат бүрд тусад нь тогтооно. Энэхүү төлбөрийн газрын төрөл, байршлаас хамааруулан эрх бүхий байгууллагаас тогтоодог. Тогтмол төлбөрийг улирал бүр төлдөг.

ОХУ-ын нүүрсний АМНАТ-ийн бодлого

Тус улсын нүүрсний АМНАТ нь 2011 он хүртэл борлуулалтын орлогын 4% байсан бөгөөд 2012 оноос хойш олборлосон тонн тутамд татвар оногдуулдаг болсон. Энэ нь нүүрсний салбарыг дэмжих бодлоготой холбоотой юм. Жишээлбэл, 2014 онд нүүрсний АМНАТ тонн тутамд антрацит 45 рубль, коксжих нүүрс 57 рубль, хүрэн нүүрс 14 рубль, бусад нүүрс 24 рубль тус тус байжээ. Үүнээс хойш коксжих нүүрсэнд ногдох АМНАТ-ийн хэмжээг Австралийн нүүрсний үнэтэй уялдуулсан коэффициентоор үржүүлдэг болсныг дээр дурдсан билээ.

ОХУ-ын Засгийн газар 2019 онд нүүрсний АМНАТ-д дэлхийн зах зээлийн үнээс хамаарсан прогрессив тогтолцоог нэвтрүүлэх талаар судалж байсан боловч хараахан нэвтрүүлээгүй байна. Мөн 2022-2024 оны Татвар, төсвийн бодлогод коксжих нүүрсний салбарын АМНАТ-ын хэмжээг тогтмол хувь хэмжээтэй тогтоох, түүнийгээ дэлхийн зах зээлийн үнэтэй холбох зэрэг өөрчлөлтүүд хийхээр төлөвлөж байгаа ажээ.

АМНАТ болон бусад төрлийн татваруудыг зарим мужид арай бага хэмжээтэй тогтоодог. Тухайлбал, Магадан мужид татварын хувь хэмжээг 40 хувиар бага тооцдог буюу тооцоолсон татварыг 0.6 коэффициентээр үржүүлж урамшуулал үзүүлдэг. Бүтээгдэхүүн хуваах гэрээний горимоор ашигт малтмал олборлож буй компаниудын татварыг 50% хөнгөлөх буюу тооцоолсон татварыг 0.5-аар үржүүлж татвар төлдөг.

2.4. Бүгд Найрамдах Хятад Ард Улсын АМНАТ-ийн тогтолцоо

БНХАУ-ын уул уурхайн салбарын статистик

БНХАУ-д 2020 оны байдлаар нийт 173 төрлийн ашигт малтмалын орд илэрсэн бөгөөд үүний дотор эрчим хүчний 13 төрлийн ашигт малтмал, 59 төрлийн металл, 95 төрлийн металл бус ашигт малтмал, 6 төрлийн шингэн болон хий орд байна. Тус улсын нүүрсний нөөц нь 162.3 тэрбум тонн. Нүүрсний нөөцийн 30 гаруй хувь нь Шинжаан Уйгурын өөртөө засах улсад байдаг.

БНХАУ-ын 2020 оны нөөцийн татварын орлого 175 тэрбум 500 сая юань болж, өнгөрсөн оны мөн үеийнхээс 3.7%-аар буурсан бөгөөд улсын нийт татварын орлогын 1.1%-ийг бүрдүүлж байна. Уурхайн эрх шилжүүлснээс олсон орлого 112 тэрбум 320 сая юань болж, 19.3%-аар өсөж, хайгуулын болон олборлох эрхийн төлбөр 2.85 тэрбум юань болж, 20.9%-аар буурчээ.

Хүснэгт 12. Хятадын нийт нүүрсний олборлолт ба дундаж үнэ

	2015	2016	2017	2018	2019	2020
Олборлолт, сая тонн	3746.5	3410.6	3523.6	3697.7	3846.3	3902.0
БНХАУ-ын Чинхуандаогийн спот үнэ, ам.доллар/тонн	67.53	71.35	94.72	99.45	85.89	83.10

Эх сурвалж: ВР

2020 онд БНХАУ 4.08 тэрбум тонн анхдагч эрчим хүчний бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 4.98 тэрбум тонныг хэрэглэжээ. Эрчим хүчний хэрэглээнд нийт нүүрс 56.8%-ийг эзэлж байна. БНХАУ 2020 онд 3.9 тэрбум тонн нүүрс олборлосон нь өмнөх оны мөн үеэс 1.4%-аар өсөж, 4.3 тэрбум тонн нүүрс хэрэглэсэн нь өнгөрсөн оноос 0.6%-аар өссөн байна.

Хүснэгт 13. БНХАУ-ын мужуудын нүүрс олборлолт сая тн

Муж	2021	2020	2019	2018	2017
Shanxi	1193	1063	971	893	854
Inner Mongolia	1039	1001	1035	926	879
Shaanxi	700	679	634	623	570
Xinjiang	320	266	238	190	167
Guizhou	131	119	130	139	166
Anhui	113	111	110	115	117
Henan	93	105	109	114	117
Shandong	93	109	119	122	129
Ningxia	86	82	72	74	74
Heilongjiang	60	52	52	58	54
Yunnan	58	53	48	45	44

Эх сурвалж: БНХАУ-ын Үндэсний статистикийн газар

БНХАУ-ын уул уурхайн бодлого, зохицуулалт

Засгийн газрын бодлого

БНХАУ-ын Төрийн зөвлөл 2019 оны 6-р сард "Эрх мэдлийг шилжүүлэх, төрийн үйлчилгээг оновчтой болгох, үүнд чиглэсэн шинэчлэл"-д анхаарлаа хандуулж байгаагаа дахин илэрхийлэв. Энэхүү бодлогыг уул уурхайн салбарт хэрэгжүүлэхдээ хөрөнгө оруулалтын үйл явцыг хялбарчлах, удирдлагын тогтолцоог шинэчлэх, уул уурхайн бүтээгдэхүүний чөлөөт худалдааг хангах зорилт тавьжээ.

БНХАУ-ын Байгалийн нөөцийн яам (БНЯ) 2019 оны 12-р сарын 31-нд БНХАУ-ын эрдэс баялгийн удирдлагын тогтолцоог цаашид шинэчлэх зорилгоор “Эрдэс баялгийн менежментийн шинэчлэлийг дэмжих тухай (туршилт хэрэгжүүлэлт) санал дүгнэлт”-ийг гаргасан. Энэхүү санал дүгнэлтийг 6 мужид 2 жилийн турш хэрэгжүүлсэн туршилтад үндэслэсэн. Дүгнэлт нь 2020 оны 5-р сарын 1-ээс хэрэгжиж эхэлсэн бөгөөд 3 жилийн хугацаанд хүчинтэй байна. Санал дүгнэлт (Opinion)-ийн гол онцлог:

- Олборлолтын эрхийг зөвхөн олон нийтийн тендер эсвэл сонгон шалгаруулалтын журмаар Засгийн газар олгоно. Төрийн зөвлөлөөс баталсан гол бүтээн байгуулалтын төслүүд болон газрын ховор элемент, цацраг идэвхт бодис хайх, олборлохтой холбоотой төслүүдэд олборлолтын эрхийг БНЯ гэрээгээр олгохыг зөвшөөрдөг.
- Газрын тос, байгалийн хий, занарын хий (shale gas), байгалийн хийн гидрат (natural gas hydrate), цацраг идэвхт ашигт малтмал, вольфрам (tungsten), газрын ховор элемент, цагаан тугалга (tin), сурьма (antimony), молибден (molybdenum), кобальт (cobalt), лити (lithium), леопольдит (leopoldite) зэрэг нь БНЯ-д бүртгэгдсэн байх ёстой.
- Бусад ашигт малтмалын олборлолтын эрхийг муж эсвэл доод шатны засаг захиргаанд бүртгүүлэх ёстой.
- Хайгуул хийх эрхийн хугацааг 3 жил байсныг 5 жил болгон сунгасан. Сунгах хугацаа нь 5 жил юм.
- Өргөдөл гаргагч нь хайгуул, олборлолтын үйл ажиллагаа явуулахын тулд уул уурхайн аюулгүй байдал, байгаль орчныг хамгаалах шаардлагыг хангасан, олборлолт, хайгуулын техникийн хангалттай чадавхыг эзэмшсэн байх ёстой.
- Өмнө нь газрын тос, байгалийн хийн хайгуулын эрх, олборлох эрхийг хоёр өөр системээр зохицуулдаг байсан бөгөөд хайгуулчид тус тусад нь өргөдөл гаргах ёстой байсан. Санал дүгнэлтийн зааврын дагуу хайгуулчид газрын тос, байгалийн хийн эдийн засгийн хувьд нөхөгдөх боломжтой нөөц олсон тохиолдолд эрх бүхий удирдлагуудад мэдэгдсэний дараа олборлолтын үйл ажиллагаагаа эхлүүлж болно.

Хайгуулын эрх (Prospection rights) нь судалгаа, хайгуулын эрх гэсэн ойлголттой төстэй. **Олборлох** эрхийг өргөдөл гаргагчид нээлттэй тендер эсвэл тендерийн санал болгох үйл явцаар дамжуулан олгодог. Ашигт малтмалын олборлох эрхийг шилжүүлэх журмын төсөлд (2019 оны 3-р сар) заасны дагуу дараах гурван онцгой тохиолдолд олборлох эрхийг нийтийн болон сонгон шалгаруулалтгүйгээр олгож болно:

- Төрийн зөвлөл уурхайд хайгуул хийх тодорхой этгээдийг сонгосон бөгөөд энэ тохиолдолд БНЯ-д гэрээгээр олборлох эрхийг шилжүүлэхийг зөвшөөрнө.
- Хайгуулын зардлыг улсын төсвөөс гаргасан
- Хайгуул хийж илрүүлсэн орддоо хайгуулч олборлолтын эрхийн өргөдөл гаргасан

Зохицуулалтын хүрээ

Уул уурхайн салбарыг дараах хууль тогтоомжийн хүрээнд зохицуулж байна. Үүнд:

- Ашигт малтмалын тухай хууль 2009 он
- Ашигт малтмалын тухай хуулийг хэрэгжүүлэх журам 1994 он
- Ашигт малтмалын хайгуулын 2014 оны блок бүртгэлийн захиргааны арга хэмжээ
- Ашигт малтмалын хайгуулын зөвшөөрөл, бүртгэлийн үйл ажиллагааг цаашид зохицуулах тухай Газар, баялгийн яамны 2017 он
- Ашигт малтмалын ашиглалтын бүртгэлийн захиргааны арга хэмжээ 2014 он
- Ашигт малтмалын нөхөн олговор цуглуулах удирдлагын тухай заалт 1997 он

- Эрдэс баялгийн тухайн оны төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх арга хэмжээ
- Ашигт малтмалын хайгуулын эрх, ашиглалтын эрхийг шилжүүлэх захиргааны арга хэмжээ 2014 он

Холбогдох зохицуулалтын байгууллагууд нь:

- Байгалийн нөөцийн яам
- Үндэсний хөгжил шинэчлэлийн хороо
- Экологи, Байгаль орчны яам (ЭБЯ)
- Худалдааны яам
- Төрийн татварын алба
- Онцгой байдлын яам
- Үндэсний эрүүл мэндийн комисс
- Төрийн зөвлөлийн Гаалийн тарифын комисс

Хайгуул, олборлолтод хамаарах татвар, төлбөр

Уул уурхайн эрх эзэмшигчдийн засгийн газарт төлдөг үндсэн төлбөрт дараах зүйлс орно.

- **АМНАТ (mineral royalties).** Төрөөс ашигт малтмал олборлох эрх (хайгуул хийх, олборлох эрх гэх мэт) авсан этгээд АМНАТ төлөгч байна. АМНАТ нь:
 - Ашигт малтмалын уул уурхайн эрхийг дуудлага худалдаа, олон нийтийн болон сонгон шалгаруулалтаар олгосон тохиолдолд ялсан оролцогчийн санал болгосон үнэ.
 - Зөвшөөрөл эзэмшигч болон эрх бүхий байгууллагын хооронд бичгээр тохиролцсоны үндсэн дээр уул уурхайн эрхийг олгосон тохиолдолд уул уурхайн эрхийн үнэлгээ ба ижил нөхцөлтэй уул уурхайн эрхийн зах зээлийн жишиг үнэ (аль өндрөөр нь авна).
- **Хайгуулын эрхийн хураамж.** Эхний 3 жилд зөвшөөрөл эзэмшигч нь жил бүр км² тутамд 100 юань төлнө, 4 дэх жилээс эхлэн жил бүр 100 юаниар нэмэгдэнэ. Жилийн төлбөрийн дээд хэмжээ хавтгай дөрвөлжин км тутамд 500 юань.
- **Олборлох эрхийн төлбөр.** Энэ төлбөр нь жилд км² тутамд 1000 юань.
 - “Ашигт малтмалын эрх олгох дэглэмийг шинэчлэх төлөвлөгөө”-ний хүрээнд хайгуулын эрхийн төлбөр, олборлолтын эрхийн төлбөрийг ашигт малтмалын үнэ, эдийн засгийн хөгжлийн хэрэгцээнд тулгуурлан динамик тохируулга хийх боломжтой “уул уурхайн хураамж”-аар орлуулах юм.
- **Нөөцийн татвар (Resource tax).** Зарим ашигт малтмалын нөөцийн татварын үндсэн хувь хэмжээг дараах байдлаар тогтоосон.
 - Газрын тос: Нийт борлуулалтын 6%
 - Байгалийн хий: Нийт борлуулалтын 6%
 - **Коксжих нүүрс болон бусад нүүрс: Нийт борлуулалтын 2-10%**
 - Төмөр (баяжмал): Нийт борлуулалтын 1-9%
 - Алт (гулдмай): Нийт борлуулалтын 2-6%
 - Зэс, никель (баяжмал): Нийт борлуулалтын 2-10%
 - Графит (баяжмал): 3-12%
 - Диатомит (баяжмал): 1-12%
 - Каолин (хүдэр): 1-12%
- **НӨАТ.** Сангийн яам, Татварын албаны шийдвэрээр 2018 оны 5-р сарын 1-ээс ашигт малтмалын төрөл, бүтээгдэхүүнээс хамаарч 10% ба 16% болсон. Урьд нь энэ хязгаар 11% ба 17% байсан. Одоогоор Монголоос авах нүүрсний импортод НӨАТ 13% ноогдуулдаг.
- **Хот байгуулалт, барилгын татвар (City maintenance and construction tax).** Хотод байрладаг бүх ААН татвар ногдох цэвэр орлогын 7%, бусад суурин газар 5%, хөдөөд 1%.

- **Газар ашиглалтын татвар (Land use tax).** Уурхайн хашаа, агуулах, овоолго хаягдал, хүдэр тээвэрлэх замын талбай энэ татвараас чөлөөлөгдөнө. Бусад ашиглаж буй газрын татвар км2 тутамд:
 - Том хот: 1.5-30 юань
 - Дунд зэргийн хот: 1.2-24 юань
 - Жижиг хот: 0.9-18 юань
 - Бусад суурин, тосгон, уурхайн бүс: 0.6-12 юань
- **ААНОАТ (Corporate income tax).** Татвар ногдох орлогын 25%, гадаадын ААН бол 20%.
- **Боловсролын татвар (Education surcharges).** Бүх ААН төлөх ёстой. Улсынх 3% + орон нутгийнх 2%. Шууд бус татварт (компанийн төлсөн НӨАТ, бизнесийн татварууд, тансаг ба онцгой хэрэглээний татвар зэрэгт) суурилна.
- **Гаалийн татвар (Customs duties).** Экспорт, импортын үйл ажиллагаа эрхлэгчдэд ногдуулна. 2020 оны баталсан “Catalogue of Commodities subject to the Administration of Export Licenses” жагсаалтаар, нүүрс, газрын тос, шатахуун экспортлогчид экспортын квот авч байж экспортын зөвшөөрөл хүсэх ёстой. Бусад уул уурхайн экспортлогчид квот авалгүй экспортын зөвшөөрөл хүсэх боломжтой

БНХАУ-ын зохицуулалтын дэлгэрэнгүй

БНХАУ-ын хууль тогтоомжийн дийлэнх нь хууль батлагдахаасаа өмнө хэд хэдэн удаа туршилтын хэрэгжилт, санал дүгнэлт авсан байдаг. Батлагдсан ч гэсэн заримдаа хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулдаг. Хууль тогтоомжоос гадна хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой зохицуулалтууд байнга өөрчлөгддөг. Ямар хууль тогтоомж хүчин төгөлдөр хэвээр байгаа, хүчингүй болсныг мэдэхэд хэцүү.

Ашигт малтмалын тухай хууль

Ашигт малтмалын тухай хууль (АМТХ) нь БНХАУ-ын нутаг дэвсгэрт ашигт малтмал хайх, олборлох, ашиглах эрхийн бүртгэлийн үйл ажиллагааг зохицуулдаг. Уг хуулийг 1986 оны 3-р сарын 19-ний өдөр Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн Их Хурлын Байнгын хорооноос баталж, 1996, 2009 онд тус тус нэмэлт өөрчлөлт оруулсан. 2019 оны 12-р сарын 17-ны өдөр Байнгын хороо болон Байгалийн нөөцийн яам АМТХ-ийн шинэчилсэн найруулгын төслийг олон нийтийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн. Санал өгөх хугацаа 2020 оны 1-р сарын 15-нд дууссан. Энэ нэмэлт өөрчлөлтийн төслийг БХАТИХ-ын Байнгын хороонд хэзээ оруулж хэлэлцүүлж, санал авах нь одоогоор тодорхойгүй байна.

Ашигт малтмалын эрх олгох үндсэн арга нь олон нийтийн тендер буюу дуудлага худалдаагаар явагдахыг нэмэлт, өөрчлөлтийн төсөлд онцолсон. Төсөлд уул уурхайн талбайн экологийн нөхөн сэргээлтийн талаар тодорхой бүлэг нэмж, хариуцах талууд, нөхөн сэргээх хөрөнгийн эх үүсвэрийг мөн зааж өгсөн. Өөр нэг томоохон дэвшил бол төрийн өмчит уурхай, иргэдийн өмчит уурхай, хувийн компанийн эзэмшиж буй уурхайнуудын өөр өөр журмыг хүчингүй болгож, бүх өргөдөл гаргагч болон эрх эзэмшигчид нэгдсэн дүрэм үйлчилдэг болно.

АМНАТ (mineral royalties)

Ашигт малтмалын эрхийг шилжүүлсний орлогыг төр, орон нутаг 40:60 харьцаатай хувааж авдаг. Орлогыг өгөөжийн хэмжээгээр тодорхойлж, олборлолтын явцад жил бүр цуглуулдаг. Орлогын тооцооны томъёо нь:

$$\begin{array}{ccccc} \text{Ашигт малтмалын эрх} & & \text{Ашиглалтын эрх} & & \text{ашигт малтмалын} \\ \text{шилжүүлсний жилийн} & = & \text{шилжүүлсний өгөөжийн} & * & \text{бүтээгдэхүүний жилийн} \\ \text{орлого} & & \text{хувь хэмжээ} & & \text{борлуулалтын орлого} \end{array}$$

Газрын тос, байгалийн хий зэрэг Байгалийн нөөцийн яамны хариуцдаг ашигт малтмалын хувьд олборлолтын эрхийн шилжүүлгийн орлогын зах зээлийн жишиг үнэ, шилжүүлгийн орлогын жишиг хувь хэмжээ, төлбөрийг хэсэгчлэн тооцох нэгдсэн стандартыг Газрын нөөцийн яам гаргаж болно.

Нөөцийн татварын хууль

БНХАУ байгуулагдсан цагаас хойш 1986 он хүртэл БНХАУ-ын байгалийн баялгийг чөлөөтэй ашигладаг байсан. 1982 онд БНХАУ "Далайн газрын тосны нөөцийг ашиглахад гадаад хамтын ажиллагааны тухай журам" гаргасан. Ингэснээр төрийн өмчийн баялгийг төлбөртэй ашиглах үе шат эхэлсэн. БНХАУ-ын нөөцийн татварын шинэчлэлийн түүхийг доорх хүснэгтэд харуулав.

Хүснэгт 14. БНХАУ-ын нөөцийн татварын хуулийн шинэчлэл

Огноо	Бодлого, дүрэм журам	Агуулга
1984 оны 10-р сар	БНХАУ-ын Нөөцийн албан татварын тухай хууль (төсөл)	Нүүрс, газрын тос, байгалийн хийн нөөц, борлуулалтын орлогыг татварын суурь болгох, илүү хувь хэмжээг шат дараатай төвлөрүүлэх ажлыг хэрэгжүүлэх.
1986 оны 1-р сар	БНХАУ-ын Ашигт малтмалын тухай хууль	Төлбөртэй ашигт малтмалын олборлолтыг эхлүүлэхийн зэрэгцээ баялгийн татвар, хураамжийг хамтад нь бий болгосон.
1994 оны 1-р сар	БНХАУ-ын нөөцийн албан татварын тухай түр журам	Давсны татварыг нөөцийн татварт оруулсан; металл бус хүдрийн бусад ордууд, төмрийн хүдрийн ордууд, өнгөт металлын хүдрийн ордууд зэргийг энэ татварт хамржуулж өргөтгөсөн.
2010 оны 6-р сар	Шинжааны түүхий нефть, байгалийн хийн нөөцийн шинэчлэлийн зарим асуудлын тухай заалтууд	Түүхий нефть, байгалийн хийн нөөцийн татварыг Шинжаанд борлуулалтын орлогоос авдаг болсон. татварын хувь хэмжээ нь 5% болсон
2011 оны 11-р сар	БНХАУ-ын нөөцийн татварын тухай түр журамд өөрчлөлт оруулах тухай Төрийн зөвлөлийн шийдвэр	Түүхий нефть, байгалийн хийн татварыг борлуулалтын хэмжээнээс 5-10% хүртэл авдаг болсон.
2014 оны 10-р сар	Түүхий газрын тос, байгалийн хийн нөөцийн татварын талаар баримтлах бодлогод өөрчлөлт оруулах Сангийн яам, Татварын ерөнхий газрын шийдвэр	Түүхий нефть, байгалийн хийн нөөцөд ногдуулах татварын хэмжээг 5-6% болгон өөрчлөх; 2014 оны 12-р сараас Нүүрсний баялгийн татварыг шинэчилж, улсын хэмжээнд нүүрсний нөөцийн албан татвар ногдуулах, ижил төстэй бусад төлбөр, хураамжийг цуцлах
2015 оны 5-р сар	Газрын ховор элемент, вольфрам, молибдений нөөцийн татварын нэмэлт татварыг өртөг суурьтай болгох. Сангийн яам, Татварын ерөнхий газар	Рений (rhenium), гянт болд (tungsten), молибдений нөөцийн татварыг эзлэхүүний квотоос үнийн квот болгон өөрчилсөн.

Нөөцийн татварын хууль (Resource Tax Law)

БНХАУ-ын 13 дахь сонгуулийн БХАТИХ-ын Байнгын хорооны 2019 оны 8 дугаар сарын 26-ны өдрийн хуралдаанаар Нөөцийн татварын тухай хуулийг баталж, 2020 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдөж эхэлсэн.

Хуульд заасан татвар ногдох 164 нөөцөөс түүхий газрын тос, байгалийн хий, занарын хий, газрын ховор элемент зэрэг томоохон нөөцөд улсын хэмжээнд мөрдөгдөж буй тогтмол хувь хэмжээ ногдуулдаг. Нүүрс, төмрийн хүдэр, алт, мөнгө зэрэг бусад ихэнх нөөцөд хувь хэмжээний тодорхой завсар зааж өгсөн. Хуульд заасан хувь хэмжээний хязгаартай эдгээр нөөцийн хувьд бодит хэрэгжих хувь хэмжээ тогтоох эрхийг мужийн түвшний засаг захиргаанд олгосон. Дараа нь энэ хувийг Ардын их хурлаар батламжилж, Төрийн Зөвлөл ба БХАТИХ-ын Байнгын хорооны бүртгэлд оруулдаг (2-р зүйл ба хавсралт).

Хүснэгт 15. БНХАУ-ын нөөцийн татварын хувь хэмжээ

Ашигт малтмалын төрөл	Нөөцийн татварын хууль	Шинжаан	Өвөр Монгол	Гуандун муж
Нүүрс, түүхий	2-10%	6%	10%	6%
Нүүрс, боловсруулсан		5%	9%	4%

Усны нөөцийн татварыг 2016 оноос эхлэн туршилтын журмаар 10 мужид нэвтрүүлсэн. Байгалийн усны нөөцөөс шууд ус олборлож, гүний ус олборлож буй аж ахуйн нэгж, хувь хүмүүс татвар төлөгчид юм. Хууль батлагдсанаас хойш 5 жилийн дотор Төрийн зөвлөл хуульд өөрчлөлт оруулах саналыг БХАТИХ-ын Байнгын хороонд гаргах ёстой (14-р зүйл).

Нөөцийн татварыг өртөгт суурилсан (ad valorem) буюу биет хэмжээнд суурилсан зарчмаар тооцож, хураадаг. Өртөгт суурилсан зарчмаар төлөх нөөцийн албан татварыг борлуулсан татвар ногдох нөөцийн бүтээгдэхүүний дүнг холбогдох татварын хувь хэмжээгээр үржүүлэх замаар тооцох ба биет хэмжээнд суурилсан дээр татвар ногдуулах бүтээгдэхүүний борлуулалтын хэмжээг татварын тодорхой хувь хэмжээгээр үржүүлэх замаар тооцно (3-р зүйл).

“БНХАУ-ын Нөөцийн татварын тухай хууль”-ийн хэрэгжилтийг хангах зорилгоор Сангийн яам, Улсын татварын алба 2020 онд 34-р тушаал буюу “Нөөцийн татвар хураах, удирдахтай холбоотой зарим асуудлын тухай” тушаалыг баталж 2020 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс мөрдөж эхэлсэн. Уг тушаалаар нөөцийн татварыг хураах, захиран зарцуулахтай холбоотой зохицуулалтыг тодорхой болгож, нөөцийн татварын тайлангийн маягтыг шинэчлэн боловсруулж, татвар төлөгчдөд чиглэсэн бодлогын үндэслэл, үйл ажиллагааны чиглэлийг илүү ойлгомжтой болгосон. Энэхүү тушаалд дараах удирдамжийг тусгасан.

Татвар ногдох бүтээгдэхүүний борлуулалтыг татвар төлөгчөөс НӨАТ ороогүй татвар ногдох бүтээгдэхүүнийг борлуулсны төлөө худалдан авагчид ногдуулсан нийт үнийг үндэслэн тодорхойлно. НӨАТ-ын нэхэмжлэл болон бусад хууль ёсны бөгөөд хүчин төгөлдөр нотлох баримт бүрдүүлсэн тохиолдолд борлуулалтад тусгагдсан тээврийн болон бусад зардлыг борлуулалтаас хасаж болно. Холбогдох тээврийн болон бусад зардал гэдэгт татвар ногдуулах бүтээгдэхүүнийг уурхайн ам, угаах (боловсруулах) үйлдвэрээс боомт, худалдан авагчийн тогтоосон газар хүртэлх тээвэрлэлтийн зардал, ачих буулгах, агуулах, хадгалах зардал хамаарна.

Татвар төлөгчийн мэдүүлсэн татвар ногдох бүтээгдэхүүний борлуулалтын хэмжээ хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр бага, эсхүл татвар ногдох бүтээгдэхүүнийг өөрөө ашигладаг боловч борлуулаагүй бол татварын эрх бүхий байгууллага татвар ногдох бүтээгдэхүүний борлуулалтыг дараах аргачлалын аль нэгээр сонгож тодорхойлно:

- ❖ Татвар ногдох бүтээгдэхүүний борлуулалтыг татвар төлөгчөөс НӨАТ ороогүй татвар ногдох бүтээгдэхүүнийг борлуулсны төлөө худалдан авагчид ногдуулсан нийт үнийг үндэслэн тодорхойлно. НӨАТ-ын нэхэмжлэл болон бусад хууль ёсны бөгөөд хүчин

төгөлдөр нотлох баримт бүрдүүлсэн тохиолдолд борлуулалтад тусгагдсан тээврийн болон бусад зардлыг борлуулалтаас хасаж болно. Холбогдох тээврийн болон бусад зардал гэдэгт татвар ногдуулах бүтээгдэхүүнийг уурхайн ам, угаах (боловсруулах) үйлдвэрээс боомт, худалдан авагчийн тогтоосон газар хүртэлх тээвэрлэлтийн зардал, ачих буулгах, агуулах, хадгалах зардал хамаарна.

❖ Татвар төлөгчийн мэдүүлсэн татвар ногдох бүтээгдэхүүний борлуулалтын хэмжээ хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр бага, эсхүл татвар ногдох бүтээгдэхүүнийг өөрөө ашигладаг боловч борлуулаагүй бол татварын эрх бүхий байгууллага татвар ногдох бүтээгдэхүүний борлуулалтыг дараах аргачлалын аль нэгээр сонгож тодорхойлно:

1. Татвар төлөгчийн сүүлийн үеийн ижил төрлийн бүтээгдэхүүний борлуулалтын дундаж үнийг тодорхойлох.
2. Сүүлийн үеийн бусад татвар төлөгчдийн ижил төрлийн бүтээгдэхүүний борлуулалтын дундаж үнийг тодорхойлох.
3. Боловсруулалтын зардал, ашгийг хасаж татвар ногдуулахгүй бүтээгдэхүүний борлуулалтын үнийг тодорхойлно.
4. Татвар ногдох бүтээгдэхүүний найрлагын татвар ногдуулах үнийг тодорхойлох. Найрлагын татвар ногдох $\text{үнэ} = \text{зардал} \times (1 + \text{зардлын ашгийн хувь}) \div (1 - \text{нөөцийн татварын хувь хэмжээ})$. Зардлын ашгийн хувь хэмжээг муж/аймгийн татварын алба тогтооно.
5. Бусад боломжит аргаар тодорхойлох.

Хайнань мужид зардлын ашгийн хувь нь 10%. Өвөр Монголын өөртөө засах оронд эрчим хүч, ашигт малтмалын зардлын ашгийн харьцаа 20%, металлын ашигт малтмалынх 13%, металл бус ашигт малтмалынх 9%, хий, давсных 10% байна. Энэ журам Өвөр Монголд 2020 оны есдүгээр сарын 1-нээс хэрэгжиж эхэлжээ.

Түүнчлэн татвар төлөгч нь худалдан авсан түүхий хүдрээ өөрөө олборлосон хүдэртэй хольж, баяжуулах бүтээгдэхүүн болгон боловсруулж борлуулах тохиолдолд суутган авахыг зөвшөөрсөн гаднын татвар ногдох бүтээгдэхүүний худалдан авалтын дүнг дараах байдлаар тооцно.

Жишээлбэл, нэг нүүрсний компани 1 сая юаниар худалдан авсан түүхий нүүрсээ, өөрөө 2 сая юаниар олборлосон түүхий нүүрстэй хольж, борлуулсан нүүрсээ 4.5 сая юаниар борлуулсан гэе. Орон нутгийн түүхий нүүрсний татварын хувь хэмжээ 3%, боловсруулсан нүүрсний татвар 2% байна. Татвар ногдох борлуулалтын орлогыг тооцоходоо татварын хөнгөлөлтийг харгалзана. Худалдан авсан түүхий нүүрсний худалдан авалтын дүн $\times$ (бүс нутгийн түүхий нүүрсний татварын хувь хэмжээ $\div$ тухайн бүс нутагт нүүрс боловсруулахад ногдуулах татварын хувь хэмжээ) $= 1,000,000 \text{ юань} \times (3\% \div 2\%) = 150,000 \text{ юань}$.

2014 оны 12-р сарын 1-ээс 2023 оны 8-р сарын 31-ний өдрийг хүртэл уурхайн газрыг нөхөн сэргээсэн бол нүүрсний нөөцийн татварыг 50 хувиар бууруулах хөнгөлөлт үзүүлнэ.

Нөөцийн татварыг үйлдвэрлэл, олборлолт явагдаж буй нутгийн засаг захиргаанд төлнө. Нөөцийн татварыг сар, улирал болгон зарлаж, төлдөг. Хэрэв татварыг тогтоосон хугацаанд тооцож, төлөх боломжгүй бол төлбөрийг гүйлгээ тус бүрээр хийж болно (11, 12 дугаар зүйл).

Нөөцийн татварын шинэчилсэн найруулгын хэрэгжилтийн талаар тус улсын Сангийн яам, Улсын татварын албанаас нэлээд тодруулга өгч байгаа бөгөөд татварын тодорхой хувь хэмжээг ерөнхийд нь тухайн муж, аймгийн засаг захиргаа тогтоодог. Түүнчлэн төрийн байгууллагуудаас гаргасан үндсэн хууль тогтоомж, дагалдах баримт бичгүүдэд дүн шинжилгээ хийсний үндсэн дээр тодорхой нөхцөлийг хангасан тохиолдолд нөөцийн татварын хөнгөлөлт эдлэх боломжтой.

БНХАУ-ын Нөөцийн татварын тухай шинэ хуулиар “БНХАУ-ын Нөөцийн татварын тухай түр журам (2011)”, “БНХАУ-ын Нөөцийн татварын талаарх түр журам (1993)”-ыг хүчингүй болгосон. 2011 оны түр журам нь 1993 оны түр журмын шинэчилсэн найруулга юм. Энэхүү журмыг “Өвөр Монголын Өөртөө Засах Орны нүүрсний нөөцийн татварын зарчмын татварыг хэрэгжүүлэх арга хэмжээ” (2015), “БНХАУ-ын Нөөцийн татварын тухай түр журмыг хэрэгжүүлэх нарийвчилсан журам” (2011) тус тус дагалдана.

Хуучин завсрын журмаар нүүрсний нөөцийн татварыг өртөгт суурилсан аргаар тооцож ногдуулдаг байсан бөгөөд татварыг тооцоолж байсан томъёо нь:

- $\text{Түүхий нүүрсний татварын өглөг} = \text{түүхий нүүрсний борлуулалт} \times \text{холбогдох татварын хувь хэмжээ}$
- $\text{Угаасан нүүрсэнд төлөх татвар} = \text{угаасан нүүрсний борлуулалтын хэмжээ} \times \text{хөрвүүлэх хувь} \times \text{холбогдох татварын хувь хэмжээ}$

Энэ журмын хугацаанд Өвөр Монголд мөрдөгдөж буй татварын хэмжээ 9 хувь байсан. Харин угаасан нүүрсний хөрвүүлэх хувийг дараах хоёр томъёог ашиглан тооцож байсан.

- $(\text{Боловсруулсан нүүрсний борлуулалтын дундаж үнэ} - \text{боловсруулалтын дундаж зардал} - \text{боловсруулалтын дундаж ашиг}) \div \text{боловсруулсан нүүрсний борлуулалтын дундаж үнэ}$
- $\text{Түүхий нүүрсний борлуулалтын дундаж үнэ} \div (\text{боловсруулсан нүүрсний борлуулалтын дундаж үнэ} \times \text{иж бүрэн ашиглалтын хувь})$

Харин шинэ журмын дагуу хөрвөх хувь хэмжээг тооцохын оронд түүхий болон боловсруулсан нүүрсний татварын хувь хэмжээг тусад нь тооцохоор болсон.

3. Монголын улсын АМНАТ-ийн зохицуулалтын туршлага: Нүүрсний салбар

3.1. Монголын эдийн засаг ба нүүрсний салбар

Байгалийн баялгийн рентийн¹⁶ ДНБ-д эзэлж буй хувь хэмжээгээр тухайн улс байгалийн баялгаас хэр хамааралтайг харж болдог. 2020 оны байдлаар Монголын нийт байгалийн баялгийн рент нь ДНБ-ий 16.4 хувьтай тэнцсэн ба энэ нь дундаж орлоготой орнуудын дунджаас 5 дахин, дэлхийн дунджаас 8 дахин өндөр үзүүлэлт юм (Зураг 16). Үүнээс нүүрсний рент нь ДНБ-ий 6.9 хувьтай тэнцэж байна. Гэтэл дэлхийд эрчим хүчний нүүрс болон коксжих нүүрсний экспортоор тэргүүлэгч Индонез, Австрали улсуудын нүүрсний рент нь 0.7 хувь байна.


Зураг 16. Байгалийн баялгийн рент, 2020 он



Эх сурвалж: World Development Indicators, World Bank 2019

Нүүрсний рентийн хэмжээ нь нүүрсний үнийн түвшнээс ихээхэн хамаардаг. Энэ үзүүлэлт 2011 онд дээд цэгтээ буюу ДНБ-ий 26 хувьд хүрч байсан бол 2015 онд 2.4 хувь болтлоо буурч байжээ.

Зураг 17. Нүүрсний рент ДНБ-д эзлэх хувь




Эх сурвалж: World Development Indicators, World Bank

¹⁶ Дэлхийн Банк байгалийн баялгийн рентийг тухайн баялгийг олборлох өртөг болон дэлхийн зах зээлийн үнийн зөрүү гэж тодорхойлсон. Үүнийг бас баялгийн сул ашиг ч гэх нь бий.

Монголын эдийн засгийн нөхцөл байдалд нүүрсний салбарын экспорт хамгийн хүчтэй нөлөөлдөг. Ковид-19 цар тахлын нөлөөгөөр 2020-2021 оны эдийн засгийн өсөлт унаж, саарахад нүүрсний экспортын саатал, орлогын бууралт гол нөлөө үзүүлсэн.

Зураг 18. Нүүрсний олборлолт экспорт, улирлаар мян.тн



Зураг 19. Нүүрсний экспорт ба эдийн засгийн өсөлт



Эх сурвалж: АМГТГ, УСХ

Олон улсын байгууллагууд 2021 оны эхний хагас жилийн нүүрсний салбарын экспортын өсөлтөд тулгуурлан нийт өсөлтийг харьцангуй өөдрөг таамаглаж байсан боловч хил хаагдаж экспорт буурсантай холбоотойгоор оны сүүлийн хагаст бодит эдийн засаг 2020 оны түвшнээс ч доош унаад байна. Ковид-19-ийн тодорхой бус байдал дээр нэмээд татварын орчны гэнэтийн шок ойрын үеийн эдийн засгийн өсөлтийн өөдрөг таамаглал дэвшүүлэх магадлалыг эрс бууруулж байна.

Хүснэгт 16. Монгол эдийн засгийн өсөлтийн таамаглалууд, %

	2021*	2022*
Дэлхийн банк, 2021 оны VI сар	5.9	6.1
ОУВС, 2021 оны IV сар	5.0	7.5
АХБ, 2021 оны IV сар	4.8	5.7
Монголбанк, 2021 оны VI сар	5.2-8.6	3.0-8.8

Эх сурвалж: Азийн хөгжлийн банк, ОУВС, Дэлхийн банк, Монголбанк

Монголын эдийн засаг уул уурхайгаас, ялангуяа нүүрсний салбараас хэт хамааралтай байгааг дээрх тоо баримтууд илтгэж байна. Тиймээс нүүрсний салбарын бодлого хууль дүрмийг байнга өөрчлөх нь маш эрсдэлтэй. Түүхий эдийн үнийн хэлбэлзэл дээр нэмээд бодлого, институтийн орчны өөрчлөлт нь нүүрсний салбарын борлуулалтад сөргөөр нөлөөлж, улмаар нийт эдийн засагт эрсдэл дагуулж болзошгүй юм. Үүний нэг жишээ нь 2021 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн Засгийн газрын 174 дүгээр тогтоолоор гадаад зах зээлд борлуулсан нүүрсэнд АМНАТ ногдуулах борлуулалтын үнэлгээг тооцох журмыг гэнэт өөрчилсөн явдал юм. Үүний улмаас нүүрс экспортлогчид их хэмжээний татварын өрөнд орж, улмаар нүүрсний борлуулалтаа зогсоох, зөвхөн үнэ өндөртэй нүүрсээ сорчлон борлуулах, чанар багатай нүүрс хаягдах, эрдэс баялгийн нөөцийг бүрэн ашиглах боломжгүй болох зэрэг асуудал тулгараад байна. Энэ талаарх тулгамдаж буй асуудлыг дараагийн хэсгүүдэд дэлгэрүүлж авч үзье.

3.2. Монгол дахь АМНАТ-ийн зохицуулалт

АМНАТ нь Ашигт Малтмалын тухай хуулийн хүрээнд ЗГ-ын тогтоолуудын хүрээнд зохицуулагддаг. АМНАТ-ыг зохицуулдаг тогтоолууд нь нүүрсний үнийн адил маш тогтворгүй байнга өөрчлөгдсөөр ирсэн. Энэхүү өөрчлөлтүүд нь нарийвчилсан судалгаа шинжилгээнд үндэслэсэн гэхээсээ илүүтгээгээр компаниудаас авах АМНАТ-ийн хэмжээг өндөр байлгах тал дээр л голчлон суурилсан байдаг. Эдгээр үндэслэлгүй шийдвэрүүд нь нүүрсний компаниудыг татварын өндөр ачааллыг үүрэхэд хүргэж, цаашлаад зарим төрлийн нүүрсний экспортыг бууруулснаар татварын баазыг бууруулахад хүргэж байна. Монголын АМНАТ-ыг тооцоход мөрдөж байгаа дүрэм журам болон эдгээр дүрэм журмууд хэрхэн өөрчлөгдөж ирснийг авч үзье.

Ашигт малтмалын тухай хууль, 47 дугаар зүйл (2006 он):

- **АМНАТ төлөгч** – ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч, экспортлогч, Монголбанканд алт тушаагч. Хуулийн анхны хувилбараар ашигт малтмал худалдсан, худалдахаар ачуулсан, ашигласан бүх төрлийн бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээнээс тооцож АМНАТ-ийг төсөвт төлөхөөр заасан. “Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч” туршилтын журмаар олборлосон ашигт малтмалыг мэргэжлийн хяналтын албаны зөвшөөрлөөр борлуулж болох ба ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн адилаар АМНАТ төлдөг байжээ.
- **АМНАТ ногдуулах борлуулалтын үнэлгээ** - Экспортлосон бол олон улсын худалдаанд хүлээн зөвшөөрөгдсөн тухайн сарын дунджийг тогтоох зарчмыг үндэслэн тухайн бүтээгдэхүүний, эсхүл түүнтэй адил төстэй бүтээгдэхүүний олон улсын зах зээлийн үнийг баримтална. Дотоодод борлуулсан буюу ашигласан бол тухайн бүтээгдэхүүний, эсхүл түүнтэй адил төстэй бүтээгдэхүүний дотоодын зах зээлийн үнийг үндэслэнэ. Жишиг үнийг тодорхойлох боломжгүй тохиолдолд тусгай зөвшөөрөл эзэмшигчийн мэдүүлсэн борлуулалтын орлогыг үндэслэнэ.
- **АМНАТ хувь хэмжээ** - хуулийн анхны хувилбараар (1) дотоодод борлуулсан нүүрс, түгээмэл тархацтай ашигт малтмалын тухайд борлуулалтын үнэлгээний 2.5 хувиар, (2) бусад ашигт малтмалын тухайд 5.0 хувь байхаар заасан. 2010 оны нэмэлтээр, үндсэн хэмжээн дээр нэмээд зах зээлийн үнийн түвшний шатлал, боловсруулалтын түвшнээс хамаарч дараах хувийг ногдуулна.

Хүснэгт 17. АМНАТ-ын түвшин

Боловсруулаагүй нүүрс		Баяжуулсан нүүрс		Кокс	
Үнэ, \$/тн	Хувь	Үнэ, \$/тн	Хувь	Үнэ, \$/тн	Хувь
0-25	0.0	0-100	0.0	0-160	0.0
25-50	1.0	100-130	1.0	160-190	0.5
50-75	2.0	130-160	1.5	190-210	1.0
75-100	3.0	160-190	2.0	210-240	1.5
100-125	4.0	190-210	2.5	240-270	2.0
125 +	5.0	210 +	3.0	270 +	2.5

Эх сурвалж: Ашигт Малтмалын тухай хууль

АМНАТ-тэй холбоотой зарим өөрчлөлт (АМЕР, 2021):

- 2010.11.25 - АМНАТ-ийн хувийг тооцох, төлбөр ногдуулах аргачлалыг Засгийн газар батлахаар заасан, хүдэр, баяжмал, бүтээгдэхүүний боловсруулалтын түвшинд тавигдах шаардлага, ангилал, тооцох үндсэн зарчим, аргачлалыг Засгийн газраас батлахаар заасан;
- 2013.10.03 - Хөрөнгө оруулалтын тухай хууль батлагдсантай холбоотой АМНАТ-ийг тогтворжуулах гэрчилгээнд заасан хувь хэмжээгээр ногдуулахаар заасан.
- 2015.02.18 - стратегийн ач холбогдол бүхий ордын төрийн эзэмшлийн хувь хэмжээг гэрээний үндсэн дээр 5% хүртэлх (тусгай) АМНАТ-өөр орлуулж болно.
- 2015.06.04 - АМНАТ-ийн төлбөрийг худалдсан, худалдахаар ачуулснаас хойш дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор улсын төсөвт төлдөг болсон.
- 2019.03.26 - Тухайн сард худалдсан, худалдахаар ачуулсан ашигт малтмалд ногдох АМНАТ-ийг дараа сарын 20-ны өдрийн дотор, жилийн эцсийн тооцоог дараа жилийн 2 сарын 10-ны дотор хийж төсөвт төлөхөөр заасан. Мөн АМНАТ-ийг хүдэр, баяжмал, бүтээгдэхүүнд давхардуулж ногдуулахгүй байхаар заасан
- 2019.11.22 - Үндсэн хуулийн цэцийн шийдвэртэй холбоотойгоор хуулийн 47 дугаар зүйлийн зарим заалтын найруулгыг шинэчлэн АМНАТ төлөгч нь (1) худалдсан, худалдахаар ачуулсан, (2) экспортолсон, (3) өөрийн хэрэгцээнд ашигласан ашигт малтмалын борлуулалтын үнэлгээнд АМНАТ-ийг давхардуулахгүйгээр ногдуулж төсөвт төлөхөөр тодруулсан. Ашигт малтмал экспортолсон этгээд АМНАТ төлөгч байхаар заасан. АМНАТ-ийг хүдэр, баяжмал, бүтээгдэхүүнд давхардуулахгүй байх шаардлагын хүрээнд өмнө төлөгдсөн АМНАТ-ыг тайлагнасан бол дараагийн шатанд суутгаж байхаар заасан.

АМНАТ-ийг тооцоход хамгийн их маргаан дагуулдаг гол асуудал бол АМНАТ ногдох борлуулалтын үнэлгээг хэрхэн тооцох асуудал юм. Хүснэгт 18-д Биржийн нэр зарлах тухай ЗГ-ын тогтоол хэрхэн өөрчлөгдөж ирснийг харууллаа. Энэ тогтоолд заасан журамд 2007 онд батлагдсанаас нь хойш зөвхөн нүүрстэй холбоотой 8 удаагийн өөрчлөлт оржээ.

2007 оны 88-р тогтоолоор жишиг үнийг Хятадын www.coalworld.net цахим хуудаст тавигдсан үнийн баримтлахаар заасан байсан бөгөөд уг тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор 2010 оны 39 дүгээр тогтоолын дагуу жишиг үнэ тооцох аргачлалыг Татварын ерөнхий газраас батлан мөрдөх болсон. Гэвч энэхүү жишиг үнэ нь компаниудын борлуулалтын үнээс хэт өндөр байсан тул нүүрс экспортлогч компаниудын татварын ачааллыг хүндрүүлж, хүчтэй шүүмжлэлд өртсөн. Тиймээс 2011 оны 74 дүгээр тогтоолоор өөрчлөлт оруулж гэрээний үнээр АМНАТ-ыг тооцож эхэлсэн бөгөөд үүнийг 2013 оны 4-р сар хүртэл мөрдөхөөр болсон. Энэ хугацаанд жишиг үнэ тооцох шинэ аргачлалыг боловсруулахаар болсон. Улмаар 2013 оны 131 дүгээр тогтоолоор жишиг үнийг зарлах шинэ эх сурвалжийг танилцуулсан ба энэ нь <http://en.sxcoal.com> цахим хуудас байв. Гэвч энэхүү сайтын мэдээлэл нь өмнөх цахим хуудасны мэдээллээс төдийлөн ялгаагүй байсан гэж нүүрс экспортлогч компаниуд дүгнэдэг.

<http://en.sxcoal.com> цахим хуудас нь БНХАУ-ын Shanxi Fenwei Energy Information Services Co хэмээх компанийн ажиллуулдаг мэдээллийн цахим хуудас юм. Жишиг үнийн хувьд эхлээд Хятадын далайн боомтуудын үнийг голчлон мэдээлж байгаад сүүлийн үед Ганц мод, Сэхэ зэрэг манай улстай хиллэдэг боомтууд дээрх нүүрсний үнийг зарладаг болсон. Энд тухайн заасан боомт дахь, тухайн заасан хугацааны бодит хэлцлийн спот зах зээлийн үнийг мэдээлдэг. Нүүрсний үнэ тооцох аргачлалаа тус цахим хуудаст нийтэлсэн¹⁷. Уг аргачлалд дурдсанаар, нүүрсний үнийг нүүрсний чанарын үзүүлэлтүүдэд үндэслэн хэд хэдэн ангиллаар зарлах ба тухайн чанарын нүүрсний бодит үнэ нь энд зарласан үнийн орчимд байсан гэсэн үг юм. Хэрвээ

¹⁷ <http://www.sxcoal.com/home/data/Fenwei%20CCI%20Methodology.pdf>

тухайн ажлын өдөр ямар нэг арилжаа хийгдээгүй бол компаниудын санал болгосон үнийг харгалзан үздэг. Ингэхдээ компаниудын худалдан авах үнийн захиалгаас хамгийн өндөр санал болгосон үнийг 30%-аас өсгөж, худалдан үнийн захиалгуудаас хамгийн бага санал болгосон үнийг 30% бууруулж дундаж үнийг тооцдог. Арилжаалсан нүүрсний бодит үнийг нүүрсний чанарын үзүүлэлтүүдээр засварлаж, тухайн ангиллын нүүрсний зарлах үнэд тусгадаг. Энэ үнийн индекс тооцоонд урт хугацаат гэрээгээр борлуулж буй болон тусгай нөхцөлтэй гэрээ бүхий нүүрсний үнийг оруулдаггүй.

Хүснэгт 18. Нүүрсний жишиг үнийн эх сурвалж, АМНАТ ногдуулах борлуулалтын үнэлгээний талаарх журам

Нүүрсний борлуулалтын үнэлгээ, түүний үндэслэл болгох эх сурвалжийн талаарх журам	
Засгийн газрын 2007 оны 4 сарын 4-ний өдрийн 88 дугаар тогтоол	
	Биржийн нэр зарлах тухай – Нүүрсний жишиг үнийг тогтоохдоо Хятадын www.coalworld.net цахим хуудаст тавигдах үнийг баримтлахаар заасан.
Засгийн газрын 2010 оны 2 сарын 17-ны 39 дүгээр тогтоол	
	Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай – Жишиг үнэ тооцох аргачлалыг Татварын ерөнхий газраас батлан мөрдүүлэх болсон.
Засгийн газрын 2012 оны 10 сарын 6-ны 74 дүгээр тогтоол	
	Тогтоолд өөрчлөлт оруулах тухай – 2013 оны 4 сарын 1 хүртэл АМНАТ-ийг жишиг үнээс биш гэрээний үнээс тооцохоор болсон.
Засгийн газрын 2013 оны 4 сарын 6-ны 131 дүгээр тогтоол	
	Тогтоолын хавсралтуудад, нэмэлт өөрчлөлт оруулах тухай – АМНАТ-ийг жишиг үнээр тооцох болсон ба жишиг үнийг http://en.sxcoal.com -ээс авч эхэлсэн.
Засгийн газрын 2014 оны 3 сарын 21-ний 88, 89 дүгээр тогтоол:	
	Аргачлал батлах тухай – Гэрээний үнийг ашиглах болсон.
Засгийн газрын 2014 оны 7 сарын 4-ний 220 дугаар тогтоол:	
	Гэрээний үнийг ашиглахдаа ижил боомтоор, ижил төрлийн бүтээгдэхүүний бусад аж ахуйн нэгжийн экспортолж буй үнээс 10 ба түүнээс дээш хувиар ялгаатай байвал бодит бус үнэ гэж үзэн жишиг үнийг ашиглана.
Засгийн газрын 2016 оны 2 сарын 1-ний 81 дүгээр тогтоол:	
	Биржийн болон зах зээлийн үнийн эх сурвалжийн нэр зарлах тухай – Буцаад АМНАТ-ийг жишиг үнэд үндэслэн тооцох болсон (http://en.sxcoal.com)
Засгийн газрын 2019 оны 9 сарын 4-ний 342 дугаар тогтоол	
	Журам батлах тухай – Гэрээний үнэд үндэслэх ба гэрээний үнэ нь жишиг үнээс 30 болон түүнээс дээш хувиар бага бол жишиг үнэд суурилан АМНАТ-ийг тооцох болсон.
Засгийн газрын 2021 оны 6 сарын 23-ны 174 дүгээр тогтоол:	
	Тогтоол хүчингүй болгох, тогтоолд өөрчлөлт оруулах тухай - БНХАУ-д нүүрсний үнэ өссөнтэй холбоотойгоор зөвхөн жишиг үнэд суурилан АМНАТ-ийг тооцох болсон (http://en.sxcoal.com).

Эх сурвалж: Холбогдох ЗГ-ын тогтоолууд

<http://en.sxcoal.com> цахим хуудсандаа танилцуулсан үнийн индекс тооцох аргачлалын 3.3-3.7 дахь хэсэгт эрчим хүчний, коксжих, антрацит нүүрсний үнийн индексийг хэлцэл тус бүрийн нүүрсний чанарын үзүүлэлтээр засварласан дунджаар хэрхэн тооцох, хангалттай хэлцлийн мэдээлэл байхгүй үед хэрхэн орлуулж тооцох дэлгэрэнгүй томъёо аргачлалыг тайлбарласан.

Зарлах нүүрсний стандарт ангилал, гэрээний нөхцөлд тулгуурлан CCI 5500, CCI 5000, CCI Import index, CCI 4700 Import index, CCI 3800 Import index гэх мэт 10 гаруй үнийн индексүүдийг тооцож зарладаг.

Монгол Улсаас экспортолсон нүүрс БНХАУ-ын Ганц мод, Сэхэ боомтууд болон Бугат хотын зах зээлд гардаг учраас эдгээр боомтын үнийг sxcoal.com цахим хуудаснаас авч жишиг үнийг тооцно гэсэн үг юм. Гэхдээ нүүрсний чанар ангиллаас хамаараад олон янзын үнэ зарлагддаг. Жишээлбэл, Ганц мод боомт дахь боловсруулаагүй коксжих нүүрсний хувьд Ganqimaodu Mongolia Raw Coking 2 (ex-stock with VAT), 19.0 Ad/%, 28.0 Vdaf/%, 0.9 St.d/%, 85.0 G, 13T/mm, 64 CSR гэсэн ангиллын нүүрс зарлагддаг.

2014-2021 онд АМНАТ ногдуулах борлуулалтын үнэлгээ тооцоходоо жишиг үнэ болон гэрээний үнийн аль нэгээр, эсвэл хослуулан тооцох аргачлалуудыг янз бүрээр хэрэглэж ирсэн. Гэхдээ жишиг үнийн эх сурвалж болох <http://en.sxcoal.com> өөрчлөгдөөгүй. Хамгийн сүүлд 2021 оны 7-р сараас зөвхөн жишиг үнийг ашиглан АМНАТ-ийг ногдуулах борлуулалтын үнэлгээг тооцох болсон.

Гэхдээ Сангийн яамны боловсруулсан, нүүрсний АМНАТ-ийн жишиг үнэ тооцох аргачлал нь уул уурхайн салбарын яам, төрийн байгууллага, татвар төлөгч аж ахуйн нэгжүүд, олон нийтэд ил тод биш байгааг зориуд тэмдэглэх нь зүйтэй.

3.3. Нүүрсний борлуулалтын үнэ ба жишиг үнийн зөрүү

Нүүрс нь биржийн бус түүхий эд бөгөөд боловсруулалт, тээвэрлэлт, шинж чанар, стандарт, ангиллын олон үзүүлэлтээс хамаараад гэрээний үнэ маш их ялгаатай тогтоогддог. АМГТГ 2014 оноос эхлэн сар бүр нүүрсний АМНАТ тооцох жишиг үнийг Сангийн яамнаас авч, хэд хэдэн төрлөөр олон нийтэд зарлаж байна. Тодруулбал боловсруулаагүй нүүрс, баяжуулсан нүүрс болон кокс гэсэн гурван ангиллын хүрээнд жишиг үнийг зарладаг. Жишиг үнэ тооцож зарладаг нүүрсний ангиллыг дараах хүснэгтэд харуулав.

Хүснэгт 19. Жишиг үнэ тооцдог нүүрсний ангилал


Төрөл	Нэр	Чанарын үзүүлэлт
Боловсруулаагүй нүүрс	Антрацит	Дэгдэмхий: V<8%, Үнслэг: A<25%, Илчлэг: Q>5500
	Коксжих	Барьцалдаг чанар: G>=50, Дэгдэмхий: V<28%, Үнслэг: A<12.5%, 12.5%<15%, >15%
	Сул коксжих	Барьцалдах чанар: G>=50, Дэгдэмхий: V>28%, Үнслэг: A<12.5%, 12.5%<15%, >15%
	Коксжих чанаргүй нүүрс	Барьцалдах чанар: G<50, Дэгдэмхий: V= 28%-37%, >37% Үнслэг: A<=25%, >=25%Илчлэг: Q>5500, >=450
	Хүрэн нүүрс	Илчлэг: Q<4500, Чийг: W<45%, V>40% Үнслэг: A<20%
Баяжуулсан нүүрс	Антрацит	Дэгдэмхий: V<8%, Үнслэг: A<12%, Илчлэг Q>7000
	Коксжих нүүрс	Барьцалдах чанар: G>=60, Дэгдэмхий: V<28%, Үнслэг: A<=10.5%, 10.5%<12%, >=12%
	Сул коксжих нүүрс	Барьцалдах чанар: G>=60, Дэгдэмхий: V>28%, Үнслэг: A<=10.5%, 10.5%<12%, >=12%
	Коксжих чанаргүй нүүрс	Барьцалдах чанар: G<60, Чийг: W<12, Үнслэг: A<=20%, >=20%, Илчлэг: Q>5000, >=4500
Кокс	Кокс	Ерөнхий хүүхрийн хэмжээ: S<1.4%, Үнслэг: A<11.0%-14.0%, Чийглэг: W<2.0%, Дэгдэмхий бодисын гарц: V<1.2%-2.0%, Илчлэг: Q>5300

Эх сурвалж: АМГТГ

Энэ ангилал нь нүүрс экспортлогчид, салбарын мэргэжилтнүүдийн дунд нэлээд маргаан дагуулдаг. Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 193 дугаар тогтоолоор боловсруулсан ба боловсруулаагүй нүүрсний ангиллыг баталсан. Мөн 2014 оны Монгол Улсын стандартаар нүүрсний ангилал чанарын стандарт MNS 6457 -г баталсан. Гэвч эдгээр ангилал нь жишиг үнэ тооцох дээрх ангиллаас зарим үзүүлэлтээр зөрдөг. Ингэснээр чанар багатай нүүрсэнд чанар сайтай нүүрсний жишгээр хэт өндөр татвар ногдуулах гэх мэт асуудал гардаг. Ялангуяа Нарийн сухайт, Хөшөөтийн ордод олборлолт эрхэлж буй экспортлогч компаниудад энэ нь маш том тулгамдсан асуудал болдог. Гэхдээ нүүрсний ангиллын талаарх энэ асуудлын шийдэл боловсруулах судалгааны ажил тусдаа хийгдэж байгаа тул энэ судалгаанд уг асуудлыг дэлгэрүүлж авч үзээгүй.

Доорх зурагт жишиг үнэ болон компаниудын гэрээний үнийн сүүлийн жилүүдийн динамик болон ЗГ-ын тогтоолуудын өөрчлөлтийг 2007 оноос хойш харууллаа. Олон улсын зах зээл дэх нүүрсний үнийн бууралттай холбоотойгоор 2014 – 2016 онд гэрээний болон жишиг үнийн зөрүү харьцангуй бага байсан. Энэхүү зөрүү 2016 – 2018 онд нэмэгдэж эхэлжээ. 2019 оноос ерөнхийдөө гэрээний үнэд (гэрээний үнэ жишиг үнээс 30 болон түүнээс дээш хувиар бага бол жишиг үнэд суурилна) суурилан АМНАТ-ийг тооцдог болсон нь асуудлыг бага зэрэг намжааж байсан.

Зураг 20. Жишиг үнэ болон гэрээний үнийн зөрүү, мянган төгрөг



Тайлбар: Баяжуулсан коксжих, коксжих, сул коксжих, эрчим хүчний (чанаргүй коксжих нүүрс) нүүрснүүдийн борлуулалтын гэрээний үнэ болон жишиг үнийг экспортод эзэлж байгаа хувь хэмжээгээр жигнэн дунджийг нь тооцов

Эх сурвалж: АМГТГ, судлаачийн тооцоолол

Гэхдээ 2021 оны 7-р сараас эхлэн АМНАТ-ийг шууд жишиг үнэд суурилан тооцох болсон нь нүүрс экспортлогчдод хүнд цохилт болоод байна. Компаниудын өгсөн мэдээллээр, 2021 онд компаниудын дундаж гэрээний үнэ болон дундаж жишиг үнийн хооронд тонн тутамд 400 мянган төгрөгийн зөрүү үүссэн. Гэхдээ АМГТГ-аас авсан тоо мэдээллийн хувьд нэг асуудал байгаа нь, компаниудын борлуулалтын гэрээний үнийн мэдээлэл нь бүтэн жилийн турш дахь хамгийн дээд, доод үнийн мэдээлэл хэлбэртэй, зөвхөн интервалаар бидэнд мэдэгдэж байгаа юм. Тиймээс тухайн нэг төрлийн нүүрсний дунджийг олохдоо энэ интервалын дунджаар тооцсон. Харин нийт

нүүрсний үнийн дунджийг тодорхойлохдоо нүүрсний экспортын хэмжээгээр жигнэн дунджилсан. Хэдийгээр экспортын нүүрсний гэрээний болон жишиг үнийн зөрүүг тооцоход энд дурдсан тооцооны нарийвчлалын асуудал байгаа боловч жишиг үнэ нь бодит борлуулалтын үнээс хэт өндөр байгаа нь тодорхой байна.


Дээрх зургаас нэг ажиглагдаж буй зүйл нь нүүрсний үнэ өсөх бүрд АМНАТ-ийг тооцох жишиг үнийн аргачлал руу шилжиж байгаа явдал юм. 2014 – 2015 онд нүүрсний үнэ бага байх үед гэрээний үнээр АМНАТ-ийг тооцож байсан бол 2016 оноос нүүрсний үнэ өсөх үед жишиг үнийг ашиглах болсон байна. Мөн 2021 оны 7-р сараас эхлэн АМНАТ-ийг жишиг үнээр тооцох болсныг үүнтэй холбон тайлбарлаж болно. Учир нь Засгийн газраас АМНАТ тооцох борлуулалтын үнэлгээг тооцох аргачлалыг өөрчлөх шийдвэр гаргахдаа ямар үндэслэл, тооцоо ашигласан нь тодорхойгүй, энэ талын хэлэлцүүлэг огт хийгдэж байгаагүй, ямар нэг судалгааны тайлан мэдээлэл уул уурхайн салбарын оролцогчид болон олон нийтэд нээлттэй биш байгаа юм.

Энд бас нэг зүйлийг онцлон тэмдэглэх хэрэгтэй. 2021 оны нүүрсний жишиг үнийн өсөлт нь өмнөх жилүүдийн нүүрсний жишиг үнэ өсөж байсан үеүдээс ялгаатай. Учир нь Ковид-19 цар тахлын дотоод дахь дэгдэлт өндөр байсны улмаас БНХАУ-ын зүгээс Монгол Улсаас нэвтрэх тээврийн хэрэгсэлд хязгаарлалт тавьж, үүнээс үүдэн хилийн боомтууд дээр нүүрс тээврийн их хэмжээний дараалал үүсэж, тээвэрлэлтийн зардал түүхэнд байгаагүй өндөр түвшинд хүрсэн. Жишээ нь, судалгаанд оролцсон салбарын судлаачийн мэдээлснээр, 2021 оны 8-р сард Таван толгойн ордоос тонн тутам нь 70 орчим ам.доллароор ачигдсан нүүрс Гашуунсухайт боомт дээр тээврийн зардал нь нэмэгдсэнээр 171 ам.доллар хүрч, улмаар үүнээс цааш хил нэвтэрч БНХАУ-ын Ганцмод боомт дээр 270 орчим ам.долларын үнэ хүрч байсан. Гэтэл <http://en.sxcoal.com> цахим хуудсанд тухайн боомтын үнийг мэдээлэхдээ энэхүү тээврийн хэт өндөр зардал шингэсэн 270 орчим ам.долларын үнийг зарлах юм. Иймээс нүүрс экспортлогчид бодит гэрээний үнээс хэт давсан үнээр тооцож татвар төлөхөд хүрнэ. Өмнөх тохиолдлуудад жишиг үнэ болон гэрээний үнэ зөрүүтэй байсан хэдий ч тээврийн зардал бага байсан тул нүүрс экспортлогч компаниуд нь АМНАТ-ийг жишиг үнээр тооцож төлөөд тухайн үеийнхээ нүүрсний үнийн өсөлтөөс бага боловч ашиг олох, ядаж алдагдал хүлээхгүй байх боломжтой байсан.

Нүүрсний борлуулалтын гэрээний үнэ ба жишиг үнийн зөрүүг үүсгэж буй бас нэг хүчин зүйл нь урт хугацаат борлуулалтын гэрээтэй холбоотой. Нэгдүгээрт, нүүрсний компани урт хугацаат борлуулалтын гэрээ байгуулсан үед дэлхийн зах зээлийн үнийн өсөлтөөс шалтгаалсан жишиг үнээр АМНАТ ногдуулах нь шударга бус юм. Хоёрдугаарт, <http://en.sxcoal.com> дээр мэдээлсэн үнийг тооцохдоо урт хугацааны гэрээний үнийг биш тухайн үеийн спот үнийг ашигладаг.

Жишиг үнэ болон компаниудын гэрээний үнийн зөрүүг нүүрсний төрлөөр нь авч үзье. Сул коксжих нүүрсний хувьд жишиг үнэ ба гэрээний дундаж үнийн хоорондын зөрүү 2017 оноос хойш нэлээд өндөр, гэхдээ тогтвортой байсан бол энэ зөрүү 2021 онд нэмэгджээ. Энэ зөрүү бол дээр дурдсан Ковид-19-тэй холбоотой тээврийн зардлаас үүдсэн зөрүү юм. Тухайлбал, АМГТГ-ийн өгсөн мэдээллээр 2021 оны байдлаар сул коксжих нүүрсний компаниудын дундаж үнэ нь 71.0 – 183.0 мянган төгрөгийн хооронд байсан. Гэтэл баяжуулсан болон сул коксжих нүүрснүүдийн жилийн дундаж жишиг үнэ нь харгалзан 577.1 болон 416.6 мянган төгрөг байна.


Зураг 21. Сул коксжих нүүрс, мянган төгрөг/тонн




Эх сурвалж: АМГТГ

Дээрхтэй адилаар, баяжуулсан болон боловсруулаагүй коксжих нүүрсний хувьд, 2014 - 2016 онд коксжих нүүрсний жишиг үнэ, гаалийн үнэ, компаниудын дундаж үнүүдийн хооронд том ялгаа ажиглагдахгүй байна. 2016 оноос хойш жишиг үнэ болон компаниудын дундаж үнийн зөрүү нэмэгдсэн боловч 2021 онд жишиг үнэ нь компаниудын дундаж үнээс бараг гурав дахин өндөр болжээ. Тодруулбал, 2021 онд компаниудын баяжуулсан коксжих нүүрсний дундаж үнэ 120.0 – 400.9 мянган төгрөг, боловсруулаагүй коксжих нүүрсний дундаж үнэ нь 142.5 байсан. Харин АМНАТ тооцсон жишиг үнэ нь баяжуулсан болон боловсруулаагүй коксжих нүүрсний жишиг үнүүд харгалзан 739.6 болон 641.5 мянган төгрөг байна.

Зураг 22. Баяжуулсан коксжих нүүрс, мянган төгрөг/тонн




Зураг 23. Боловсруулаагүй коксжих нүүрс, мянган төгрөг/тонн



Эх сурвалж: АМГТГ, ГЕГ

Жишиг үнэ тогтоох нүүрсний ангилалд эрчим хүчний нүүрс байдаггүй учир “Коксжих чанаргүй нүүрс”-ний ангилалд багтаан АМНАТ-ийг тооцдог. АМГТГ-ын өгсөн мэдээллээр 2021 онд компаниудын эрчим хүчний нүүрсний дундаж үнэ нь 55.0 – 87.3 мянган төгрөг байсан. Гэтэл боловсруулаагүй коксжих чанаргүй нүүрсний жишиг үнийг 2021 онд дунджаар 319.8 мянган төгрөг гэж тогтоож байжээ. Жишиг үнийн энэхүү зөрүү нь компаниудад борлуулалтынхаа орлогын 37 - 58 хувийг АМНАТ -д төлөх нөхцөл байдалд хүргэж байна.

Зураг 24. Антрацит, мянган төгрөг/тонн



Зураг 25. Эрчим хүчний нүүрс, мянган төгрөг/тонн



Эх сурвалж: АМГТГ, ГЕГ


Хэдийгээр үүнд Ковид-19-ийн хязгаарлалт, тээвэр логиستيкийн доголдлоос үүдсэн тээврийн зардлын өсөлт голлон нөлөөлж байгаа боловч жишиг үнийг тогтоохдоо үүнийг харгалзан үзэх шаардлагатай юм.

3.4. Жишиг үнийг тооцох аргачлал

Хэдийгээр ЗГ-ын тогтоол шийдвэрийн дагуу АМНАТ ногдуулах борлуулалтын үнэлгээний суурийг тооцохдоо <http://en.sxcoal.com> цахим хуудаснаас үнийн эх сурвалжийг авдаг гэдэг ч яг ямар арга аргачлалаар жишиг үнийг тогтоож байгаа нь нээлттэй биш байна. Салбарын яам, агентлаг, татвар төлөгч компаниуд ч нүүрсний жишиг үнэ тооцож буй аргачлалын талаар мэдээлэлгүй байсан. Иймээс судалгааны баг Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газарт албан ёсоор хандаж, нүүрсний жишиг үнэ тооцох аргачлалыг гаргаж өгөхийг хүссэн. Сангийн яам албан бичгээр хариу өгсөн боловч, нүүрсний жишиг үнийг тогтооход ЗГ-ын 2016 оны 81-р тогтоолын дагуу БНХАУ-ын нүүрсний зах зээлийн үнийн мэдээллийн эх сурвалж болох <http://en.sxcoal.com> цахим хуудсыг ашиглан мэдээлдэг бөгөөд энэ үнийг БНХАУ-ын нэмэгдсэн өртгийн албан татварыг хасаж тооцдог гэсэн ерөнхий тайлбар өгсөн. Харин тухайн нүүрсний төрөлд аль боомтын ямар үнийг хэрхэн авч ашигладаг талаар нэмэлт тайлбар өгөхөөс татгалзсан.

Иймээс бид жишиг үнэ болон <http://en.sxcoal.com> цахим хуудсанд зарласан үнийн харьцуулалтыг хийсэн. Баяжуулсан коксжих нүүрсний жишиг үнийн хувьд Ганцмод болон Бугат дахь БНХАУ-ын НӨАТ-гүй баяжуулсан коксжих нүүрсний үнэтэй таарч байна. Гэхдээ эдгээр жишиг үнүүд нь нэг сарын хоцролттой байна. Тодруулбал, Сангийн яамнаас тухайн сарын жишиг үнийг гаргахдаа өнгөрсөн сарын sxcoal цахим хуудсанд зарласан үнийг ашиглаж байна. Ингэхдээ 2017 оноос 2021 оны 4-р сар хүртэл sxcoal дахь Бугатын үнийг баримтлан баяжуулсан коксжих нүүрсний жишиг үнийг зарлаж байсан бол 2021 оны 5-р сараас үүнийгээ өөрчлөн Ганцмодын үнийг баримтлан жишиг үнийг зарлах болсон нь доорх зургаас тодорхой харагдаж байна. Эндээс үзвэл, Сангийн яам жишиг үнийг тооцохдоо БНХАУ-ын боомтыг илүү өндөр үнэ зарласан боомтоор сольж тооцжээ. Мөн 2018 оны эхний 3 сарын жишиг үнийг аль боомтын ямар үнэд үндэслэсэн нь тодорхойгүй байна. Харамсалтай нь энэ талаар салбарын оролцогч талуудад ямар нэг мэдээлэл тайлбар өгөөгүй ажээ.

Зураг 26. Баяжуулсан коксжих нүүрсний жишиг үнэ болон sxcoal-ийн үнийн харьцуулалт




Тайлбар: Ганцмод, Бугат дахь баяжуулсан нүүрсний үнийг нэг сараар урагшлуулан зурав

Эх сурвалж: АМГТГ, en.excoal.mn

Харин боловсруулаагүй сул коксжих нүүрсний жишиг үнийг en.excoal.com-оос зарладаг Сэхэ боомтын Washed 1/3 Coking ангиллын нүүрсний үнээс Хятадын НӨАТ-ийг хасан 2020 оны 4-р сар хүртэл авч ашигласан байна. Гэхдээ 2020 оны 5-р сараас хойш аль боомтын ямар нүүрсний үнийг үндэслэж жишиг үнэ зарлах болсон нь тодорхойгүй байгаа нь доорх зургаас тодорхой харагдаж байна. Мөн баяжуулсан коксжих нүүрсний адилаар, жишиг үнийг sxcoal -ийн зарласан үнээс нэг сарын хугацааны хоцрогдолтой тооцож зарлаж байна.

Зураг 27. Боловсруулаагүй сул коксжих нүүрсний жишиг үнэ болон Сэхэ дэх үнийн харьцуулалт



Тайлбар: Ceke Washed 1/3 Coking coal-ийн үнийг нэг сараар урагшлуулж зурав

Эх сурвалж: АМГТГ, en.excoal.mn

Бусад нүүрснүүдийн жишиг үнийг тооцох аргачлал нь тодорхой бус, <http://en.sxcoal.com> дээр зарладаг Бугат, Ганцмод, Сэхэ боомтуудын үнээс БНХАУ-ын НӨАТ-ыг хассан дүнтэй ойролцоо боловч шууд тохирохгүй байгааг тэмдэглэе.

Энд тулгамдаж буй бас нэг асуудал нь жишиг үнэ зарлахдаа зөвхөн БНХАУ-ын Өвөр Монголын өөртөө засах орны боомтуудын үнийг хамруулдаг бөгөөд тус улсын Шинжаан Уйгарын өөртөө засах орны боомтуудын үнийг зарладаггүй. Гэтэл Ховд аймгийн Хөшөөтийн нүүрсний уурхайд

олборлолт эрхэлдэг МоЭнКо компани нүүрсээ Ярант-Тайкешкен боомтоор гаргаж БНХАУ-ын төрийн өмчийн Байяи Стил компанид худалддаг. Мөн Хөшөөтийн нүүрсний чанар харьцангуй доогуур, үнслэг дунджаар 30%, Жи индекс нь 60% байдаг боловч өндөр чанартай нүүрсний үнээр тооцож АМНАТ төлөх шаардлага тавигддаг байна. Энэ бүхний улмаас тус уурхай бүр ч илүү татварын дарамтад орж, үйл ажиллагаагаа зогсооход хүрээд байгаа ажээ.

Дээрх харьцуулалт шинжилгээнд үндэслэн, манай улсын жишиг үнэ тооцож буй аргачлалын талаар таамаглалд үндэслэн дараах дүгнэлтийг хийж болохоор байна. Үүнд:

- 1. Тухайн сарын нүүрсний жишиг үнийг өмнөх сарын <http://en.sxcoal.com>-д зарласан үнийг ашиглаж байна.** Зах зээл хэвийн байх үед нэг сарын дотор том өөрчлөлтүүд гарахгүй учраас энэ нь төдийлөн хүндрэлтэй асуудал биш байж болно. Гэхдээ олон улсын зах зээл хэлбэлзэл өндөртэй, тухайлбал Ковид-19-ийн цар тахалтай холбоотойгоор нөхцөл байдал хурдтай өөрчлөгдөж байгаа үед энэ хоцролт нь нүүрс экспортлогчдод, улмаар улсын төсөвт эрсдэл дагуулж болох юм. Ийм нөхцөл байдал 2020 оны эхэн үед Индонезид тохиолдож байсан бөгөөд тус улсын нүүрс экспортлогчид засгийн газартаа АМНАТ-ийг гэрээний үнээр тооцдог болох хүсэлт гаргаж байсан.
- 2. Жишиг үнэ тооцох аргачлалыг үзэмжээр өөрчилдөг байж болзошгүй байна.** Жишиг үнийг тооцох аргачлал нь ил тод биш байгаагийн дээр тооцох аргачлалаа татвар төлөгчдөд урьдчилан мэдэгдэлгүйгээр өөрчилж байгаа нь салбарын оролцогчдын тодорхой бус байдлыг нэмэгдүүлж байна.
- 3. Жишиг үнийг зарлахдаа БНХАУ-ын НӨАТ-аас бусад зардлуудыг хасаж тооцохгүй байна.** Монголын хилээс гараад тухайн боомтууд хүрэхэд гаалийн татвар, ариутгалын төлбөр, гаалийн бүрдүүлэлтийн төлбөр, хадгалалт ачиж буулгах зардал, байгаль орчны татвар, тээвэрлэлтийн зардлууд нүүрсний үнэ дээр нэмж тооцогддог. Мөн БНХАУ-ын орон нутгийн шинжтэй Баяннуур аймгийг хөгжүүлэх төлбөр гэх мэт татвар хураамжийг хасдаггүй.
- 4. Ковид-19 цар тахалтай холбоотой хилийн хязгаарлалт, тээврийн зардлын өсөлт шингэсэн үнээр тооцож нүүрс олборлогчдод татвар ногдуулах нь илэрхий учир дутагдалтай юм.** Ялангуяа энэ хүндрэлийн суурь шалтгаан болж байгаа цар тахлын дэгдэлт хэр удаан үргэлжлэх нь тодорхойгүй байгаа үед хэт өндөр татварын дарамт нь нүүрс экспортлогчдын үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх нь гарцаагүй юм.
- 5. Жишиг үнийг зарлахдаа БНХАУ-ын Шинжааны боомтын үнийг зарладаггүй.** Үүний улмаас нүүрсний үнэ хямд байдаг Шинжаан муж руу нүүрс экспортолдог Моэнко компани илүү өндөр жишиг үнээр тооцож АМНАТ төлөхөд хүрч байна.

Мөн жишиг үнийн асуудлаас гадна нэг анхаарах ёстой зүйл нь нүүрсний ангилал юм. Учир нь нүүрсний чанарын үзүүлэлт (илчлэг, дэгдэмхий, чийг, үнслэг болон хүхэр) бага зэрэг өөрчлөгдөхөд л үнэд их хэмжээгээр нөлөөлдөг. Судалгааны тайлангийн 2-р бүлэгт танилцуулсан Индонез улсын жишээнээс харахад тэд нүүрсний нэг суурь үнэ зарлах ба нүүрсний нэр төрлийн нарийвчилсан 75 ангилал тус бүрд баримтлах жишиг үнийг тусгай томъёогоор тооцож зарлаж байсан. Манай улсын хувьд ч нүүрсний чанар ангиллын стандартыг боловсронгуй болгож, БНХАУ болон бусад орны зах зээлийн үнэ мэдээлдэг ангилалтай нийцүүлж чадвал Индонезийн жишиг үнэ тооцох аргачлалаас санаа авч нэвтрүүлэх боломжтой. Гэхдээ Индонез нь эрчим хүчний нүүрсний экспортоор дэлхийд тэргүүлэгч бөгөөд дээрх ангиллыг эрчим хүчний нүүрсний хувьд голчлон гаргасан байдаг.

S&P Global Platts нь S&P Global-ийн салбар компани бөгөөд АНУ-ын Нью-Йорк хотод төвтэй, дэлхий даяар 19 оффистой. Газрын тос, байгалийн хий, шингэрүүлсэн хий, цахилгаан эрчим хүч,

нүүрсний салбар, нефть хими, металл, хөдөө аж ахуйн салбар зэргийг судалдаг дэлхийн мега судалгааны байгууллагуудын нэг юм.

Дэлхийн хэмжээнд Ази Номхон далайн бүс нутгийн нүүрс, Атлантын нүүрс гэсэн ерөнхий 2 ангиллын дагуу коксжих нүүрсний арван ерөнхий ангиллаар (2 төрлийн PCI нүүрс, 1 төрлийн сул коксжих нүүрс болон 7 төрлийн металлургийн нүүрс) ачилт/хүргэлтийн байршлаар нь үнийн үнэлгээг гаргадаг ба нүүрсний жишиг чанарын үзүүлэлтүүдээс гадна нүүрсний үнэд чанарын үзүүлэлтүүдээс хамаарсан тохиргоо хийдэг тогтсон аргачлалтай. Тэдний тооцооллоор Австралийн PLV (Premium Low Vol), АНУ-ын LV (Low Vol) коксжих нүүрснүүдийн урвалын хүч (Coke Strength after Reaction ‘CSR’) 1%-иар өсөхөд үнэ нь 1%-иар өсөж байгаа бол нүүрсний дэгдэмхий, чийгшил, хүхэр болон үнслэг 1%-иар нэмэгдэхэд үнэ нь харгалзан 1%-иар буурч байна.

Хүснэгт 20. Нүүрсний чанарын үзүүлэлтүүдийн үнэд үзүүлж буй нөлөө, \$/тн

	Үзүүлэлтийн хамгийн бага болон их утга	Австралийн PLV нүүрсний үнийн (FOB) өөрчлөлт, %	Цэвэр өртөг
CSR-ийн %-ийн өөрчлөлт	67 – 74%	3.00%	13.02
Дэгдэмхийн %-ийн өөрчлөлт	18 – 27%	-0.75%	-3.26
Чийгшлийн %-ийн өөрчлөлт	8 – 11%	-1.00%	-4.34
Үнслэгийн %-ийн өөрчлөлт	7 – 10.5%	0.00%	0.00
Хүхрийн %-ийн өөрчлөлт	0.3 – 1%	-0.25%	-1.09

Эх сурвалж: Platts Coal Trader International

Хүснэгт 21. Нүүрсний чанарын үзүүлэлтүүдийн үнэд үзүүлж буй нөлөө, \$/тн

	Үзүүлэлтийн хамгийн бага болон их утга	АНУ-ын LV нүүрсний үнийн (FOB) өөрчлөлт, %	Цэвэр өртөг
CSR-ийн %-ийн өөрчлөлт	50 – 64%	0.2%	0.85
Чийгшлийн %-ийн өөрчлөлт	6 – 11%	1.00%	4.25
Үнслэгийн %-ийн өөрчлөлт	5 – 10%	1.50%	6.38
Хүхрийн %-ийн өөрчлөлт	0.7 – 1.05%	0.85%	3.61

Эх сурвалж: Platts Coal Trader International

Жич: Австралийн PLV коксжих нүүрсний үнэ 434 ам.доллар/тн, АНУ-ын LV коксжих нүүрсний үнэ 425 ам.доллар/тн байсан зэргийг харгалзан хувьд шилжүүлбэл CSR 1%-иар өсөхөд үнэ нь 1%-иар өсөж байгаа бол нүүрсний дэгдэмхий, чийгшил, хүхэр болон үнслэг 1%-аар нэмэгдэхэд үнэ нь харгалзан 1%-иар буурч байна.

Эндээс харахад нүүрсний жишиг үнийн тооцооллыг нүүрсний төрөлтэй уяж, чанарын үзүүлэлтээс хамааруулсан нарийн томъёо боловсруулж, нүүрсний нарийвчилсан төрөл бүр дээр өөр үнэ тогтоох нь шударга бөгөөд оновчтой байна.

3.5. Ашигт малтмал борлуулах үнэд үзүүлж буй тээвэр, логистик, дэд бүтцийн нөлөөлөл

Нүүрс нь овор жин ихтэй нурмаг бүтээгдэхүүн тул газар нутаг томтой, дэд бүтэц сул хөгжсөн орнуудын нүүрсний экспорт нь тээвэр, логистикийн үлэмж их зардал шаарддаг. Манай улсын хувьд Манай улсын нүүрсний уурхай бүрийн байршил, хилээр нэвтрэх боомтоос хамаараад тээвэрлэлтийн асуудал ялгаатай байдаг. Шивээ хүрэн боомт ачаалал багатай, хил нэвтрэхэд хурдан, Нарийн сухайт ордоос боомт хүртэл 56 км сайжруулсан болон засмал замтай тул нүүрс тээвэрлэлт харьцангуй хүндрэл багатайд тооцогддог. Ховдын Булган боомтын хувьд ч адил, зөвхөн нэг компани нүүрс экспортод гаргадаг тул ачаалал бага, хил нэвтрэхэд бэрхшээл багатай. Харин Таван толгой ордоос хилийн боомт хүртэл 267 км бөгөөд ерөнхийдөө ачаалал ихтэй байдаг.

Манай улсын замын нөхцөлөөс гадна хилийн боомтын нэвтрүүлэх чадвар нэлээд хязгаарлагдмал. Нүүрсийг автомашинаар тээвэрлэдэг нь энэ сул талыг улам хүндрүүлдэг. Ялангуяа Ковид-19 цар тахлаас шалтгаалан БНХАУ-ын талаас нүүрс тээврийн хил нэвтрэлтийг эрс хязгаарлаад байна. Таван толгой уурхайн дэд бүтцийг хөгжүүлэхийн тулд Засгийн газар 2011 оноос хойш тус уурхайгаас Гашуун сухайт боомт хүртэлх 270 км төмөр зам барих ажлыг эхлүүлсэн боловч улс төрийн тодорхойгүй байдал, менежмент, санхүүжилтийн асуудлаас болоод төмөр замын барилгын ажил өдийг хүртэл дуусаагүй үргэлжилж байна. Төмөр зам барих нь зөвхөн тээвэрлэлтийн ачааллыг бууруулаад зогсохгүй байгаль орчинд ээлтэй, тээврийн зардал тавин хувь бага, тээвэрлэлт тогтмолжих оновчтой шийдэл юм. Гэвч төмөр зам барьснаар тээвэр логистикийн асуудал бүрэн шийдэгдэхгүй.

Дотоодын тээвэр, логистикийн хүндрэл нь нөгөө талаасаа зохион байгуулалтын дутагдалтай холбоотой. Нүүрс экспортлогчид нүүрсээ ихэвчлэн уурхайн амнаас борлуулах EXW нөхцөлөөр борлуулдаг бөгөөд нүүрсийг улсын хил хүртэл тээвэрлэх, хил нэвтрүүлж борлуулах үйл ажиллагааг тээвэр зуучийн олон жижиг компаниуд гүйцэтгэдэг. Эдгээр олон жижиг компаниудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулахад хүндрэлтэй бөгөөд энэ хүндрэл нь ялангуяа Ковид-19-ийн цар тахлын үед 2021 онд тээврийн зардлын огцом өсөлтөөр тод илэрч байна. Хил нэвтрэх автомашины тоо хязгаарлагдсан үед тээвэр зуучийн олон жижиг компаниуд хил нэвтрэх эрхийн төлөө өрсөлдөж, улмаар тээврийн зардлын зохиомол өсөлтийг үүсгэсэн гэж дүгнэж болохоор байна. Нүүрс олборлогчид EXW нөхцөлөөр түүхий эдээ уурхайн амнаас ачсанаас хойших тээвэрлэлтийг худалдан авагч буюу тээвэр зуучийн компани хариуцах бөгөөд тээврийн хэрэгсэл өмчлөх шаардлагагүй учраас дэд бүтцийн хөгжил сул орчинд энэ нөхцөл нь уурхайн компаниудад ашигтай нөхцөл юм. Гэхдээ нүүрсний борлуулалтын өртгийн харьцангуй өндөр хувь нь тээвэр зуучийн компаниудад очиж байгаа учраас нүүрсний салбарын хувьд бүхэлд нь авч үзвэл ашиггүй нөхцөл болно. Үүнээс үүдээд салбарын хэмжээнд, эсвэл улсын хэмжээнд тээвэр зуучийн үйл ажиллагааг нэгдсэн журмаар зохицуулсан зохион байгуулалтад оруулбал үр ашиггүй өрсөлдөөн, зохиомол үнийн өсөлтийг шийдвэрлэх боломжтойг салбарын зарим мэргэжилтэн зөвлөдөг.

Дээрх бэрхшээлүүд нь нүүрсний жишиг үнэ, хил дээрх үнэ, компаниудын борлуулалтын гэрээний үнийн зөрүүг үүсгэж буй гол хүчин зүйлсийн нэг юм. <http://en.sxcoal.com> цахим хуудаст зарлаж байгаа Хятадын боомтууд дахь нүүрсний үнэ нь тус боомт хүртэл гарсан бүх зардлыг шингээсэн үнэ байдаг. Эдгээр зардалд тээвэрлэлтийн зардал НӨАТ, гаалийн хураамж, талбайн зардал, импортын татвар, байгаль орчны татвар, ариутгалын төлбөр зэрэг зардлууд багтдаг. Гэтэл Монголын талаас уурхайн аман дээрээсээ зарж байгаа ба тиймээс жишиг үнэ болон гэрээний үнийн хооронд асар их зөрүү гарч байна. Ялангуяа 2021 онд хил гаалийн зардал, тээврийн зардал эрс нэмэгдсэнээр үнийн зөрүүг улам ихэсгэжээ.

Жишээлбэл, 2021 онд Ганцмод боомтод баяжуулсан коксжих нүүрсний дундаж үнэ нь 2030 юань/тонн байсан бол Цагаан хадад 715 юань/тонн байжээ. Энэхүү үнийн зөрүүний ихэнх хэсгийг тээврийн зардал эзэлж байгаа ба тээврийн зардал нь нүүрсний үнээсээ ч давсан байна. Компаниудын мэдээлж байгаагаар 2021 онд Цагаан хад – Ганцмодын тээврийн зардал нь 2100 юань/тонн хүрсэн тохиолдол гарсан байна.

Компаниудын гэрээний үнэ болон жишиг үнийн зөрүүг Хятадын НӨАТ, гаалийн хураамж болон бусад зардлыг тооцон харьцуулсан үр дүнг нүүрсний төрлөөр ангилан дараах хүснэгтүүдэд харуулав.

Хүснэгт 21. Цагаан хад – Ганцмод нүүрс тээвэрлэх зардал, 2021 оны дунджаар, юань/тонн

Татвар, суутгал	Баяжуулсан коксжих	Түүхий коксжих
FOT/EXW Ганцмод үнэ (http://en.sxcoal.com)	2,030	1,693
НӨАТ	234	195
Хятадын гаалийн хураамж, талбайн зардал	30	30
Импортын татвар	51	43
DAP Ганцмод үнэ	1,715	1,425
Тээврийн зардал Цагаанхад - Ганцмод	1,000	1,000
Цагаан хад үнэ	715	425

Тайлбар: НӨАТ 13%, импортын татвар 3%, Гаалийн хураамж 3%

Эх сурвалж: Нүүрс экспортлогч компаниудын мэдээлэл

Хүснэгт 22. Нарийн сухайт – Сэхэ нүүрс тээвэрлэх зардал, 2021 оны дунджаар, юань/тонн

Татвар суутгал	Өртөг	Тайлбар
FOT/EXW Сэхэ үнэ (http://en.sxcoal.com)	1139.7	
Хятад дахь зардал	182.5	
НӨАТ	131.1	
Ариутгалын төлбөр	0.04	1 машин тутам 4 юань
Гаалийн бүрдүүлэлтийн төлбөр	1.4	Тонн тутам 1.5 юань
Хадгалалт ачиж буулгах зардал	18	Тонн тутам 18 юань
Байгаль орчны татвар	3.2	Тонн тутам 3.15 юань
Гаалийн татвар	28.7	3%
Монгол дахь зардал	79.5	
Тээврийн зардал	75.0	
Гаалийн хураамж бусад	3.4	
С зөвшөөрлийн төлбөр	0.1	
Ариутгалын төлбөр	0.15	
Бусад зардал	088	
Нарийн сухайт дахь үнэ	877.6	

Эх сурвалж: Нүүрс экспортлогч компаниудын мэдээлэл

Дээрх хүснэгтүүдээс харвал, <http://en.sxcoal.com> цахим хуудасны мэдээлэлд үндэслэн Сангийн яамнаас зарлаж буй жишиг үнэ нь хэдийгээр БНХАУ-ын НӨАТ-ын татварыг хасдаг боловч АМНАТ ногдох борлуулалтын үнэлгээнээс хасдаг боловч БНХАУ-ын талд гарч буй бусад зардлыг хасахгүй байна. Жишээлбэл, 2021 онд Таван толгойн ордоос гарч буй баяжуулсан нүүрсэнд тонн тутамд 81 юань, боловсруулаагүй коксжих нүүрсэнд тонн тутамд 73 юань, Нарийн сухайт ордоос гарч буй нүүрсний хувьд 51 юанийг хасаж байж Монголын хил дээрх жишиг үнийг илүү бодитой тооцож зарлах шаардлагатай болж байна.

Үүнээс гадна, жишиг үнэд орж тооцогддог боловч нүүрс экспортлогчдын борлуулалтын гэрээнд төдийлөн тусдаггүй зардал бол тээврийн зардал юм. Улсын хил хүртэлх зай ойрхон учраас Нарийн сухайтын ордын нүүрсэнд тээврийн зардлын энэ нөлөө харьцангуй бага байна. Харин тээвэр логистикийн хүндрэлтэй Таван толгойн нүүрсний хувьд энэ бол гол асуудал болдог. 2021 оны тухайд Таван толгойн ордын нүүрс олборлогчдын АМНАТ тооцоход нөлөөлж буй үнийн өсөлтийн гол шалтгаан нь Цагаан хаднаас Ганц мод боомт руу нэвтрэх хүртэлх тээврийн зардал (1000 юань) болж байна. Түүхий коксжих нүүрс борлуулж буй компаниудын хувьд тээврийн зардал нь нүүрсний үнээсээ 2 дахин давж буй тооцоог дээрх хүснэгт харуулж байна.


3.6. Нүүрс экспортлогчдод ногдож буй татварын ачаалал

Ашигт малтмал олборлогчид бусад бизнес эрхлэгчдийн адил улсын болон орон нутгийн татвар хураамжуудыг төлөхийн зэрэгцээ салбарын онцлогтой нэмэлт татвар, хураамжийг төлдөг. Татварын энэ ачаалал сүүлийн жилүүдэд хэрхэн өөрчлөгдөж ирснийг өнөөгийн нөхцөл байдалтай холбон харьцуулж авч үзье.

Ашигт малтмалын хуульд зааснаар нүүрсний экспортлогчид борлуулалтынхаа орлогоос суурь АМНАТ 5%, үнээс хамаарсан өсөн нэмэгдэх АМНАТ 5% хүртэл, нийт 10% хүртэл татвар төлдөг. Баяжуулсан нүүрсний хувь АМНАТ-ийн дээд хувь хэмжээ 8%. Гэвч АМНАТ ногдох борлуулалтын үнэлгээг хэрхэн тооцохоос татварын энэхүү ачаалал ихээхэн хамаарна. Хэрвээ энэ тооцоонд жишиг үнэ баримтлах үед жишиг үнэ нь экспортлогчдын бодит гэрээний үнээс давбал экспортлогчдын бодит орлогод ногдох үр нөлөөтэй хувь (effective rate) нь дээрх 10%, 8% гэсэн дээд түвшнээс давах болно.

Энэ судалгааны хүрээнд 2014-2020 оны нүүрс экспортлогч компаниудын төлсөн АМНАТ-ийн борлуулалтын орлогод эзлэх хэмжээг Олборлох Үйлдвэрлэлийн Ил Тод Байдлын Санаачилга (ОУИТБС)-ын тоон мэдээлэлд үндэслэн тооцов (Зураг 28. Нүүрсний борлуулалтын орлогод ногдох АМНАТ-ийн хувь хэмжээ). Судалгаанд нүүрс экспортлогч 38 компанийн мэдээллийг ашигласан.

Зураг 28. Нүүрсний борлуулалтын орлогод ногдох АМНАТ-ийн хувь хэмжээ




Эх сурвалж: EITI, Нүүрс ассоциаци, судлаачийн тооцоолол

Зургаас харахад, нүүрс экспортлогчдын борлуулалтын нийт орлогод ногдож буй АМНАТ төлсөн хувь хэмжээ нь нүүрсний үнэ бага байсан 2016 оны үед хамгийн бага, 5.5% байсан бол түүнээс хойш нүүрсний үнийн өсөлтийг даган тасралтгүй нэмэгдэж иржээ. Энэ өсөлт нь Ашигт малтмалын хуулиар тогтоосон өсөн нэмэгдэх татварын хувь хэмжээнээс голлон хамаарна. Харин 2021 онд АМНАТ-ийн ачааллын хувь хэмжээ огцом нэмэгдсэн байна. Хэдийгээр ОУИТБС-ын тоон мэдээлэлд 2021 оны компаниудын мэдээлэл ороогүй байгаа боловч Монгол нүүрс ассоциацийн цуглуулсан нүүрс экспортлогч 9 гол компанийн тоо мэдээлэлд үндэслэн 2021 оны хувь хэмжээг тооцсон. 9 компанийн мэдээлсэн жилийн дундаж АМНАТ-ийн ачааллын дунджийг тооцоход дор хаяж 20.0% гарч байна. Компаниудын өөрсдийн тооцсон АМНАТ ба борлуулалтын орлогын харьцаа буюу ачааллын арифметик дундаж бүр 24.8% хүрч байна. Зарим компаниудын мэдээлж байгаагаар АМНАТ-ийн ачаалал буюу борлуулалтын орлогод ногдуулж буй АМНАТ нь оны хоёрдугаар хагаст 30 хувь хүрч байжээ.

АМНАТ ногдох борлуулалтын үнэлгээг жишиг үнэд үндэслэн тооцох 2021 оны 6-р сарын 3Г-ын шийдвэрээс шалтгаалан салбарын хэмжээнд үүсээд байгаа алдагдсан боломж, зардлыг нарийн тооцох боломж, тоо мэдээлэл хангалтгүй байна. Гэхдээ судалгааны багт ирүүлсэн нүүрс экспортлогч 3 компанийн мэдээллээс харахад, 2021 оны сүүлийн хагаст жишиг үнээр тооцон ногдуулсан АМНАТ-ийн хэмжээ нь хэрвээ гэрээний үнээр тооцсон бол төлөх АМНАТ-ийн хэмжээнээс 3 дахин өндөр байна. АМНАТ-ийн ачаалал буюу ногдуулсан АМНАТ ба борлуулалтын орлогын харьцаа дунжаар 20%, 2021 оны 9-10-р сард дээд тал нь 26% хүрч байжээ.


Зураг 29. Компаниудын үүрсэн АМНАТ-ийн ачаалал, 2021 оны сүүлийн хагас



Эх сурвалж: Холбогдох компаниудын мэдээлэл

Дээрх АМНАТ-ийн ачааллаас гадна бусад татварын ачааллыг бас харгалзан үзэх ёстой. Манай улсын хувьд уул уурхайн компаниуд бусад аж ахуйн нэгжийн адил ААНОАТ, НӨАТ, гаалийн татвар татварыг нэгэн адил төлөхийн зэрэгцээ зөвхөн уул уурхайн компаниудын төлдөг агаарын бохирдлын, лицензийн төлбөр гэх мэт бусад татвар хураамжийг ч төлдөг. Аж ахуйн нэгжүүдийн нийтлэг төлдөг татваруудын хувь хэмжээ ямар түвшинд байгааг дараах зурагт харуулав. Нүүрс экспортлогчдын төлдөг гол татвар орлогын татвар ААНОАТ бөгөөд хоёр шатлалт энэ татварын хувьд нүүрс экспортлогч ихэнх компаниуд хамгийн өндөр хувь болох 25%-ийг цэвэр орлогоос төлдөг.

Зураг 30. Монгол Улсын зарим татварын хувь хэмжээ (%), 2000-2021 он



Татварын ерөнхий газар

Манай улсын хувьд компанийн цэвэр ашигт ногдуулах татварын үр нөлөөтэй хувь (effective tax rate)-аар дундаж орны тоонд тооцогддог боловч нүүрс экспортлогчдын борлуулалтын орлогод ногдуулах АМНАТ-ийн хувийг цэвэр ашигт нь хөрвүүлж тооцвол татварын дарамт өндөртэй орны тоонд орно. Ялангуяа 2021 оны 7-р сараас хойш нүүрс экспортлогчдод ногдуулаад буй хэт их төлбөр нь татварын дарамтыг улам ихэсгэж байгааг анхаарч, зөв зохистой арга хэмжээ авах шаардлагатай байна.

Ковид-19 цар тахлаас үүдэлтэй тээврийн зардлын өсөлт, жишиг үнээр АМНАТ тооцох болсон шийдвэрийн нөлөөгөөр чанар муутай нүүрсний экспорт эрс буурч байгааг нүүрс экспортлогчид мэдээлж байна. Жишиг үнээр тооцсон АМНАТ хэт өндөр байгаагаас зарим төрлийн нүүрсний борлуулалт зардлаа нөхөж чадахгүйд хүрч байгаа тул нүүрсний овоолго нэмэгдэхэд нөлөөлжээ. Хэдийгээр нүүрс экспортлогчдоос салбарын хэмжээнд чанар багатай нүүрсний овоолго хэр их нэмэгдсэн талаар тоон мэдээлэл цуглаагүй боловч үүнийг бүтээгдэхүүний нөөцийн хуримтлалыг

Монголын нөхцөлд эргэлтийн хөрөнгийн хуримтлал нь уул уурхайн бүтээгдэхүүний нөөцөөс голчлон бүрддэг. Доорх зурагт харуулснаар эргэлтийн хөрөнгийн нийт хуримтлал нь 2020 оны IV улирлаас хойш тасралтгүй өссөн бөгөөд 2021 оны III улиралд дээд цэгтээ хүрсэн. Ийнхүү III улиралд өсөхөд хил хаагдсан болон жишиг үнээр АМНАТ тооцож эхэлсэн зэргээс шалтгаалж нүүрсний овоолго нэмэгдсэн нь үүнд голлон нөлөөлсөн гэж дүгнэж болно. Түүнчлэн нүүрсний гаалийн дундаж үнэ нь 2021 оны III улирлаас эрс өсөж эхэлсэн. Энэ нь чанар багатай үнэ хямд нүүрсний оронд чанар сайтай, үнэтэй нүүрс түлхүү гарч, нүүрсний дундаж үнийг өсгөсний нөлөөг агуулж байж болох юм.

Хугацаа	Эргэлтийн хөрөнгийн нийт хуримтлал /зүүн/ (MNT)	Үндсэн хөрөнгийн хуримтлал /зүүн/ (MNT)	Нүүрсний гаалийн дундаж үнэ (\$/тонн) /баруун/ (\$/ton)
2020-I	1400	1300	~50
2020-II	1800	1700	~50
2020-III	-500	2300	~50
2020-IV	0	1500	~50
2021-I	1000	1600	~100
2021-II	1000	1900	~150
2021-III	2100	2100	~200
2021-IV	0	2300	~350


Нүүрс хэмээх ашигт малтмал нь геологийн урт хугацааны явцад бүрэлдэхдээ өөр өөр шинж чанар бүхий олон үет давхарга байдлаар бүрддэг бөгөөд түүнийг ил аргаар олборлох нь тусгай технологи, дараалал шаарддаг. Дэлхийн зах зээлийн үнэ ихээр буурвал тухайн уурхай үйл ажиллагаагаа үргэлжлүүлэхийн тулд аль болох үнэлгээ өндөртэй давхаргын нүүрсээ сорчлон олборлож борлуулах сонирхол үүснэ. Дэлхийн зах зээлд нүүрсний үнэ нэмэгдсэн ч компаниудын борлуулсан бодит үнээс өндрөөр борлуулалтын орлогыг үнэлж татвар тогтоох нь компаниудад дэлхийн зах зээлийн үнэ буурсантай адил нөлөөлж, үнэлгээ багатай нүүрсний давхаргаа олборлохгүй байх, сорчлон олборлох олборлож бэлдсэн үнэлгээ багатай нүүрсний овоолгоо борлуулж чадахгүй байх нөхцөл үүсэж болзошгүй юм. Ингэснээр үнэлгээ багатай нүүрсний доод давхаргын сайн чанартай нүүрсээ ч олборлох боломжгүй болох юм. Өөрөөр хэлбэл, тухайн орд баялгийн нөөцийг бүрэн дүүрэн ашиглах хуульд заасан суурь зарчим биелэхгүйд хүрэх эрсдэлтэй байгааг анхаарах шаардлагатай байна.

4. Дүгнэлт ба санал зөвлөмж

Ковид-19 цар тахлын нөлөөгөөр нүүрсний салбарын компаниуд үйл ажиллагаа болон санхүүгийн бэрхшээлтэй тулгарч, хил нэвтрэх үйл ажиллагаа удааширснаас үүдэн нүүрсний экспортын тээврийн зардал огцом өсөөд байна. Энэ үед нүүрс олборлогчдын АМНАТ ногдуулах борлуулалтын үнэлгээний аргачлал гэнэт өөрчлөгдөж төлөх АМНАТ-ийн хэмжээ огцом өссөн. АМНАТ ногдуулах борлуулалтын үнэлгээ тооцох аргачлалтай холбоотой нөхцөл байдлыг гүнзгийрүүлж авч үзсэн энэхүү судалгаагаар тодруулсан бодлогын асуудлуудыг энэ хэсэгт тоймлож авч үзье.

4.1. АМНАТ-ийн зохимжтой хувь хэмжээ, татварын бодлого

1. Макроэкономикс, татварын онолд татварын оновчтой хувь хэмжээний тухай Лафферын муруй (Laffer curve) гэсэн ойлголт байдаг. Энэ нь хэрвээ татварын хувь хэмжээ ихээхэн бага үед татварын хувийг нэмснээр татварын нийт орлого нэмэгдэж болох ч тодорхой түвшнээс цааш үргэлжлүүлэн нэмэх нь татварын ачааллыг хэт нэмэгдүүлж, татвар төлөгчдийн орлого олох сонирхлыг бууруулах, үйлдвэрлэл борлуулалтаа бууруулахаас аргагүй байдал руу түлхдэг гэсэн онол юм. Доорх зурагт харуулснаар, төсвийн орлогыг хамгийн их байлгах татварын оновчтой хувь хэмжээ гэж байдаг бөгөөд татварын хувь хэмжээг түүнээс илүү түвшинд хүргэж нэмбэл татварын бааз суурь хумигдаж улмаар төсвийн орлого буурдаг.



АМНАТ ногдуулах борлуулалтын үнэлгээг бодит байдлаас өндрөөр тооцож татвар ногдуулах нь үнэн хэрэгтээ АМНАТ-ийн хуульд заасан хувь хэмжээг далд байдлаар өсгөж татварын орлогыг нэмэгдүүлэх гэсэн оролдлого юм. Гэхдээ нүүрс экспортлогчдод ногдуулж буй энэхүү татварын илүүдэл дарамт төсвийн орлогыг үнэхээр нэмэх үү, эсвэл татварын бааз суурийг хүчтэй хумин төсвийн орлогод сөргөөр нөлөөлөх үү гэдэг нь тодорхойгүй байна. Судалгааны тайлангийн өмнөх бүлэгт танилцуулснаар, хамгийн ихдээ борлуулалтын орлогын 10%-тай тэнцүү байх ёстой АМНАТ-ийн хувь хэмжээ нь компаниудын өгсөн мэдээллээр, дэлхийн зах зээлд нүүрсний үнэ өсөөгүй байх үед ч аль хэдийнээ уг 10%-ийг давдаг байсан бөгөөд 2021 онд дунджаар 20-25% хүрч нэмэгдсэн нь маш их дарамт юм. Учир нь АМНАТ-ийг борлуулалтын орлогод ноогдуулдаг бөгөөд хэрвээ үүнийг компанийн цэвэр ашигт ногдуулдаг ААНОАТ-д хөрвүүлж тооцвол “үр нөлөөтэй татварын хувь” (effective tax rate) хэд дахин нэмэгдэхээр байна. Үүн дээр

ААНОАТ-ын 25% болон бусад гол татварууд, агаарын бохирдлын хураамж гэх мэт элдэв төлбөр хураамжийг нэмж тооцвол маш өндөр дүн гарна. Татварын илүүдэл дарамт нь татварын бааз суурийг хумьснаараа төсвийн орлогыг бууруулах, эдийн засгийн хамгийн гол салбаруудын нэг болох уул уурхайн салбарын үйлдвэрлэл, экспортыг бууруулах, хөрөнгө оруулалтыг сааруулах гэх мэт сөрөг нөлөөг дагуулна.

2. Жишиг үнийг тооцоолох аргачлал үндэслэл муутай тогтоогдож, татварын байгууллага болон экспортлогч компаниудын хооронд маргаан үүссэнээс шалтгаалан нүүрсний экспорт саатах, сорчлон олборлох, нүүрсний зарим орд давхарга ашиглалтгүй үлдэх, олборлосон нүүрс борлуулагдахгүй удсанаас шалтгаалж хаягдах эрсдэл үүсээд байна. Энэ нь байгалийн баялгийг зөв зохистой ашиглах, үнэ цэнэ хүргэх төрийн бодлоготой зөрчилдөхөд хүрч байна.
3. Манай улсад АМНАТ болон бусад татварын оновчтой хэмжээг тооцож тогтоосон судалгаа, тооцоо байдаггүй. Иймээс жишээ нь нүүрсний АМНАТ-ийн суурь түвшин болох 5%, үнээс хамаарсан өсөн нэмэгдэх хувийн 1%-5% шатлал, өсөн нэмэгдэх хувь тооцоход үндэслэсэн нүүрсний үнийн босго утгуудыг (25\$, 50\$ гэх мэт) ямар тооцоонд үндэслэж тогтоосон нь бүрхэг байна. Зүй нь ийм тооцооллыг онолын тусгай загвар дээр туршиж, салбарын болон холбогдох оролцогчдын санал бодлыг тусгаж, хэлэлцүүлж байж тогтоох учиртай.
4. Өсөн нэмэгдэх АМНАТ-ийн өсөн нэмэгдэх хувийг үнийн өссөн дүнгээс биш нийт үнээс авч байгаа нь шударга биш зарчим юм. Жишээлбэл, тонн түүхий нүүрсний үнэ 24.9 ам.доллар байхад АМНАТ 5% буюу 1.25 ам.доллар төлж байснаа нүүрсний үнэ 25 ам доллар хүрэхэд 6% буюу 1.5 ам.доллар төлөх ёстой болно. Өөрөөр хэлбэл, нүүрсний үнэ бага байхад АМНАТ-ийн дараах орлого 23.65 ам.доллар байсан бол нүүрсний үнэ өссөн үед АМНАТ-ийн дараах орлого 23.5 ам доллар болж буурч байна. Энэ гажуудлыг арилгахын тулд өсөн нэмэгдэх АМНАТ-ийн хувийг үнийн өссөн дүнгээс шатлан тооцох шаардлагатай.
5. Бодлогын хувьд анхаарах бас нэг зүйл бол Ковид-19 цар тахлын сөрөг нөлөөнд хамгийн хүчтэй нэрвэгдсэн салбаруудын нэг нь, уул уурхайн салбар, тэр дундаа тээвэр, логистикоос хамгийн их хамааралтай нүүрсний салбар юм. 2020 оны 1-р сард улсын хэмжээнд өндөржүүлсэн бэлэн байдал зарласнаас хойш одоог хүртэл экспортын үйл ажиллагаа нь хязгаарлагдаж, тасалдаж байгаа тус салбарын хүндрэл дээр АМНАТ ногдуулах борлуулалтын үнэлгээг жишиг үнээр тооцох болсон гэнэтийн шийдвэр маш том цохилт болж байгааг зайлшгүй тэмдэглэх шаардлагатай. ЭЗСЭШХ-ийн 2021 оны 4-р сард гүйцэтгэсэн түүвэр судалгаагаар, 2020 онд уул уурхайн компаниудын 42%-ийн борлуулалт буурсан, 67%-ийн борлуулалтын төлөвлөгөө нь тасарч, 78% нь санхүүгийн хүндрэлд орж байжээ¹⁸. 2021 онд ч энэ байдал үргэлжилсэн. Цар тахлын хүндрэлтэй үеийг даван туулах, тээвэр логистикийн суурь хүндрэлийг шийдвэрлэх, нэмүү өртөг шингэсэн боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэх том сорилтууд тус тус хүлээгдэж байгааг харгалзан үзэх шаардлагатай. Мөн урт хугацаанд дэлхийн улс орнууд хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, эрчим хүчний цэвэр эх үүсвэрийг нэмэгдүүлэхийн тулд нүүрсний хэрэглээнээс татгалзах, нүүрсний олборлолтыг хязгаарлах амлалт өгч, энэ чиглэлээр арга хэмжээ авч эхэлснийг ч харгалзан үзэх нь зүйтэй.
6. Уул уурхайн компаниудын төлсөн татвар, АМНАТ-ийн мэдээлэл хүртээмж, чанар муутай байна. Уул уурхайн компаниуд олборлолт, борлуулалт, улсын болон орон нутгийн төсөв төлсөн татвар гэх мэт гол мэдээллүүдээ Засгийн газарт тайлагнадаг боловч

¹⁸ Эдийн засгийн судалгаа эрдэм шинжилгээний хүрээлэн (2021 он), “Уул уурхайн салбарт Ковид-19-ийн үзүүлсэн нөлөө”.

уг мэдээлэл уул уурхайн салбар болон олон нийтэд хүртээмжгүй байна. Зарчмын хувьд олборлох салбарын мэдээлэл олон нийтэд ил тод нээлттэй байх ёстой. Энэ ажлыг хариуцаж буй байгууллага нь одоогоор “Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга”-ын Монгол дахь ажлын алба юм. Монгол Улс уг санаачилгад 2006 оноос нэгдсэн бөгөөд Монгол дахь ажлын алба нь одоогоор УУХҮЯ-ны харьяанд ажилладаг. Гэхдээ ОҮИТБС-ын цахим мэдээллийн санд буй уул уурхайн компаниудын мэдээллүүд алдаа ихтэй, нэгтгэж боловсруулахад төвөгтэй, хоцролт ихтэй зэрэг нь энэхүү судалгааны явцад ажиглагдаж байна.

7. Манай улсад АМНАТ-ийг аж үйлдвэржилтийг дэмжих хөшүүрэг болгон ашиглах зохицуулалт учир дутагдалтай байна. Жишээ нь, нүүрсний хувьд боловсруулалт хийсэн ч өсөн нэмэгдэх АМНАТ-ийн босго үнийг боловсруулсан бүтээгдэхүүний үнэтэй уялдаагүй, хэт доогуур тогтоосон тул энэ нь татварын бодитой дэмжлэг болж чадахгүй байна. Жишээ нь, БНХАУ-д АМНАТ-ийн суурь түвшнийг боловсруулалтын түвшинтэй уялдуулж хөнгөлөх боломжтой байдаг.
8. Хэдийгээр манай улс дэлхийн нүүрсний зах зээлийн хамгийн том худалдан авагчтай шууд хиллэдэг боловч тээвэр логистикийн хүндрэлээс болоод уг зах зээлд эзлэх байр сууриа тогтвортой хадгалж чаддаггүй. Гэтэл Австрали, Индонези зэрэг улсууд далайн тээврээр, ОХУ зэрэг улсууд төмөр зам ба далайн тээврээр хослуулан уг зах зээлд нүүрсээ хямд зардлаар нийлүүлэх давуу талтай байдаг. Байгалийн болон дэд бүтцийн эдгээр давуу талаас гадна эдгээр улсын нүүрсний экспортлогчид татварын бодлогын хувьд ихээхэн давуу талтай байдгийг энэ тайлангийн 2-р бүлэгт танилцуулсан кэйс судалгаанаас харж болно. Жишээлбэл, манай улсын гол өрсөлдөгчдийн нэг болох ОХУ-ын эрчим хүчний нүүрс экспортлогчид олборлолтын хэмжээнд суурилсан маш бага татвар төлдөг бол коксжих нүүрс олборлогчид нь Австралийн нүүрсний үнээр тооцсон борлуулалтын орлогын 1.5%-тай тэнцэх АМНАТ төлдөг. Иймээс уул уурхайн салбар дахь АМНАТ болон бусад татвартай холбоотой асуудалд эдийн засгийн гол тулгуур болж байгаа нүүрсний салбарын өрсөлдөх чадварыг байнга анхаарч байх нь чухал.
9. Монгол Улсын хувьд Нүүрсний салбар нь экспорт, улсын төсөв, дотоодын нийт бүтээгдэхүүнд хамгийн их нөлөөтэй дэд салбар учраас уг салбарын үйл ажиллагаанд нөлөөлөх аливаа шийдвэрийг маш сайн судалж, олон талын оролцоотой хэлэлцэж гаргадаг байх шаардлагатай юм. Түүхий эдийн үнийн хэлбэлзэл, халдварт өвчин гэх мэт давагдашгүй хүчин зүйлээс шалтгаалан салбарын үйл ажиллагаа доголдсон үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх туршлага, зөвлөмжийг судалж бэлтгэх шаардлага ч тавигдаж байна.

4.2. Нүүрсний жишиг үнэ тооцох аргачлал

1. Нүүрсний тээврийн зардал нь жишиг үнэ ба борлуулалтын үнийн зөрөөг голлон тодорхойлж байгаа хүчин зүйл. Манай улсын нүүрсний салбарын хувьд, ялангуяа Таван толгойн ордоос экспортлох нүүрсний хувьд дэд бүтцийн сул хөгжил, зохион байгуулалтын хомсдолоос шалтгаалсан тээврийн зардал үлэмж их байдаг. Энэ зардал Ковид-19 цар тахлаас үүдэн хил нэвтрэлт удааширсан үед огцом нэмэгдсэн. Таван толгой ордоос Гашуунсухайт боомт хүртэлх тээврийн өндөр зардал бол үндсэндээ нүүрс тээвэрлэлтийн үйл ажиллагаа дүрэм журамгүй, зохион байгуулалтгүй, үр ашиггүй, авилгатай холбогдсон байгаагийн илрэл юм.
2. Манай улсын хувьд экспортолсон, экспортлохоор ачуулсан нүүрсэнд АМНАТ ногдуулах борлуулалтын үнэлгээг тооцоход үндэслэж буй жишиг үнийг хэрхэн тооцож буй аргачлал ил тод биш, эргэлзээ төрүүлэхүйц байна. Хэдийгээр ЗГ-ын тогтоолуудад

нүүрсний борлуулалтын үнэлгээний үндэслэл болгох эх сурвалжийг БНХАУ-ын <http://en.sxcoal.com> цахим хуудас байхаар заасан боловч үүнд үндэслэн жишиг үнийг тогтоохдоо уг эх сурвалжийн аль боомтын, ямар зэрэглэлийн нүүрсний үнийг хэрхэн сонгож байгаа нь тодорхойгүй байна. Сангийн яам дээрх цахим хуудасны зарласан үнээс БНХАУ-ын НӨАТ-ыг хасдаг гэж мэдээлсэн бөгөөд уг үнээс хасвал зохих импортлогч талын бусад татвар, боомтын зардлууд, зуучлагч компанийн ашгийг хасдаггүй ажээ. Судалгааны явцад уг аргачлалын талаар нүүрс экспортлогч компаниуд, АМГТГ-аас тодруулахад, энэ аргачлалын талаар тодорхой мэдээлэлгүй, Сангийн яамны тооцсон жишиг үнийг л шууд хүлээн авдаг гэж мэдээлсэн. Нүүрсний жишиг үнийг зарлаж эхэлснээс хойш олон жил өнгөрч байгаа боловч АМНАТ төлөгчид, уул уурхайн салбарын төрийн байгууллагууд одоо хүртэл энэ аргачлалыг тодорхой мэдэхгүй байгаа нь хачирхалтай юм. Энэ байдал нь нүүрс экспортлогчдод тодорхойгүй байдал, эрсдэлийг нэмэгдүүлэх нэг хүчин зүйл болж байна. Гэтэл АМНАТ ногдуулах борлуулалтын үнэлгээнд жишиг үнийг харгалздаг Индонез, ОХУ зэрэг орнуудын кэйс судалгаанаас харахад, эдгээр улсын жишиг үнэ тооцох аргачлал нь бүх оролцогч талуудад ил тод, нээлттэй, томъёо тайлбар нь ойлгомжтой байна (Эдгээр аргачлал, томъёог энэхүү тайлангийн 2-р бүлэгт дэлгэрэнгүй дурдсан).

3. Засгийн газар 2021 оны 6-р сарын 23-ны өдрийн 174-р тогтоол гаргаж, АМНАТ ногдуулах борлуулалтын үнэлгээг жишиг үнээр тооцох болсон шийдвэрийн үндэслэл, судалгаа тооцоо тодорхойгүй байна. Ер нь ЗГ-ын 2007 оны 88-р тогтоолоор нүүрсний борлуулалтын үнэлгээг тооцох ерөнхий заалтыг баталснаас хойш энэ аргачлал маш олон удаа өөрчлөгдөж ирсэн бөгөөд тэр бүрийд ямар тооцоо, бодит шаардлагад үндэслэсэн талаарх ямар нэг судалгаа, баримт байгаа эсэх нь тодорхойгүй байна. Жишээлбэл, эдгээр асуудлыг хэлэлцэж шийдвэрлэсэн Засгийн газрын хуралдааны тэмдэглэл нээлттэй, ил тод биш байна.
4. АМНАТ ногдуулахад жишиг үнэ баримтлах аргын нэг сул тал нь АМНАТ ногдуулах борлуулалтын үнэлгээг тооцох асуудал нүүрсний борлуулалтын орлогыг бодитой зөв тогтоох гэхээсээ илүүтэй тухайн борлуулсан нүүрсний шинж чанар, ангиллыг нарийн тодорхойлж түүнийгээ бусад улсын нүүрстэй харьцуулалт хийх төвөгтэй ажил болж хувирдаг. Гэтэл аливаа татварын тогтолцооны нэг гол зарчим нь тухайн татвар энгийн ойлгомжтой байх зарчим байдаг. Ялангуяа нүүрсний хувьд уурхай бүрийн нүүрсний шинж чанар нь маш олон параметрээс хамаараад өөр өөр, нэг уурхайн хувьд ч нүүрсний давхаргаас хамаараад шинж чанар нь өөр өөр байдаг. Энэ онцлог шинж бүрийг харгалзан зөв зохистой нүүрсний ангилал, стандартыг тогтоох нь татварын зорилгоор байтугай инженерийн болон шинжлэх ухааны хувьд ч маргаантай асуудал байдаг.
5. 2021 оны 7-р сарын 1-ээс бүх төрлийн нүүрсний экспортын борлуулалтын үнэлгээг жишиг үнэд үндэслэн тооцох болсноор Монгол Улсын гадаад худалдаа, экспортын албан ёсны статистик бодит байдлаас ихээхэн гажуудалтай, хэт өндөр тооцогдох эрсдэлтэй байна. Учир нь манай улсын экспортын бүх албан ёсны статистик гаалийн бүртгэлийн тоон мэдээнд тулгуурладаг. Харин гаалийн бүртгэлд бүх төрлийн нүүрсний үнийг бүртгэхдээ хил хүртэлх нөхцөлтэй борлуулалтын гэрээний үнэлгээнд суурилалгүй хэт өндөр тогтоогдсон жишиг үнээр экспортын дүнг бүртгэж мэдээлэх нөхцөл байдал үүсээд байгаа юм. Хэрвээ манай улсын экспортын орлогын хамгийн гол эх үүсвэрийн бүртгэл тооцоо ийнхүү бодит байдлаас зөрүүтэй гарах нь үндэсний тооцоо, төлбөрийн тэнцэл гэх мэт макро эдийн засгийн гол тоон мэдээллийн үнэн зөв байдлыг алдагдуулах, улмаар түүнд тулгуурлан боловсруулах бодлогын суурийг сулруулах эрсдэлтэй юм.

4.3. Санал, зөвлөмж

Дээрх дүгнэлтүүдтэй холбоотойгоор дараах зөвлөмжүүдийг дэвшүүлж байна.

1. Ковид-19 цар тахлын нөлөөгөөр нүүрсний салбарын үйл ажиллагаа ихээр доголдож, улмаар эдийн засгийн өсөлт саарсан энэ цаг үед нүүрс экспортлогчдын идэвхийг бууруулж буй жишиг үнэд үндэслэн АМНАТ тооцох аргачлалыг эргэн харж өөрчлөх нь нүүрс экспортлогчдын татварын дарамт, АМНАТ-ийн өр нэмэгдэх, татварын маргаан гүнзгийрэхээс сэргийлэх нэг гарц юм. Учир нь жишиг үнийн өсөлтөд тээврийн зардлын гэнэтийн огцом өсөлт голлон нөлөөлж байгаа нь тодорхой. Иймээс нүүрс экспортлогчдын борлуулалтын бодит орлого өсөөгүй байхад үүнд ногдуулах татвар огцом өсвөл нүүрс олборлогчид үйл ажиллагаагаа зогсоох, улмаар улсын төсөв, ажил эрхлэлт, эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй.
2. АМНАТ ногдуулах борлуулалтын үнэлгээ тооцоход жишиг үнэ тооцож буй одоогийн журмыг өөрчлөн гэрээний үнэд суурилах, эсвэл жишиг үнэ тооцох аргыг бодит байдалд нийцэхүйц болгож өөрчлөх. Журмыг гэрээний үнэ суурьтай болгож өөрчлөх нь татвар тооцох талаасаа хамгийн энгийн, чирэгдэл багатай шийдэл юм. Сонгосон орнуудаас Австрали, БНХАУ зэрэг улс гэрээний үнийг суурь үнэ болгон ашиглаж байна.
3. Хэрвээ жишиг үнийг АМНАТ ногдуулах борлуулалтын үнэлгээ тооцох суурь болгож ашиглах тохиолдолд нүүрсний суурь үнийг зарлах ба нүүрсний нэр төрлийн нарийвчилсан ангилал тус бүрд баримтлах жишиг үнийг тусгай томъёогоор тооцдог (Индонез улсын жишгээр) байх нь тохиромжтой. Учир нь цөөн төрлийн нүүрсний жишиг үнэ зарласан тохиолдолд чанар багатай нүүрсний борлуулалт зогсоход хүрнэ. Жишиг үнэ тооцдог томъёо нь нүүрсний чанарын үзүүлэлтүүд (илчлэг, үнслэг, хүхэр, чийгшил) ба жишиг үнийн хоорондын шууд хамаарлыг тусгасан байх шаардлагатай. Индонез улсад баримталдаг жишиг үнэ тооцох томъёо эрчим хүчний нүүрсэнд илүү тохиромжтой бол коксжих нүүрсний хувьд баримтлах томъёог Platts-ийн жишгээр тооцож болох юм. Энэ тохиолдолд нүүрсний ангилал стандартыг Монголын нүүрсний чанар, олон улсын жишигт нийцүүлэн нарийвчлан тодорхойлох шаардлагатай болно.
4. Хэрвээ жишиг үнийг АМНАТ ногдуулах борлуулалтын үнэлгээ тооцох суурь болгож ашиглах тохиолдолд жишиг үнэд нүүрс экспортлогчийн хариуцах ёсгүй нэмэгдэл өртгийг хасаж өөрчлөх нь татварын тогтолцооны шударга байх зарчимд нийцнэ. Тухайлбал, ЗГ-ын 2021 оны 174-р тогтоолоос хойш мөрдөж байгаа журмаар тооцох нүүрсний жишиг үнэд БНХАУ-ын НӨАТ-аас бусад татвар, боомтын зардлууд, дундын зуучлагч компаниудын ашиг шингэсэн байгааг хасаж тооцох шаардлагатай.
5. АМНАТ тооцох жишиг үнэ ба борлуулалтын гэрээний үнийн зөрүүг голлон үүсгэж байгаа тээврийн зардлыг бууруулах зохион байгуулалтын арга хэмжээг авах. Энэ нь ялангуяа Тавантолгой – Гашуунсухайтын нүүрсний тээвэрлэлтийг хийж буй тээвэр зуучийн олон компаниудын үйл ажиллагааг нэгтгэн зохион байгуулж, үр ашиггүй өрсөлдөөний зардлыг хэмнэх, авилгыг бууруулах ач холбогдолтой. Ингэснээр нүүрс экспортлогчдын ба улсын төсвийн орлого нэмэгдэх, Монголын нүүрсний өртөг буурч өрсөлдөх чадвар нь нэмэгдэх боломжтой.
6. Нүүрс экспортлогчдын борлуулалтын гэрээг аль болох экспортын гааль хүргэх нөхцөлөөр (FCA, CIF, DAP) байгуулах нь жишиг үнэ ба гэрээний үнийн зөрүүг бууруулах нэг арга байж болох юм. Одоогоор нүүрс экспортлогчид ихэвчлэн “уурхайн ам” EXW нөхцөлөөр гэрээ байгуулдаг бөгөөд тээврийн зардлын өсөлт экспортлогчдоос үл шалтгаалдаг. Нүүрс экспортлогчид хилийн боомт хүртэлх тээвэрлэлтийг хариуцах нь өөрсдөө тээврийн зардлаа бууруулах, оновчтой зохион байгуулалтад орох хөшүүрэг байж болох юм.

7. Экспортолсон, экспортлохоор ачуулсан нүүрсэнд АМНАТ ногдуулах борлуулалтын үнэлгээг тооцоход үндэслэж буй жишиг үнийг хэрхэн тооцож буй аргачлалыг ил тод, нээлттэй болгох. Хэдийгээр ЗГ-ын тогтоолуудаар нүүрсний борлуулалтын үнэлгээний үндэслэл болгох эх сурвалжийг БНХАУ-ын <http://en.sxcoal.com> цахим хуудас байхаар заасан боловч зарласан жишиг үнийн мэдээлэл нэлээд зөрүүтэй, тогтворгүй байгаа юм.
8. Жишиг үнэ тогтоох ажлын хэсэгт нүүрс олборлогчид болон уул уурхайн салбарын төлөөллийг хангалттай оролцуулж, ил тод байх, хариуцлагатай байх, оролцоог хангах зарчмыг баримтлах
9. АМНАТ ногдуулахтай холбоотой бодлого, журмыг тогтвортой мөрдөх. Ашигт малтмалын тухай хууль шинэчлэгдэн батлагдсанаас хойш буюу 2007 оны ЗГ-ын 88-р тогтоолоор АМНАТ ногдуулах борлуулалтын үнэлгээг тооцох анхны журам баталснаас хойш уг журамд эргэж буцсан маш олон удаагийн өөрчлөлт орсон.
10. Уул уурхайн бирж байгуулахтай уялдуулан АМНАТ ногдуулах борлуулалтын үнэлгээ тооцох асуудлыг хэрхэн зохицуулах талаар хэлэлцүүлэг, тооцоо судалгаа хийх шаардлагатай. Тус биржийг байгуулснаар нүүрсний борлуулалтын гэрээ ил тод, нэгдсэн стандарттай болж, АМНАТ ногдуулах борлуулалтын үнэлгээг тооцоход хялбар болох давуу талтай. Гэхдээ бирж байгуулагдаж, холбогдох институц нь бүрдэж, үйл ажиллагаа нь жигдрэх хүртэл ихээхэн хугацаа шаардагдаж болзошгүйг анхаарах хэрэгтэй.
11. Уул уурхайн салбарт, улмаар нийт эдийн засагт татварын бодлогын үзүүлэх нөлөөллийн суурь тоон загвар боловсруулах. Ийм загвар боловсруулснаар татварын оновчтой хувь хэмжээ, жишээ нь АМНАТ-ийн суурь ба өсөн нэмэгдэх хувь, үнийн босгуудыг шинжлэх ухааны үндэслэлтэй тогтоох, татварын бодлогын янз бүрийн өөрчлөлт салбарт ямар хэмжээний шууд ба шууд бус нөлөөлөл үзүүлэхийг олон төрлийн хувилбараар симуляц шинжилгээгээр урьдчилан тодорхойлох боломж бүрдэнэ.

Судалгаанд ашигласан эх сурвалж

Харьцуулсан судалгаанд ашигласан эх сурвалжууд

Австрали

- Department of Industry, Science, Energy, and Resources of Australia, Recourses and Energy Quarterly,, December 2021 <https://publications.industry.gov.au/publications/resourcesandenergyquarterlydecember2021/documents/Resources-and-Energy-Quarterly-December-2021.pdf>
- Australian Financial Review, Signs of thaw in China's ban on Australian coal,, <https://www.afr.com/world/asia/signs-of-thaw-in-china-s-ban-on-australia-coal-20211124-p59bue#:~:text=Australia%20exported%2013%20million%20tonnes,25%20million%20tonnes%20a%20month>
- Minerals Council of Australia, Estimates of royalties and company tax paid by the minerals sector, Deloitte, May 2021
- Australian Government, <https://www.australia.gov.au/>
- Lexology, Mining in Australia, July 2018, <https://www.lexology.com/library/detail.aspx?g=e44f47fc-0ce6-4c8f-a90b-e0913b084d29>
- Department of Mines and Petroleum of Australia, Mineral royalty rate analysis stakeholder consultation paper, https://www.jtsi.wa.gov.au/docs/default-source/default-document-library/mrra_stakeholder_consultation_paper_2013.pdf?sfvrsn=3c746b1c_5
- The Association of Mining and Exploration Companies, Mining and Petroleum Legislation Amendment Bill 2021, <https://secureservercdn.net/198.71.233.189/0h5.0cf.myftpupload.com/wp-content/uploads/2022/02/Submission-to-the-Department-of-Regional-NSW-Mining-Exploration-and-Geoscience-re-Mining-and-Petroleum-Legislation-Amendment-Bill-2021.pdf>
- Dr Jack Mintz, University of Calgary, Tax Facts https://www.minerals.org.au/sites/default/files/Tax%20Facts_%20October%202019.pdf
- Mineral Royalty Amendment Bill 2021-North Territory, <https://treasury.nt.gov.au/dtf/territory-revenue-office/whats-new/mineral-royalty-amendment-bill-2021>
- South Australian Legislation, [https://www.legislation.sa.gov.au/lz/path=%2FV%2FP%2F2005%2FMINING%20\(ROYALTY\)%20AMENDMENT%20ACT%20\(COMMENCEMENT\)%20PROCLAMATION%202005_18.8.2005%20P%203058](https://www.legislation.sa.gov.au/lz/path=%2FV%2FP%2F2005%2FMINING%20(ROYALTY)%20AMENDMENT%20ACT%20(COMMENCEMENT)%20PROCLAMATION%202005_18.8.2005%20P%203058)
- Royalty Legislation Amendment Bill- 2020 <https://documents.parliament.qld.gov.au/tableOffice/TabledPapers /2020/5620T1194.pdf>
- Government of Western Australia <https://www.wa.gov.au/>
- Government of New South Wales <https://www.nsw.gov.au/>
- Government of Queensland <https://www.qld.gov.au/>
- Government of North Territory <https://nt.gov.au/>
- PwC Tax Summaries, <https://taxsummaries.pwc.com/australia/corporate/other-taxes>
- Australian Taxation Office, <https://www.ato.gov.au/Business/International-tax-for-business/In-detail/Doing-business-overseas/Exporting-goods-or-services-overseas---what-you-need-to-know/>

Индонез

- International Trade Center: trademap.org
- PWC. (2019). Mining in Indonesia: Investment and Taxation Guide
- PWC (2016). Mining in Indonesia: Investment and Taxation Guide
- Mining Business Activities GR 23/2010: <https://peraturan.bpk.go.id/Home/Details/5031/pp-no-23-tahun-2010>
- Royalty rates GR 81/2019: <https://peraturan.bpk.go.id/Home/Details/126145/pp-no-81-tahun-2019>
- Индонезийн эрчим хүч, ашигт малтмалын яам: <https://www.minerba.esdm.go.id/>
- Bourassa , J. M., & Lacy, A. (2020). Mining 2020 . London Business Research Ltd.

- Mendrofa, A., & Pramashwara, S. (2021, September 13). ICLG. Retrieved from ICLG.com: <https://iclg.com/practice-areas/mining-laws-and-regulations/indonesia#:~:text=Mining%20rights%20in%20Indonesia%20principally,%E2%80%9CProduction%20Operation%20IUP%E2%80%9D>.
- Reyes, d. A. (2020, June 2). Argus. Retrieved from argusmedia.com: **Error! Hyperlink reference not valid.**
- Mining Law No. 4/2009: <https://peraturan.bpk.go.id/Home/Details/38578/uu-no-4-tahun-2009>
- Mining Law Amendment 3/2020: <https://peraturan.bpk.go.id/Home/Details/138909/uu-no-3-tahun-2020>
- APBI. (2020, July 9). APBI ICMA. Retrieved from apbi-icma.org: <http://www.apbi-icma.org/news/3264/regarding-the-request-for-relaxation-of-the-royalty-payment-system>

Оросын Холбооны Улс

- Үнэт металл, үнэт чулууны тухай хууль, <http://pravo.gov.ru/proxy/ips/?docbody=&nd=102052228>
- Бүтээгдэхүүн хуваах гэрээний тухай хууль, <http://pravo.gov.ru/proxy/ips/?docbody=&nd=102038941>
- Газрын хэвлийн тухай хууль, <http://pravo.gov.ru/proxy/ips/?docbody=&nd=102014778&rdk=>
- ОХУ-ын эх газрын тухай хууль, <http://pravo.gov.ru/proxy/ips/?docbody=&nd=102038488>
- Улс орны батлан хамгаалах, төрийн аюулгүй байдлыг хангах стратегийн ач холбогдол бүхий аж ахуйн нэгжид гадаадын хөрөнгө оруулалт хийх журмын тухай" хууль (стратегийн хөрөнгө оруулалтын тухай хууль), <http://pravo.gov.ru/proxy/ips/?docbody=&nd=102121606>
- Татварын хууль, <http://pravo.gov.ru/proxy/ips/?docbody=&nd=102054722>
- Global mining guide, Russia, Baker Mckenzie, [https://resourcehub.bakermckenzie.com/en/resources/global-mining-guide/emea/russia/topics/global-mining-guide#:~:text=The%20principal%20law%20regulating%20the,\(%22Subsoil%20Law%22\)&text=The%20Precious%20Metals%20Law%20provides,of%20precious%20metals%20and%20gems%20tones](https://resourcehub.bakermckenzie.com/en/resources/global-mining-guide/emea/russia/topics/global-mining-guide#:~:text=The%20principal%20law%20regulating%20the,(%22Subsoil%20Law%22)&text=The%20Precious%20Metals%20Law%20provides,of%20precious%20metals%20and%20gems%20tones).
- [https://uk.practicallaw.thomsonreuters.com/Document/I7d91d26fbb4311e79bef99c0ee06c731/View/FULLText.html?transitionType=SearchItem&contextData=\(sc.Search\)&firstPage=true#co_anchor_a762060](https://uk.practicallaw.thomsonreuters.com/Document/I7d91d26fbb4311e79bef99c0ee06c731/View/FULLText.html?transitionType=SearchItem&contextData=(sc.Search)&firstPage=true#co_anchor_a762060)
- ОХУ-ын Эрчим хүчний яам, <https://minenergo.gov.ru/activity/statistic>
- ОХУ-ын Татварын алба, <https://www.nalog.gov.ru/rn77/taxation/taxes/ndpi/>
- <https://www.nalog.gov.ru/rn77/taxation/taxes/ndpi/kd/>
- ОХУ-ын статистикийн хороо <https://rosstat.gov.ru/>
- Yuliyam Fedorinova, Aine Quinn, (May 30, 2021), Bloomberg, <https://www.bloomberg.com/news/articles/2021-05-30/russia-to-modernize-railroads-for-coal-exports?sref=Uk5xAhoO>
- Russian coal sector, (March 2021), United Nations Economic Commission for Europe, <https://unece.org/sites/default/files/2021-03/Russian%20Energy%20Transition%20%28coal%20sector%20overview%29.pdf>
- United Nations Statistics Division, <http://data.un.org/Data.aspx?d=EDATA&f=cmID%3aCC>
- A Guide to Russia's Resources, Geohistory, <https://geohistory.today/resource-extraction-export-russia/>
- "Уул уурхайн үйлдвэр" сэтгүүл №6 (118) 2014, 18 -р хуудас
- Russia mulls mounting tax burden on metallurgy (2021), Argus Media Group, <https://www.argusmedia.com/en/news/2256078-russia-mulls-mounting-tax-burden-on-metallurgy>
- The Coal Hub (2020), <https://thecoalhub.com/russian-ministry-of-finance-to-reject-progressive-coal-extraction-tax.html>

БНХАУ

- Announcement No. 32 [2020] of the Ministry of Finance and the State Administration of Taxation http://szs.mof.gov.cn/zhengcefabu/202007/t20200703_3543287.htm
- Interpretation of the Announcement of the State Administration of Taxation on Several Issues Concerning the Collection and Administration of Resource Tax http://www.gov.cn/zhengce/2020-08/31/content_5538850.htm
- Announcement No. 34 (2020) of the State Taxation Administration on "Several Issues Concerning the Collection and Management of Resource Tax" http://szs.mof.gov.cn/zhengcefabu/202007/t20200703_3543290.htm

- Announcement of the Inner Mongolia Autonomous Region Taxation Bureau of the State Administration of Taxation on Determining the Taxable Price Cost Profit Ratio
<http://zwgk.kailu.gov.cn/klxzwgk/zw.aspx?xxid=8902&tdml=2&dwid=27>
- "Announcement of the Hainan Provincial Taxation Bureau of the State Administration of Taxation on Determining the Cost-Profit Rate of the Resource Tax Composition of the Taxable Price (Draft for Comment)" for comments
http://hainan.chinatax.gov.cn/gzcy_5_1/24128645.html
- Announcement No. 14 [2020] of the State Administration of Taxation on Several Issues Concerning the Collection and Administration of Resource Tax
<http://www.chinatax.gov.cn/chinatax/n364/c5156066/content.html>
- Measures for the Implementation of the Ad valorem Calculation and Collection of Coal Resource Tax in Inner Mongolia Autonomous Region
<http://extwprlegs1.fao.org/docs/pdf/chn148949.pdf>
- Coal output data, Үндэсний статистикийн газар
- Statistical Review of World Energy, BP Plc
<https://www.bp.com/en/global/corporate/energy-economics/statistical-review-of-world-energy.html>
- China Mineral Resources Report 2021, Байгалийн нөөцийн яам
- 自然资源部关于推进矿产资源管理改革若干事项的意见（试行）(Opinion on Promoting the Reform of Mineral Resource Management (Trial Implementation))
http://gi.mnr.gov.cn/202001/t20200109_2497042.html
- International Comparative Legal Guides. Mining Law 2020. 7th edition.
https://www.acc.com/sites/default/files/resources/upload/ML20_E-edition.pdf
- Thomson Reuters Practical Law: Mining in China Overview
[https://uk.practicallaw.thomsonreuters.com/w-011-1348?transitionType=Default&contextData=\(sc.Default\)&firstPage=true#co_anchor_a558468](https://uk.practicallaw.thomsonreuters.com/w-011-1348?transitionType=Default&contextData=(sc.Default)&firstPage=true#co_anchor_a558468)
- 矿产资源法修订草案（征求意见稿）公开征求意见 (Mineral Resources Law draft amendment)
<http://www.npc.gov.cn/npc/c30834/201912/2671cca9197b4eee868dcc9088e1ffc8.shtml>
- 财政部 国土资源部关于印发《矿业权出让收益征收管理暂行办法》的通知 (Interim Administrative Measures for the Collection of Mineral Royalties for Assignment of Mining Rights)
http://www.gd.gov.cn/zwgk/wjk/zcfgk/content/post_2521586.html
- 中华人民共和国资源税法 (Resource Tax Law)
<https://mp.weixin.qq.com/s/fP5tgU3EAXDO7cCiFE6yEQ>
- Decision of the Standing Committee of the People's Congress of the Inner Mongolia Autonomous Region on matters authorized by the tax law such as the applicable tax rate for mineral resources tax of the Inner Mongolia Autonomous Region
https://www.nmg.gov.cn/zwyw/jrgz/202007/t20200726_247440.html
- Decision of the Standing Committee of the Guangdong Provincial People's Congress on Matters such as the Specific Applicable Rates of the Guangdong Provincial Resource Tax
http://czt.gd.gov.cn/czfg/content/post_3055821.html
- Decision of the Standing Committee of the People's Congress of Xinjiang Uygur Autonomous Region on the Specific Applicable Rates, Calculation and Collection Methods, and Tax Reduction and Exemption Methods of the Autonomous Region's Resource Tax
<http://www.xjpcsc.gov.cn/article/939/lfgz.html>
- Explanation on the "Resource Tax Law of the People's Republic of China (Draft)
<http://www.npc.gov.cn/npc/c30834/201908/4f6e6560cd13496aae74cd1dc2ae7841.shtml>
- Resource Tax Law of the People's Republic of China
https://english.mee.gov.cn/Resources/laws/envir_elatedlaws/202011/t20201113_807794.shtml
- Research on the Reform and Perfection of Resource Tax System
<https://www.scirp.org/journal/paperinformation.aspx?paperid=107943>